



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-17
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	18-114

1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	15-28
2“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	28-100
3.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл	100-104
4.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд	104-108
5.Батлагдсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга сонсох	108-111
6Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа	111-119

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 72 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 09 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Бум-Очир, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Ч.Номин, Ц.Сандаг-Очир, Х.Тэмүүжин;

Чөлөөтэй: Х.Баттулга, Ж.Баярмаа, П.Ганзориг, Х.Ганхуяа, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу, П.Мөнхтулга, Г.Уянгахишиг, Г.Хосбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батжаргал, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, Б.Түвшин, Б.Чойжилсүрэн;

Хоцорсон: С.Амарсайхан-02 минут, Ц.Баатархүү-33 минут, М.Бадамсүрэн-19 минут, Б.Батбаатар-16 минут, Р.Батболд-01 минут, Н.Батсүмбэрэл-37 минут, Б.Батцэцэг-02 минут, Ж.Бат-Эрдэнэ-10 минут, А.Ганбаатар-01 минут, Г.Ганбаатар-03 минут, С.Ганбаатар-08 минут, Б.Дэлгэрсайхан-08 минут, Б.Жавхлан-01 минут, Б.Жаргалан-59 минут, Ц.Мөнхтуяа-06 минут, З.Мэндсайхан-27 минут, Б.Пунсалмаа-05 минут, Д.Пүрэвдаваа-05 минут, Г.Тэмүүлэн-11 минут, А.Ундраа-55 минут, Д.Цогтбаатар-10 минут, Ж.Энхбаяр-1 цаг 33 минут, Д.Энхтуяа-04 минут, Р.Эрдэнэбүрэн-23 минут.

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, төр нийгмийн нэрт зүтгэлтэн Пунсалмаагийн Очирбат таалал төгссөнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх орон даяар гашуудал зарлах зарлиг гаргасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн өглөөний 07:00 цагаас 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд танхимын хойд талд байрлах төрийн далбааг ишний гуравны хоёрт хүртэл буулгасан байв.

Нэг.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, мөн газрын референт Д.Нямдэлгэр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого,

зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ц.Мөнхбат, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 10 цаг 18 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 25
Бүгд: 95
73.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: 2.Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 24
Бүгд: 95
74.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 27

Бүгд: 95

71.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 24

Бүгд: 95

74.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 28

Бүгд: 95

70.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 24

Бүгд: 95

74.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 91

Бүгд: 95

4.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул “Хууль санаачлагчид буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Хууль санаачлагчид буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав./10:50/

8.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 31
Бүгд: 95

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 28
Бүгд: 95

70.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 26
Бүгд: 95

72.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 32
Бүгд: 95

66.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитекторын Ажлын албаны дарга А.Баттөмөр, мөн газрын ахлах мэргэжилтэн Ц.Мягмарсүрэн, хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал, “Хот төлөвлөлт, судалгааны институт”-ийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн дарга Р.Амартүвшин, мөн институтийн Зам, тээвэр судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Анхбаяр, Дэд бүтцийн хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Захиргаа менежментийн хэлтсийн дарга Х.Мөнхнаран, ерөнхий менежер О.Одбаяр, Л.Эрдэнэбат, зөвлөх архитектор Л.Ганбат, Байгаль орчны зөвлөх З.Батжаргал, Эдийн засагч П.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 11 цаг 35 минутаас 14 цаг 08 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 09 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Ч.Ундрэм, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, С.Эрдэнэбат, Ө.Шижир, Л.Соронзонболд, Б.Мөнхсоёл, Ц.Идэрбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Ж.Чинбүрэн, Б.Уянга, С.Эрдэнэбат, Г.Лувсанжамц, Ж.Галбадрах, Х.Булгантуяа, А.Ганбаатар, Б.Пунсалмаа, Ж.Бат-Эрдэнэ, Б.Батбаатар, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 14 цаг 57 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ц.Баатархүү нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 35
Бүгд: 98

64.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Хэрлэн, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ц.Баатархүү нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 51
Бүгд: 98

48.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 44
Бүгд: 98
55.1 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, мөн газрын референт Д.Нямдэлгэр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр, Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 41
Бүгд: 98
58.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 33
Бүгд: 98
66.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 36
Бүгд: 98
63.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 32
Бүгд: 98
67.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 29
Бүгд: 98
70.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 27

Бүгд: 98

72.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 28

Бүгд: 98

71.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 28

Бүгд: 98

71.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

6.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 25

Бүгд: 98

74.5 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

7.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 28

Бүгд: 98

71.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

8.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70

Татгалзсан: 28

Бүгд: 98

71.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

9.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 27
Бүгд: 98

72.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

10.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 25
Бүгд: 98

74.5 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Батлагдсан хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

2.“Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

3.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:29/

4.“Монгол Улсын Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн

найруулгатай танилцлаа./15:30/

5.Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

6.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:30/

7“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

8.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

9.“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

10.Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:31/

Дагалдан гарсан:

11.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг эцсийн найруулгатай холбогдуулан санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:32/

12.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:34/

13.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:34/

14.“Хархорум” хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:34/

15.“Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:35/

16.“Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:35/

17.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:35/

18.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:35/

19.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:36/

20.“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:36/

21.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:36/

Хамт өргөн мэдүүлсэн:

22.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн

найруулгатай танилцлаа./15:36/

23.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:37/

24.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./15:37/

25.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:37/

26.“Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:37/

27.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:38/

28.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:38/

29.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:38/

30.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:38/

31.“Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:38/

Зургаа.Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы

хаалтын ажиллагаа

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга бөгөөд зөвлөх Т.Төрболд, зөвлөх Р.Алтангэрэл, Н.Отгончимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Б.Батчимэг, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд босож хүндэтгэл үзүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 53 минут үргэлжилж, 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 09 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн баасан гаргийн чуулганы хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Ирц 126-аас 72 57.1 хувьтай байна. Өнөөдрийн чуулганаар нийтдээ 6 асуудал хэлэлцэхээр байгаа.

Нэгдүгээрт, шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Мөн 2 дугаарт Нийслэл Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Гуравт, Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж,

Дөрөвт, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Тавд, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсож,

Зургаад, Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хаалт явагдахаар байгаа.

Ингээд эхний асуудалд оръё.

Шинэ Зуунмодын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Жамбын Батсуурь танилцуулна.

Индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг баталж мөн өдрийн хот байгуулах тухай Улсын Их Хурлын 76 дугаар тогтоолоор шинэ Зуунмод хотыг байгуулж нийслэлийн Тусгай чиг үүрэг гүйцэтгэх стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байхаар заасан. Шинэ Зуунмод хот дагуул хотыг байгуулснаар Улаанбаатар хотын төвлөрөл тодорхой хувиар буурахаас гадна Богд Хаан төмөр зам, чөлөөт бүс, тээвэр ложистикийн төв болж Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 10-аас 15 хувиар тэлэх боломжтой гэж үзэж байгаа юм. Мөн энэ хотод төр захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолбор байрлах бөгөөд олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын дээд түвшний уулзалт, арга хэмжээ зохион байгуулах цогцолбор байгуулж, үйлчилгээний менежмент аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгохоор зорьж байгаа юм аа.

Иймд хотын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд тус төслийг олон улсын түвшинд хөрөнгө оруулалтыг татах тохиромжтой нөхцөлөөр танилцуулах цаашид дэлхийд танигдсан хот болгон хөгжүүлэхэд хотын нэр чухал үүрэгтэй байгаа юм аа. Олон улсын туршлагаас үзэхэд хотын нэрийг тухайн улс орны талаарх төсөөллийг бий болгох соёлын өв түүхийг онцолсон төдийгүй санхүү, бизнес, аялал жуулчлалын төв, ухаалаг хот байх зэрэг нөхцөлийг илэрхийлж, олон улсад дуудах, бичихэд хялбар, ойлгомжтой байдлаар тогтоох нь цаашид маркетинг сурталчилгааны стратегийн өргөн хүрээнд төлөвлөх боломжийг бүрдүүлэн бүрдүүлэхээр байна. Өөрөөр хэлбэл хотын оноосон нэр, түүх, соёл, байгаль орчин, эдийн засгийн чадамж гэх мэт тухайн хотын бусдаас ялгарах онцлог мөн улс орны хөгжил олон улсын хэмжээнд ямар нэмэр ямар хувь нэмэр оруулах зэрэг хотын хөгжлийн зорилго, ирээдүйн байр суурийг бүрэн илэрхийлэх боломжтой байх нь тус бүтээн байгуулалтад олон улсын хөрөнгө оруулалтыг татах олон талт түншлэл дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.

Гэтэл Шинэ Зуунмод гэх нэршил нь Төв аймаг буюу Зуунмод хотын дагуул хот эсвэл Зуунмод хотыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт гэсэн зөрүү ойлголтыг төрүүлж байгаа юм аа. Иймд шинэ хот байгуулах энэхүү төслийг олон улсын түвшинд хөрөнгө оруулалт татахад тохиромжтой нөхцөлөөр танилцуулах, цаашид дэлхийд танигдсан хот болгон хөгжүүлэх зорилгоор шинэ Зуунмод хот гэсэн оноосон нэрийг өөрчлөх шаардлага үүссэн болно оо.

Монголчууд эртнээс төрт ёсны түүхтэй дэлхий дахинд нэр алдар нь түгсэн эзэнт гүрнүүдийн өлгий нутаг бөгөөд Хүннү нар Төв Азийн тал нутагт төрийн зохион байгуулалттай хүчирхэг нүүдэлчдийн төрт улсыг үүсгэн олон улсын харилцаа Торгоны замыг хяналтдаа авч Европ Азийн түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээсэн байдаг аа. Тиймээс Монгол Улсын талаар төдийгүй, шинэ хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, төслийн зорилтыг цогц байдлаар илэрхийлэх зорилгоор шинэ Зуунмод хотыг Хүннү хот гэж нэрлэн Монгол Улсынхаа төрт ёс түүх, уламжлал, соёлыг, олон улсад илэрхийлэн таниулах цаашлаад олон улсын чиг хандлагад нийцсэн ухаалаг хот болгон хөгжүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан болно. Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт энэхүү хотыг Хөшигийн хөндийд байгуулагдсан Чингис Хаан олон улсын нисэх буудлыг түшиглэн Монгол Улсын тээвэр ложистикийн гол төв байхаар төлөвлөж цаашид Зүүн Хойд Азийн зорчигч агаарын тээврийн нэгдсэн зангилгаа Төв болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Иймд дээрх зорилтод нийцүүлэн амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх зорилго олон улсын чиг хандлагыг харгалзан шинэ Зуунмод хотыг Хүннү хот гэж нэрлэх нь уламжлал шинэчлэлийг хослуулсан томъёолол хэмээн тодорхойлж байна аа. Хүннү хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хотын хувьд нийт хүн амын дийлэнх хэсгийн амьдрах, оршин суух нөхцөлийг бүрдүүлэх Улаанбаатар хотод ирж байгаа ачаалал, төвлөрлийг задалж, суурьшлыг тэнцвэржүүлэх зам тээврийн ложистикийн үйлчилгээг бий болгох, дэд бүтцийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн бие даасан байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний аюулгүй байдал, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох буюу улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэх болно оо.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр өргөн барьж байна аа. Та бүхэн хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ө.Шижир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.35 дугаар зүйлийг баримтлан яаралтай хэлэлцүүлэх горимоор 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 сарын 5-ны өдөр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийг баталж, мөн өдөр Хот байгуулах тухай Улсын Их Хурлын 76 дугаар тогтоолоор шинэ Зуунмод хотыг нийслэлийн тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд Стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байхаар хуульчлан зохицуулсан.

Хууль санаачлагч уг хуулийн төслөөр хотын нэрийг соёлын өв түүхийг онцолж судалгаанд үндэслэн маркетинг сурталчилгааны стратегийг төлөвлөх ач холбогдолтой гэж үзэн Монгол Улсын талаар төдийгүй Шинэ хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, төслийн зорилтыг илэрхийлж чадах нэрийг Хүннү хот гэж тодорхойлж, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөлд иргэдийн оролцох оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын DParliament.mn цахим системд мөн байршуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдааны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Шинэ Зуунмод гэх нэршлийг Хүннү хот болгон өөрчлөхийн ач холбогдол нэрийн утга, агуулгын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэ Зуунмодын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, мөн Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсэг танилцуулья. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Цэгмэдийн Цэрэндорж ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга, Дамбын Нямдэлгэр ЗГХЭГ-ын референт, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хотын Бүтээн байгуулалт хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч, Бэгзсүрэнгийн Мөнх-Оргил Шадар сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе ээ.

Бид нар одоо Улаанбаатар хот руу 2040 он болтол 242 их наяд төгрөг хийнэ гэдэг. Тэгээд түүн дотроо зуу нэлээн гаран их наяд төгрөг нь улсын төсвөөс болон нийслэлийн төсвөөс орохоор ойлгогдож байгаа. Үлдсэн нь тэгээд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт байх. Гэхдээ одоо миний бодлоор бол одоо жишээлэхэд энэ Улаанбаатарт 140 ч байна уу, 240 ч байна уу их наяд төгрөг хийхийнхээ оронд энэ мөнгөөрөө бид нар энэ одоо Шинэ Хархорин хот эсвэл бусад аймаг нийслэлүүдээ төвлөрлийг сааруулж тийш нь тараан байршуулалт хийх бодлогоо хэрэгжүүлэхгүй юм бол энэ Улаанбаатар руу чинь бид нар дахиад хэдэн их наядыг ч хийгээд юу ч өөрчлөгдөхөөр ийм нөхцөл байдалд орчхоод байхад дахиад яагаад мөнгө үрнэ ээ

гэж тийшээ яваад байгаа юм. Бодлого үнэхээр надад бол нэг тийм ёстой муугаар хэлэхэд мунхаглал юм шиг л санагдаад байгаа юм. Тэгээд энэн дээр нэг ямархуу гарц байгаа болоод ийм нөхцөл байдал гаргаж ирж байгаа талаар нэг тайлбарлаж өгөөч ээ гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Энэ заалны микрофоныг нэмээрэй. Муу сонсогдож байна хариулт өгье. Нямбаатар дарга хариулах уу? Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Одоо бид нарын яг хэлэлцэж байгаа асуудал бол энэ шинэ Зуунмод хотын нэрийг Хүннү хот болгож өөрчлөхтэй холбоотой асуудал байгаа. Сая өөрийн чинь асуусан асуулт бол дараагийн хэлэлцэх асуудал буюу 2040-тэй холбоотой үндсэн асуудал учраас би 2040-ийг хэлэлцэх үед энэ асуултад дэлгэрэнгүй хариулт өгье өө.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Дарга асуулт давхцаж байгаа учраас шаардлагагүй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Цагаан өвгөний Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Шууд асууя. 2024 оны 6 сарын 5-ны өдөр Шинэ Зуунмод гээд Хотын эрх зүйн байдлын тухай хууль баталсан байна манай түрүүчийн парламентаар. Тэгээд өнөөдөр бол энэ хотынхоо нэрийг өөрчилж байгаа юм байна. Хүннү гэдэг нэртэй. Энэ одоо бас зарим нэг төөрөгдөл. Бас энэ ёс заншил, үндэс угсаа, түүх, соёл гээд олон юмтайгаа холиход бас ач холбогдолтой байж болох юм гэдэг ийм зүйл бас бодогдож байна. Тэгээд энэ Хүннү хот маань байршлын хувьд яг хаахна баригдах юм бэ? Энийг нэг тодруулж өгөөч ээ гэж асуумаар байна. Энэ өөрөө манай Улаанбаатар хотын дагуул хот болно гэж байна. Манай Улаанбаатар хот маань ер нь өөр дагуул хотууд бий болгох юм уу? Одоо тэр цаад талд нь Майдар гээд дагуул хот барина гээд л нэг төсөл явж байсан. Багануурыг, Налайхыг ч дагуул хот болгох юм шиг ингээд л яригдаж байсан. Тэгэхээр зэрэг энэн дээр өөр дагуул хотуудыг барих юм уу? Хэрвээ барих бол тусдаа эрх зүйн байдлын тухай хууль гаргаад явах юм уу? Эсвэл энэн дээр багтаад ингээд явдаг юм уу гэдэг нэг ийм зүйлийг тодруулж асуух байна. Ер нь энэ Хүннү хот маань ямар хэлбэрээр бий болох юм бэ? Энэ санхүүжилтийн хувьд юм уу төр хувийн хэвшил нь түншлэх юм уу одоо нөгөө Хархорин хот шигээ болох юм уу 2040 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх гэж байгаа тэр төлөвлөгөөнийхөө тэрэнтэйгээ ижил төстэй байх юм уу ямар хэмжээний санхүүжилтээр босох хот вэ гэдэг талаар арай илүү мэдээлэл өгөөч ээ гэж асуух гэсэн юм аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 18 дугаар микрофон. Хотын дарга Нямбаатар хариулт өгье. 2024 оны 5 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Улсын Их Хурлын тогтоол гарч хот тосгодыг шинээр байгуулах тухай тогтоол хавсралтаар батлагдсан. Энэ хүрээнд Улаанбаатар хотын одоогийн захын 2 дүүргийг улсын зэрэглэлтэй хот болгохоор шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл Налайх, Багануур дүүргүүдийг улсын зэрэглэлтэй 2 хот болгохоор төлөвлөсөн.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг дээр дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр 14 хот байгуулах ийм шийдвэр гарсан. Улаанбаатар хот

дагуул, Шинэ Зуунмод хот, Багахангай, Агро сити, Шарга морьт гэсэн ийм дагуул хотуудтай байхаар төлөвлөсөн. Үүнээсээ шинэ Зуунмод хот буюу одоо бидний нэрийг нь өөрчлөх гэж байгаа энэ хот бол анх удаагаа корпорацын зарчим дээр байгуулагдах хот болохоор хуульчлагдсан. Өөрөөр хэлбэл Төв аймгийн Алтанбулаг, Төв аймгийн Сэргэлэн сумдын нутгаас 33 мянган га талбайг авч энэ шинэ Зуунмод хотыг Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын орчмын энэ газар нутаг дээр байгуулахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар дэд бүтцийн ажлууд буюу хотын доторх дулаан, цахилгаан хангамж, цэвэр бохирын шугам сүлжээ татах ажлууд хийгдээд дуусаж байгаа. Нийслэл Улаанбаатар хот, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энэ хотын эрчим хүчний эх үүсвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хийх, тэр дундаа сэргээгдэх эрчим хүч буюу цэвэр эрчим хүчээр хийх төр хувийн хэвшлийн түншлэлийн тендерийг зарлах гэж байгаа.

Улаанбаатар хот тодорхой хөрөнгөө гаргаж цэвэрлэх байгууламжийн тендерийг энэ 3 дугаар сардаа багтаж тендерээ зарлана. ТЭЗҮ нь дууссан. Цаашид энэ Улаанбаатар хотын гол дагуул хот болох энэ ирээдүйд Хүннү гэж нэрлэгдэх энэ хотын 80 хувийг Улаанбаатар хот, 20 хувийг Төв аймаг эзэмшсэн. Ийм корпорацын зарчимтай явах ийм хот болгож бид нар төлөвлөн зохион байгуулж байгаа гэдгийг хэлье. Одоо дулаан хангамжтай холбоотой гео терма хайгуулын ажлыг бид нар 3 сард энэ Хөшгийн хөндийн орчим хийхээр ингээд төлөвлөөд явж байна аа. Ингээд энэ хотуудын дэд бүтцийн асуудал хийгдсэний дараа төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр бид нар 150 мянган хүний суурьшил бүхий аялал жуулчлал цаашлаад тээвэр ложистикийн ийм төвлөрсөн хот байхаар төлөвлөн зохион байгуулж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Хотыг энэ шинэ Зуунмод хотыг шинэчлэн байгуулах Монгол Улсын хөгжлийн стратегийн нэг том голомт байх төслийг бол 100 хувь дэмжиж байгаа. Гэхдээ энэ төсөл дээр нэг 2, 3 зүйл хэлэх гэсэн юм аа. Асуух гэсэн юм.

Нэгдүгээрт нь болохлоороо Хүннү гэдэг нэр яаж сонгогдоод байгаа юм бэ? Монгол Улсын хувьд анхны төрт ёсны суурь болсон гал голомт болсон тулгар төрийн анхны гүрэн улсын нэрийг нэг хотод ч гэх юм уу засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид нэр өгч болж байгаа юм уу. Бусад улсын жишгээр бол ийм юм байхгүй ээ. Хараарай би энийг нэлээн судалсан. Тэгэхээр анхны төрт улсынхаа нэрийг нэг аймгийн жишээлбэл нэр болгож болох юм уу? Нэг зарчмын хувьд.

Хоёрдугаарт Хүннү гэдэг чинь өөрөө бол Хүнчүүдийг Хятадаар нү гэдэг нь бол зэрлэгүүд гэсэн агуулгатай явж байгаа. Хүн зэрлэгүүд. Тэгээд бид нар нөгөө Ар Монгол, Гадаад Монгол эд нар гэдэг шиг этимологи буюу хэл зүйн хувьд Монгол хүн жишээлбэл гадаад Монгол, ар Монгол гэсэн хэллэгээ хэлчхэж болохгүй байхгүй юу. Яагаад гэхээр Монголчуудыг дорд үзсэн ч гэдэг юм уу хэмжээ хязгаар тогтоосон хэллэгүүд байдаг. Тэгэхээр энэ дээр яг энэ ШУА, хэлний чиглэлийн эрдэмтэд этимологийн түвшинд, хэл шинжлэлийн түвшинд тайлбар авсан юм уу? Энэ чиглэлээр бүүр тодорхой эрдэм шинжилгээний бүүр судалгаа хурал хийж явах ёстой шүү дээ. Тэгэнгүүтээ дараачийнх нь нэг зүйл нь Хархорин хот гээд бид нар Хархориум гэдэг нэршлээр явж байгаа. Тэгээд ер нь бол ард түмэн хөгжихийн тулд өнгөрсөн үеэ хүндэтгэн үзэх ёстойгоос гадна, ирээдүй рүүгээ чиглэсэн бодлого хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр нэгэнтээ Хархорин гээд байж байгаа юм чинь бүх юмыг заавал ингэж түүхчилж яах гээд байгаа юм бэ? Заавал Хүннү гэж нэрлэх шаардлага

байгаа юм уу, ирээдүй рүүгээ чиглэсэн нэр өгч болохгүй юм уу? Одоо энэ Арабын улсууд дэлхийн томоохон гүрнүүд эд нар дандаа ирээдүй рүү чиглэсэн нэртэй хотуудыг байгуулж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дэлхий нийтийн жишиг, дээрээс нь тэр татах хүчээ тооцвол яасан юм бэ? Тэр утгаараа бол энэ нэршлийн хувьд бол 2 үндэслэл гаргаж байгаа. Энэ үндэслэлд та бүхэн тайлбар өгөхгүй юу?

3 асуултаа дүгнээд хэлэхэд нэгд энэ анхны импайр буюу эзэнт гүрний нэрийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид өгч жижгэрүүлж яах гээд байгаа юм бэ? Түүхээ ингэж жижгэрүүлж яах гээд байгаа юм бэ? Улс үндэстнүүд түүхээ ингэж сунгаж татаж хол болгох гэж ядаж байхад бид нар эсрэгээр нь ийм үйлдэл хийж болох юм уу?

Хоёрдугаар асуулт нь ирээдүй рүү чиглэсэн нь хэр их боломжтой юм уу?

Гуравдугаар асуулт нь шинжлэх ухааны түвшинд хэл шинжлэл, тэр тусмаа үг зүйн язгуур гарвал судлалын хувьд энэ үгэн дээрээ тодорхойлолт авах ёстой юм биш үү гэдэг энэ 3 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Дараа нь ШУА-ийнхан хариулах байлгүй. Монгол Улсын Засгийн газрын хуралдаан дээр эдийн засгийг эрчимжүүлэх Улаанбаатар хотын тэлэлт суурьшлын бүсийг бий болгоход хамгийн их том үүрэг рольтой суурьшлын бүс хурдан үүсэх бүс бол одоогийн энэ Хөшигийн хөндий орчим буюу Улсын Их Хурлын 68 дугаар тогтоолоор шинэ Зуунмод хот гэж нэрлэсэн. Энэ хотыг нэрийг нь өөрчилье гэдэг ийм асуудал Засгийн газрын хуралдаан дээр яригдаад дэлхий дахинд Монголыг хамгийн их түүхийн хувьд урагшлуулж сурталчлан таниулах анхны төрт улсынхаа нэрээр нэрлэвэл яасан юм бэ гэдэг ийм зүйлүүд яригдаад тодорхой судалгаанууд хийгдсэний үндсэн дээр энэ нэршил рүү оръё оо гэдэг ийм санал санаачилга гарсан. Тухайлах юм бол Эдийн засаг хөгжлийн сайд Гантөмөр дарга энэ дээр ер нь бид нар энэ том эдийн засгийн бүс үүсгэхэд нэлээн тийм даацтай, далайцтай нэр байвал яадаг юм бэ гэдэг ийм санаачилгууд гараад энэ асуудал шийдэгдсэн. Тэр түүх сурвалж талаасаа ШУА-аас хариулт авсан нь зөв байх аа. Би бол хэлж мэдэхгүй байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Зуунмод хот гэдэг агуулгаар бид нар олон улсын концепцын уралдаан бас зарлах ийм бэлтгэл ажлыг хангаад мастер болон тэр неон гээд сүүлийн үеийн ухаалаг хотуудтай бас танилцаж ийм аялал хийсэн юм. Эрдэнэбүрэн сайд 20 минутын хотын сайдын хувьд бас хамт байсан. Шанхай хотын төлөвлөлттэй ч бас бид нар очиж нэлээдгүй танилцсан. Тэгэхээр яг энэ нэршлээр олон улсад концепцын уралдаан зарлах бол бас их боломж жоохон тааруу байгаад байгаа юм. Зуун ширхэг мод гэдэг ийм агуулгаар орчуулагдаад тэгээд тэрийгээ яаж тайлбарлах вэ гэдэг агуулгаар яг аймгийн төв гээд тайлбарлахаар яг ийм концепцын хувьд болж өгөхгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ агуулга дээр эртний эзэнт гүрний хаадууд түүхээ яг таны хэлж байгаагаар илүү тод томруун болгох тусам энэ өөрөө чухал гэдэг агуулгаараа Хүннү гэдэг нэрийг нийслэл Улаанбаатар хотыг тэлэх Хөшигийн хөндий хавийн 2 дахь том

дагуул хотын бүтээн байгуулалтаа нэрлэх нь зүйтэй юм байна аа. Энийг олон улсад тайлбарлах нь өөрөө илүү хялбар.

Эртний эзэнт гүрний түүхтэйгээ, одоо үетэй, ирээдүй үетэй бас ийм хоорондоо гинжин хэлхээний хувьд энэ бол их тийм чухал зүйл юм гээд. Ингээд археологичидтой бас уулзаж ярилцсан археологичдын хувьд ч гэсэн Хүннү хотын Хүннү улсын нийслэл бол өөрөө Луут гэдэг нэртэй хот байсан. Энэ нь өөрөө жишээлбэл лууны бэлгэдэл ч гэсэн энэ бол Монгол Улсын үндсэн бэлгэдэл байсан.

Тийм учраас аливаа асуудлуудыг ингэж гаргаж хот болон дагуул хотуудыг байгуулахдаа эртний түүхтэй холбоотой энэ асуудлуудаа гаргаж тавих нь бол төрт улс илүү урт удаан хугацаанд оршин тогтнох бэлгэдэл болох талаасаа энэ туйлын чухал юм аа. Хархорин хот гээд бид нар эрх зүйн орчин хийчихлээ. Хархорин хот гэдэг энэ үг бол одоо Пакистанд хүртэл гүүрний нэрээр байдаг. Гэтэл бид нар өөрсдөө Хүннү гэдэг энэ нэрээс бас одоо ингээд зугтах ч юм уу, Хүннү Монгол улсын бүрэлдэхүүн хэсэг юм уу байсан үгүй гэж хоорондоо мэтгэлцэх бол дэмий юм аа. Энэ агуулгаараа бид нар Хүннү гэдэг энэ нэршлээ хотынхоо нэршил болгоод ингээд явах нь туйлын чухал юм аа. Энэ маань одоо манай Төв аймгийнханд ч гэсэн бас илүү тийм бахархах бас чухал зүйл юм гэдэг агуулгаараа нийслэл Улаанбаатар хотын 2 дахь том хөрөнгө оруулалт төвийн бүс нутагт орно гэдэг агуулгаараа энэ өөрөө олон улсын концепц дээр ухаалаг ийм хот байх энэ агуулга нь Хүннү гэдэг нэртэй байх нь бол Зуунмод гэдэг хот нэртэй байхаас хамаагүй илүү давуу.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүн тодруулж асуух юм уу? Эрдэнэболд гишүүн тодруулж асуулт өгье.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайдын яг энэ зарчмын байр суурийг ойлгоод дэмжээд байгаа юм аа. Энэ миний асуулт нь жишээлбэл Монголын түүхийн хэсгээс байсан байгаагүй гэдэг, хасах ч гэдэг юм уу эс үгүй бол мэтгэлцээний тухай асуудал огт биш. Харин ч бид нар бол энэ Монголын түүхийн анхны эзэнт гүрний нэрийг ийм аймагт өгөх нь өөрөө зөв юм уу? Нэг.

Хоёрдугаарт түрүүн хэн хотын дарга бол ШУА хариулах байх гэсэн. Яг энэ нөгөө этимологи талын хэл зүй тал дээр юу гэдэг юм түрүүн тэргүүн Шадар сайд ийм санал гаргасан гээд та тэрийг нь дэмжиж үг хэлээд байна шүү дээ. Бид нар бол улс төрчид байхгүй юу. Шийдвэр гаргагч нар. Улс төрчид бол ингээд гоё санагдсан юмаа гоё тайлбарлаад ярьчихаж болно. Гэхдээ нөгөө цаад талд нь шинжлэх ухааны түвшинд энэ тайлбараа хадаж өгсөн юм уу? Энэ тайлбараа одоо энэ хэлэлцэх эсэх асуудал дээр эхнээсээ хүмүүст тайлбарлаад өгчихвөл амар байхгүй юу. Тэгэхгүй болохлоор нөгөө нэг ханзаар ингэж анх тэмдэглэгдсэн нү гэдэг дагавар нь ийм ийм байсан гээд маргаан дэгдээчхэж болохгүй. Энэ ач холбогдолгүй маргаан чинь яваад нөгөө төслийнхөө ач холбогдол руу шилжээд орчих юм бол хайран санагдана.

Д.Амарбаясгалан: ШУА-ийн Дэд Ерөнхийлөгч Цэгмэдийн Цэрэндорж Ажлын хэсгийн 20 дугаар микрофон хариулт өгье.

Ц.Цэрэндорж: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя аа. Ер нь аливаа улс үндэстнийг нэрлэдэг үндсэндээ 2 төрөл байдаг юм.

Нэгдүгээрт, тухайн үндэстэн өөрийгөө нэрлэдэг.

Хоёр дахь нь тухайн үндэстнийг хөрш зэргэлдээ ч юм уу, өөр улс үндэстнүүд нэрлэдэг ийм нэр. Тэгэхээр энэ Хүннү гэдэг нэрийн хувьд бол Хүннү бол яалт ч үгүй Хүннү гэж бидний нэрлээд байгаа энэ эзэнт гүрэн өөрсдийгөө нэрлэж байсан нэр. Гэхдээ харамсалтай нь ханз үсгээр энэ нь бид нар тэмдэглэгдэж ирсэн байгаа юм. Тэгэхдээ энэ бол ер нь Хятадын тийм түүхэн уламжлал байдаг. Одоо бол тэгдэггүй. Түүхэндээ эртнээс авхуулаад хөрш зэргэлдээ улс орнуудаа нэрлэхдээ мэдээж нү гэдэг дуудлагатай маш олон ханз байдаг. Гэхдээ тэр дотроос хамгийн тийм доромж утгатай ч гэдэг юм уу иймэрхүү нэр ханзыг нь сонгож аваад л нэрлэхдэг ийм тал бий. Жишээлбэл Монгол Улсын.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья.

Ц.Цэрэндорж: Монгол Улсын нэрийн мөнгү гэдгийн мөн гэдэг ч гэсэн их сонин утгатай ханз шүү дээ. Тийм учраас энэ Хятадууд манай төр улсын нэрийг ямар ханзаар тэмдэглэсэн бол бидний хувьд одоохондоо сонин биш. Харин энэ Хүннү гэдэг нэрийг сэргээх энэ оролдлогыг дотоод гадаадын олон эрдэмтэд хийж ирсэн. Ер нь хүн на, хүн но гэсэн иймэрхүү үг байсан байна гэдгийг сэргээж чадсан байгаа юм.

Тийм учраас бид нар энд Хятадуудын тэр өгсөн ханз хүн гэдгийн сөн ну гэдгийн тэр ханз дээр ач холбогдол өгөөд байх ямар ч шаардлагагүй гэж ингэж бодож байгаа. Нэмээд хэлэхэд энэ улс орны нэрээр нийслэл хотоо нэрлэдэг ийм тохиолдол бол гадаадад бас ер нь байдаг юм байна лээ. Жишээлбэл Мексик гэдэг юм уу эсвэл Бразил гэдэг юм уу бага зэрэг өөрчлөөд ингээд нэрлэхдээ. Миний ойлгож байгаагаар энэ бол орон нутгийн хотод өгөх гээд байгаа нэр биш. Нийслэл хотын нэг хэсэгт өгөх гээд байгаа нэр юм болов уу гэж ингэж бодож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газрын хуралдаан дээр энэ үгний талаар, нэршлийн талаар, тайлбарын талаар бас нэлээдгүй ярьсан юм. Тэгээд бидний хувьд бол яг бас ШУА-тай адилхан байр суурьтай байгаа Засгийн газрын хувьд. Бид гаднын аливаа нэгэн ханзанд ч юм уу дотооддоо хөтлөгдөж болохгүй. Одоо Чингис хааны нэр ч гэсэн Чингис гэдэг тэ? Бид бол Чингис гэдэг. Монгол л гэх юм бол Монголиа гэдэг. Монголс гэдэг газрууд бас байдаг. Бидний хувьд бол Монгол.

Тийм учраас гадаадын аль нэг байгууллага, аль улс, манай улсын түүхийг өөрсдөө ямар ханзаар тэмдэглэх яаж тайлбарлах тэдний асуудал. Харин Монголчууд бид өөрсдийнхөө түүхэнд итгэл үнэмшилтэй байх нь бидний асуудал энэ бол манай дотоод асуудал.

Тийм учраас бид түүхэндээ итгэл үнэмшилтэй байх ёстой. Түүхээ илүү тайлбарлах тусам бид нар удаан хугацаанд оршин тогтнох ёстой.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хууль тогтоолын төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ. Нэг гишүүн байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн. 1 дүгээр индрээс үг хэлнэ.

П.Сайнзориг: Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ бас нэр сольсон төдийгөөр бас энэ томоохон төслийг бас ач холбогдлын хувьд бас анхаарч битгий орхигдуулаасай л гэж хүсэж байгаа юм. Энэ шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын хуулийн цаана нь уг нь энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжиж Улаанбаатар, Төв аймаг хамтдаа хөгжих эдийн засгийн интеграцад орох энэ Улаанбаатар хотод тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө бас энэ хууль уг нь явж байгаа. Тэгэхдээ эргээд яах вэ зүгээр нэрийг солилоо гээд бас энэ зүйлүүд болчихгүй. Тэгэхээр би бас ерөнхийдөө ЗГХЭГ-ынханд бас юу гэж хандаж хэлж байгаа вэ гэхээр энэ шинэ Зуунмод хот буюу цаашдаа Хүннү гэж нэрлэгдэх хот дээр олон улсын санхүүгийн төв байгуулах асуудлыг яригддаг маш их хэмжээний томоохон дата төвүүдийг байгуулъя гэж байгаа. Энэ бол Монгол Улсын бас эдийн засагт томоохон нөлөө үзүүлэх Төв аймгийн хөгжилд бас нөлөө үзүүлэх ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр эдгээр асуудлуудын бас хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд бас яг энэнээр сольж байгаа шигээ адилхан бас ийм хурдтай оруулж ирээч ээ гэдэг зүйлийг хүсэж байгаа юм.

Дээрээс нь энэ дэд бүтцийн асуудал дээр үндсэндээ дулааны станц болон цэвэрлэх байгууламжийн асуудал яригдаж байгаа. Энийгээ одоо зайлшгүй бас энэ хавартаа шуурхай хийж чадвал бас их цааш цаашдын хөрөнгө оруулалтууд бас итгэлтэйгээр орж ирэх ийм нөхцөл байж байгаа. Тэгээд энэ Хүннү хот маань цаашдаа тээвэр ложистикийн зангилаа цэг болох бүрэн боломжтой хот байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол хажууд нь Хөшигтийн хөндий дээр шинэ Чингис хаан нисэх буудал маань байж байгаа авто тээврээр холбогдох бүрэн боломжтой. Ингээд цаашдаа төмөр замаараа холбогдох юм бол яг Монгол Улсын 3 төрлийн тээврээр холбогдсон ийм зангилаа эдийн засгийн хот болгох ийм бүрэн боломж байгаад байгаа юм аа.

Тэгэхээр энэ асуудлууд дээрээ бас анхаарал хандуулж эргээд бас энэ асуудлуудыг бас түргэн шуурхай шийдэх талд нь бас анхаарч өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Тэгээд би яах вэ зүгээр энэ дашрамд хэлэхэд энэ газар олголтоосоо эхлээд олон зүйлийг бас цэгцлэхийн төлөө явсан хот байгаа. Энэ дээр дур дураараа газрыг хувь гэдэг юм уу компаниудад өгчхөөд тэдгээр нь газрын бирж ажиллуулаад суудаг биш энэ хот маань өөрсдөө эргээд тодорхой төсөлд газар өгнө. Энэ дээр Таван одтой буудал барья. Энэ дээр битүү усан парк барья. Энэ дээр олон улсын хурал зөвлөгөөний конфренс холл барья ч гэдэг юм уу ийм зүйлүүдэд ингээд төсөл сонгон шалгаруулалтаар газраа өгнө. Корпорацын зарчмаар Улаанбаатар хот Төв аймагтайгаа хамтдаа хөгжих өнөөдөр Улаанбаатар хотын тулгамдсан асуудал дээр Төв аймагтайгаа л ярилцаж бас хамтдаа урагшлахаас өөр гарц байхгүй.

Тэгэхээр энэ концепцыг бэхжүүлэх чиглэлд нь бас цааш цаашдаа бас илүү их анхаарч хууль эрх зүйн орчны шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж яваач ээ. Тэгээд Засгийн газар бас энэ дээр бас санхүү хөрөнгө оруулалтын болон бусад бүх дэмжлэгээ үзүүлэхэд нь бас анхаарч ажиллаач ээ гэдэг зүйлийг хүсэж байгаа. Тэгээд энэ дашрамдаа бас Ерөнхий сайдыг байгаа дээр би бас хэлчихмээр байгаа юм. Үнэхээр энэ хотын нэрийг өөрчилж байгаа бол Хүннүгийн музей Хүннүгийн олдворуудаар археологийн олдворуудаар музейгээ байгуулах Хүннү судлалын төвөө байгуулна гэдгээ Засгийн газар зарлачих хэрэгтэй. Тэгээд Хүннүг түүхэн агуулга талаас нь бас маш олон улсууд л өөртэйгөө нааж байгаа. Тэгэхдээ яах вэ зүгээр хүссэн хүсээгүй бас түүхийн баримт гэдэг гэдэг юм гэдэг юм уу ийм зүйлээрээ бас Монголчууд бидэнтэй илүү их хамаатай юм гэдэг зүйл нь яригддаг энэ цаг үе

дээр яах вэ бас энэ зүйлийг бас орчин үедээ түүхийг хүүхэд залуучуудад таниулах Монголын түүхийг ч гэсэн дахиад нэг урагшлуулах. Энэнээсээ бид хэд бас брэнд болгож бас энэ хотынхоо хөгжлийг босгох энэ хотыг бүтээн байгуулахад бас түргэтгэх зорилгоор бас нэг ийм шинэ имиж гэх юм уу шинэ брэнд үүсгэж байгаад нь ерөнхийд нь дэмжиж байгаа юм. Тэгээд ерөнхийдөө бас энэ чиглэлд нь анхаараарай.

Ялангуяа би бас энэ дээр босож ирж байгаа нь олон улсын санхүүгийн төв байгууллага хууль эрх зүйн орчныг нэр сольж байгаа шигээ бас яаралтай оруулж ирээч ээ гэдэг зүйлийг л хэлэх гэж бас.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

1.Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт 73.7 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

3.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

Чуулганы хуралдаанд бага оролцож байгаа хүмүүсийн хурууны хээг таних нь багасаж байгаа Батчимэг гишүүнд зориулж хэллээ.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

74.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

74.7 хувиар санал дэмжигдлээ

7.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хууль санаачлагчийн зүгээс Жамбын Батсуурь сайд санал хэлнэ.

Ж.Батсуурь: Энэ тогтоолын нөгөө хот байгуулах тухай Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 сарын 7-ны 68 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг Шинэ Зуунмод гэснийг Хүннү гэж өөрчилсүгэй гэснийг 68 дугаар тогтоол дээр нь шинэ Зуунмод гэж байхгүй учраас Хүннү гэж өөрчлөх шаардлагагүй байгаа юм. Тийм учраас энийг дэмжихгүй байж өгнө үү гэж гишүүдээсээ хүсэж байгаа юм. Хэрвээ дэмжих юм бол байхгүй зүйл орж ирчих гээд байгаа юм аа.

Тийм учраас дэмжихгүй байж унагаж өгнө үү гэж хэлэх гэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тамгын газар яах юм. Энийг санал хурааж унагаах юм уу эс үгүй бол татчих юм уу? Татсан нь дээр биз дээ? Унагаах юм уу?

Санал хураалт.

Тогтоолын төсөл буцаах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол уншиж танилцуулъя.

Тийм 4.2 хувиар санал дэмжигдээгүй учраас тогтоолын төсөл буцаах тухай тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээуоа тул хууль санаачлагчид буцаасугай.

Ингээд энэ тогтоол баталсанд тооцогдоно.

8.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

67.4 хувиар санал дэмжигдлээ.

9.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

72.6 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66.3 хувиар санал дэмжигдлээ.

Тодруулж 2 дахь санал хураалтын дүн 74.7 хувь. 3 дахь санал хураалтын дүн 71.6 хувиар саналууд дэмжигдсэн байгаа.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалынх нь баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо одоо хуралдъя.

10.55 цагт

Дараагийн асуудалд оръё. [Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.](#)

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна аа. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа, эрхэм хүндэт нийслэлчүүд ээ,

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилго зорилтоо ханган хэрэгжүүлэхийн тулд олон жил шийдэгдээгүй зангилаа асуудлуудад төвлөрч үе шаттай та бид хамтдаа шийдвэрлэж байна аа. Олон жил гацсан хөгжлийн төслүүдийг гацаасны цаана улс дамнасан далд зохион байгуулалт байсаар ирсэн нь нууц биш юм аа.

Сүүлийн хэдэн өдөр Бадрах Энержигийн хөрөнгө оруулалтын гэрээ, Гашуун сухайт-Ганц мод, Хил холболтын төмөр замын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэлэлцэх үед жагсаал цуглаан өрнөж Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд гаднын бүртгэлгүй дугаараас мессеж илгээх зэрэг олон нөлөөллийн ажиллагаа явсан байхыг үгүйсгэхгүй ээ. Энэ бол гацаагчдын олон жилийн туршид өрнүүлсэн хуучин технологи гэдгийг та бүхэн мартаж болохгүй юм. Гэхдээ бид хамтдаа хурдтай хөгжлийн төлөө зориг гарган энэ бүхнийг даван туулах учиртай. Хамтарсан Засгийн газраас эрэмбэлэн танилцуулсан хөгжлийн 14 мега төслөөс Эрдэнэбүрэний УЦС, Гашуун сухайт-Ганц мод хил холболтын төмөр замыг дэмжих тогтоол, мөн Монгол, Францын уран олборлох хөрөнгө оруулалтын гэрээг дэмжиж баталсан Улсын Их Хурал, Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан болон Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд Засгийн газрын нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье ээ.

Цаг хугацаа өнгөрөх тусам үнэн явдал үнэн баримт бүхэн цаасан дээр түүх болон мөнхөд үлддэг ээ. Холимог тогтолцоогоор бүрдсэн шинэ парламентын анхны намрын чуулган Монгол Улсын түүхэнд тодоор бичигдэн үлдэнэ гэдэгт Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд бат итгэлтэй байна.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил болгон зарласан билээ. Энэ нь нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Улсын Их Хурал Засгийн газар, төрийн байгууллагууд, ААН, иргэд ойлголтоо нэгтгэн нийслэлийг дэмжихэд үндсэн ач холбогдол нь оршиж байгаа юм аа. Хот бол өөрөө амьд организм. Биеийн дархлааг бүхэлд нь сайжруулахтай адил нийслэлийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатайг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад оролцсон эрдэмтэн судлаачид зөвлөсөн гэдгийг бид мартаж болохгүй ээ.

Дэлхийд сайн ба муу хот гэж огт байхгүй бөгөөд гагцхүү ерөнхий төлөвлөгөөгөө зөв ба буруу хийсэн, ерөнхий төлөвлөгөөгөө хэрэгжүүлж чадсан чадаагүй гэдэг л ганцхан ялгаа байдаг гэдгийг судлаачид онцолсон. Улс төрчид шинж тэмдэгтэй зууралдах биш харин эрдэмтэн судлаачдын мэргэжилтнүүдийн зөвлөж буй суурь шалтгааныг шийдвэрлэх олон нийтэд ойлгуулах тал дээр дэмжлэг үзүүлэх нь хамгийн дөт шийдэл юм гэдгийг ч мөн судлаачид танилцуулсан.

Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд Ерөнхий сайдын шууд удирдлага дор мэргэжлийн байгууллагууд, хот төлөвлөлтийн мэргэжилтнүүд, их дээд сургуулийн төлөөлөл, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Шуурхай штабыг байгуулан ажиллуулж байна. Парламентад суудалтай улс төрийн намын дарга нар болон үе үеийн НЗД-аар ажиллаж байсан эрхмүүд штабын бүрэлдэхүүнд орж нийслэл Улаанбаатар хотын гамшгийн хэмжээнд хүрсэн суурь асуудлыг дэд бүтцийн асуудлыг улс төрөөс ангид шийдвэрлэх эр зоригийг гаргаж байгаад мөн талархал илэрхийлье ээ.

Нийслэлийн асуудал бол улс төржих сэдэв огт биш юм аа. Тийм ч учраас бид ойлголтоо нэгтгэж нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих бүлэг байгуулж ажиллахыг парламентад суудалтай улс төрийн намууд мөн нийслэлийн ялангуяа нийслэл жагсаалтад сонгогдсон эрхэм гишүүддээ уриалж байна. Энэ агуулгаар Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жилийн эхэнд Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг өргөн барьж бүх нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээ, дарааллыг зөв тогтоож, та бид хамтдаа нэгдсэн ойлголтод хүрэх нь энэхүү хэлэлцүүлгийн хамгийн чухал ач холбогдол юм. Татварын тухай хуульд оруулсан өөрчлөлтийн хүрээнд хүний хөгжил, нийгмийн хариуцлагын чиглэлээр хөрөнгө оруулсан ААН-ийг дэмжих борлуулалтын орлогын нэг хувьд ноогдох татвараас чөлөөлөх зохицуулалтын дагуу нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулахад төслүүдэд хийж буй хөрөнгө оруулалт ААН-үүд олноор саналаа илэрхийлж Засгийн газартай хамтран ажиллаж байгаад мөн талархал илэрхийлье ээ.

Засгийн газар бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар мөн төлөвлөж байна. Нийслэлийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан бүс тус бүр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эдийн засгийн төслүүдтэй уялдуулан боловсруулж Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн барихаар бэлтгэл ажлаа хангаж байна аа. Бүсийн анхдугаар хуралдаанаар 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөө бүс нутагтаа хэрэгжүүлэх 5 мега төслүүд бүсийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчны нэгдсэн санал 2026 оны улсын төсөвт тусгах зэрэг саналыг хэлэлцэхээр төлөвлөж байна.

Тийм учраас бүсээс сонгогдсон эрхэм орон нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг энэхүү бүсийн зөвлөгөөнд амжилттай бас мөн бүтээлч оролцохыг Ерөнхий сайдын хувьд уриалж байна. Бид нийслэл, Улаанбаатар хот, бүсийн асуудлыг хамтад нь авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Улаанбаатар хотын хувьд анхны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 1954 онд баталж байсан бол 1961, 1976, 1986 онуудад тодотгол хийж байсан. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөг 2002 онд баталсан байдаг. Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөн хэлэлцэн баталж байсан. Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө бүтэн хэрэгжээгүй суурь шалтгаануудыг эрчим хүчний үнийг эрт чөлөөлж чадаагүйгээс дэд бүтэцтэй газраа даган ерөнхий төлөвлөгөөнд тусаагүй төлөвлөгөөт бус барилгажилт үүссэн асуудал, Засаглалын хэт тогтворгүй байдлаас үүдэн сахилга хариуцлага суларч хууль бус газар олголт хавтгайрсан асуудал, нийслэлийн төсөв хөрөнгө оруулалтын шийдвэрлэх хэмжээнд байж чадаагүйгээс үүсэж асуудал хуримтлагдсан асуудал, Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй байсан ч хариуцлага тооцох эрх зүйн орчин сул, газар олголтын асуудлаар хэт олон

субъект улс төрийн гэнэтийн шийдвэр гаргадаг зэрэг суурь асуудлуудтай ерөнхий төлөвлөгөө хэрэгжээгүй шалтгааныг холбож үзсэн байна аа. Харин энэ удаагийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа хэрэгжихүйц байх зарчмыг баримтлан 20 минутын хот загварт тулгуурлаж Улаанбаатар хотын асуудлыг үндсэн 7 том салбараар тодорхойлж бусад улс орны туршлагад суурилан дахин төлөвлөлт хийж, нийслэлийн хэт төвлөрөл, тэгш бус хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжлийн загварыг бий болгоход энэхүү төлөвлөгөө бүхэлдээ чиглэгдсэн.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд нийслэл хот байгуулалтын өнөөгийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн өсөлт шинжлэх ухааны хөгжил, цаг үеийн өөрчлөлтүүд, ирээдүйн хотжилтын чиг хандлага, иргэд, олон нийтийн санал оролцоонд тулгуурлан амьдрахад таатай орчин бүрдсэн амьд хот бүрдүүлэхэд энэхүү төлөвлөлт чиглэгдсэн болно. Ерөнхий төлөвлөгөө хэрэгжих үндэс нь төлөвлөлтийг олон нийтийн оролцоонд тулгуурлан хэлэлцүүлэн хэрэгжүүлэх байдаг бөгөөд намрын чуулган дамжиж өргөн барьснаар хаврын чуулган хүртэл Улсын Их Хурал мэргэжлийн байгууллагууд иргэдийн дунд өргөн хэмжээний хэлэлцүүлэг хийх цаг хугацааны болгоомжийг Засгийн газраас олгох нь зүйтэй гэж үзсэн. Энэхүү ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад зөвлөсөн мэргэжилтнүүд Монгол Улсад хэрэгжиж буй төслүүдийн үе шат, эрэмбэ дараалал, төсөл хоорондын үнэлгээ хийхэд өнгөрсөн хугацаанд алдаа гарсныг мөн онцгойлон анхааруулсан.

Үүнийг олон улсын нэршлээр контрол товер гэдэг нэгдсэн ойлголт байдаг гэж тайлбарласан бөгөөд нэг үгээр хэлбэл бидний хэрэгжүүлж байсан төслүүд ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, хоорондоо уялдаа холбоогүй, эрэмбэ дараагүй, төсөл хоорондын эерэг болон сөрөг нөлөөллийг урьдчилан тооцдоггүй нэгдсэн их өгөгдөлд тулгуурласан дүгнэлт байдаггүй, төлөвлөлтөд олон нийтийг оролцуулах механизм сул зэрэг асуудал нь хөрөнгө оруулалт цаг хугацаа алдахад нэлээдгүй нөлөө үзүүлсэн байна. Тиймээс ч нийслэлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэн нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих төслүүдийн талаар нарийвчилсан мэдээллийг холбогдох байгууллагын хүмүүсээс авч хамтдаа энэхүү төслүүдийг ойлгон уялдуулж хамтдаа бас мэдээлэл түгээж олон нийттэй хамт нэг ойлголттой болоход хамтран ажиллахыг та бүхнээс хүсэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийслэл хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх 24 мега төслийг хэрэгжих хугацаа, төслийн нөлөө, өртөг гэсэн 3 хүчин зүйлийн дагуу эрэмбэлж төслүүдийн харилцан уялдаа, ач холбогдол, төсөл хоорондын эерэг, сөрөг нөлөөллийг тооцож, контрол товер аргачлал буюу нэгдсэн удирдлага, зохицуулалт, хяналттайгаар хэрэгжүүлэхээр энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан. Уг төслүүдэд Баянзүрхийн товчооноос 22-ын Товчооны уулзвар хүртэл 32км хэвтээ тэнхлэгийн 4-өөс 6 эгнээ бүхий Туулын хурдны авто замын бүтээн байгуулалт хийгдэхээр туссан. Туулын хурдны зам Хүй 7 худагт 30 мянган хүний багтаамжтай наадмын шинэ цогцолбор болон спорт бусад цогцолборуудыг барьснаар шинэ төвлөрлийг Хүй 7 худагт үүсгэх боломжтой байдлаар зохицуулалт мөн энэ төлөвлөгөөнд тусгагдсан. Хандгайтаас Чингис хаан нисэх онгоцны буудал хүртэл төр захиргааны нэгдсэн байрыг холбосон. Сэлбэ голыг дагасан гүүрэн байгууламж туннел бүхий босоо тэнхлэгийн 62.5 км хурдны замын төсөл Богд Хаан төмөр замын бүтээн байгуулалтын дотоодын сүлжээг ашиглах шугам зэрэг асуудлууд орсон байгаа. Энэхүү босоо тэнхлэгийн

хурдны замаар нийслэл Улаанбаатар хотын төвийг Хөшгийн хөндийтэй өнөөдөр та бүхэн бас хэлэлцэн баталсан Хүннү хот шинээр сүндэрлэн бий болох дэд бүтцийн асуудлыг мөн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан байгаа.

Өнөөдөр Шинэ Зуунмод хотыг Хүннү ухаалаг хот болгон өөрчлөх Улсын Их Хурлын тогтоолын төслийг одоо хэлэлцэж шинэ хотын концепцтой уялдуулах уралдаан зарлах боломжийг гаргаж өгсөн Их Хурлын гишүүд та бүхэнд мөн талархал илэрхийлье ээ.

Хотын авто замын сүлжээг хэвтээ 8 босоо, 12 тэнхлэг, 3 тойрог авто замын бүтэцтэй байхаар төлөвлөж дээрх төслүүдийг хэрэгжүүлснээр замын хөдөлгөөний оргил ачааллын үеийн дундаж хурд 9 км цагаас 22.5 км цаг болох боломжтой гэж тооцсон.

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй автомашины хэрэглээг бууруулж нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд Энхтайваны өргөн чөлөөний дагуу 17.7 км 14 өртөө бүхий Улаанбаатар метроны 1, 2 дугаар шугамыг байгуулахаар мөн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан. Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэхэд орон сууцын зориулалттай баригдаж буй барилга байгууламжийн зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх, газар доорх байгууламж, дулааны шугам, нийслэлийн дэд бүтцийг сайжруулах гэр хорооллын хэсэгчилсэн дэд бүтэц эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барих зайлшгүй шаардлагатай бөгөөд төсөл тус бүрээр мөн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан болно.

Нийслэлийн дулаан эрчим хүчний хэрэглээ нь 3820 мвт-ын байгаа бол цаашид 7480 мвт болж нэмэгдэх тооцоолол хийгдсэн. Иймд 2 дугаар цахилгаан станцын эдэлбэр газар болон дэд бүтцийг сүлжээг ашиглан 5 дугаар цахилгаан станцыг барьж эрчим хүчний хэрэглээнд 300 мвт-ын нэмэлт эх үүсвэрийг бий болгохоор энэ төлөвлөгөөнд тусгагдсан. Мөн нүүрсний уурхайд түшиглэн нүүрс болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон эх үүсвэрүүд шинээр байгуулахаар төлөвлөгдөж байна. Эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхгүйгээр хот тэлэх, шинэ хот байгуулах, орон сууцжуулалтын бүтээн байгуулалт аж үйлдвэрчдийн төсөл хэрэгжүүлэх ямар ч боломжгүй нь ойлгомжтой юм аа. Энэ намрын чуулганаар эрчим хүчний үнэ чөлөөлөх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, эрчим хүчний салбарын олон жилийн хугацаанд дуншсан асуудлыг мөн Засгийн газар Их Хуралтайгаа хамтран шийдвэрлэж чадсан гэдгийг хэлье.

Энэхүү реформыг эхлүүлсэн цагаас эрчим хүчний томоохон станцууд Бөөрөлжүүтээс эхлээд ашиглалтад орж эхэлж байгаа. Цаашдаа мөн гацсан бүх төслүүд хөдөлж эхэлж байгаа баяртай мэдээг та бүхэнд бас дуулгая аа.

Нийслэлийн дулаан эрчим хүчний сүлжээний шинэчлэлийг бүрэн шийдвэрлэхэд багадаа 2 тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Нийслэлийн асуудлыг сууриар нь шийдвэрлэх 24 мега эрэмбэлэгдсэн төслийг хэрэгжүүлэхэд багадаа 70 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт нийслэлд шаардлагатай байна аа. Тийм ч учраас ерөнхий төлөвлөгөөнд тусалсан энэ эдгээр төслүүдийг хэрэгжүүлж нийслэлийн асуудлыг бүрэн хэмжээнд шийдвэрлэх эрх зүйн шинэ орчин санхүүгийн шинэ модель зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөнд туслан хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх контрол товер буюу нэгдсэн удирдлагын зохицуулалт, хяналтын тогтолцоог бүрдүүлж, нэгдсэн ойлголтод оруулах хүрээнд эрэмбэлэгдсэн төслүүдийн эхний 4-ийг дурдахад ийм байна.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг баталж дээр дурдсан төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлж чадвал Улаанбаатар хотын иргэдийн 91 хувь нь орон сууцад 9 хувь нь сайжруулсан амины орон сууцад амьдрах боломж бүрдэнэ ээ. Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 8м²-аас 35м² болж нэмэгдүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1.2 сая зорчигч тээвэрлэж нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлэх Улаанбаатар хотын өсөн нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэглээний 30 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах боломж бүрдэх зэрэг ач холбогдолтой бөгөөд иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулах асуудалд илүүтэй төвлөрсөн төлөвлөлт гэж үзэж болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж ажлын хэсгийг олон нийтийн өргөн цар хүрээтэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэлбэртэйгээр зохион байгуулж нийслэлийн дэд бүтцийг дэмжих жилийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрыг дэмжиж ажиллахыг хичээнгүйлэн хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Энэ удаа Улсын Их Хурлаас оюутны өвлийн амралтыг тохиолдуулан нээлттэй парламент хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа.

Тэгээд энэ арга хэмжээг зарлаад нийтдээ 1740 гаруй оюутан бүртгүүлсэн Улсын Их Хурлын залуу гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг ажиллаж их дээд сургуулийн багш нартай хамтарч ажиллаж, 2 удаагийн шалгаруулалтыг явуулсны үндсэн дээр 100 оюутан үлдээд 1 сарын хугацаанд парламент дээр дадлага хийж байгаа. Цалинтай дадлагыг анх удаа хийж байгаа. Тэгээд оюутан дүү нартаа Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс дадлагынх нь ажилд амжилт хүсье. Мөн сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Их Хурал батлахаар заасан бөгөөд Улаанбаатар хотын анхны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 1954 онд баталж 1961, 1976, 1986 онуудад тодотгол шинэчлэл хийгдэж байсан ба манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн

засагт шилжиж 2002 онд Улаанбаатар хотыг 2000-2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2013 онд Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлан хэрэгжүүлж ирсэн байна аа.

Хууль санаачлагч Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, агаар хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэж улмаар иргэдийн эрүүл аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүрч байгаа тул Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчилж хотын төлөвлөлтийн шинэ орчин бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн иргэний эрүүл аюулгүй амьдралын таатай орчин бүрдүүлсэн олон төвт суурьшлын тогтолцоонд суурилсан сайн засаглал бүхий эдийн засаг, бизнес, аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх боломжтой байдлаар Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна аа.

Тогтоолын төсөлд иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын DParliament.mn цахим системд байршуулсан болно. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нийслэл Улаанбаатар хотын өмнөх төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг үнэлсэн эсэх, түүний үр дүн, хэрэгжилт хангалтгүй байгаатай холбогдуулан авсан арга хэмжээ, хариуцлага тооцсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн холбогдох яамдын уялдаа холбоог хангасан байдал, төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах эсэх, хууль бус газар олголтын асуудлыг хэрхэн хязгаарлах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хүүхдийн эрхийг хангах хүн төвтэй хот болгон хөгжүүлэхэд хэрхэн анхаарсан, Улаанбаатар хотыг 2040 он гэхэд хүн амын тоо хэд байхаар төлөвлөсөн, ус ашиглалтын зохицуулалт, хог хаягдлын менежментийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог ач холбогдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Улсын Их Хурлаар батлуулах ач холбогдол тус төлөвлөгөөнд агаарын бохирдол, түгжрэл, эрчим хүчний дутагдал зэрэг Улаанбаатар хотод тулгамдаад байгаа асуудлуудыг хэрхэн шийдвэрлэхээр тусгасан талаар, Яармагийн суурьшилтын бүс, Богд хан уулын Дархан цаазат газрын хилийн цэсийн асуудлыг хэрхэн зохицуулах, дүүжин тээврийн бүтээн байгуулалтын явц үр дүнгийн талаар асуулт асууж хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг тогтоолын төслийг дэмжиж байгаа бөгөөд хүн төвтэй хүртээмжтэй хүүхдийн тоглоомын талбай ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн хот төлөвлөлтийг хийх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэхэд Засгийн газрын оролцоог нэмэгдүүлж салбар яамдын ажлын уялдаа холбоог хангах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улаанбаатар хотод тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэх төлөвлөгөөнд суурилсан шийдлийг бий болгох Богд Хан уулын дархан цаазат газрын хилийн цэсийн асуудлыг эргэн харах, хүүхдэд ээлтэй бүтээн байгуулалтыг дэмжих, төлөвлөлтийг оновчтой хийх, тогтоолын төслийг хугацаа алдалгүй хэлэлцэх батлах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Ерөнхий төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн

бүрэлдэхүүнд нийслэлээс сонгогдсон гишүүдийг түлхүү оролцуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц одоог хүртэл хот төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүйн улмаас төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, хөрөнгө оруулалт үр дүнд суурилсан, эрэмбэлсэн нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.5, 53.3 хувь нь нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа ажлын хэсгийг танилцуулъя. Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Чинбатын Төгсдэлгэр Нийслэлийн Ерөнхий архитектор, Амгаагийн Баттөмөр Хот байгуулалт хотын стандартын газрын Ерөнхий архитекторын ажлын албаны дарга, Цэнд-Аюушийн Мягмарсүрэн Хот байгуулалт хотын стандартын газрын ахлах мэргэжилтэн, Сумьяасүрэнгийн Энхжаргал Хот байгуулалт хотын стандартын газрын хуулийн мэргэжилтэн, Раднаагийн Амартүвшин Хот төлөвлөлт судалгааны институт Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот ОНӨҮГ-ын дарга, Оюуны Одбаяр Хот төлөвлөлт, судалгааны институцийн ерөнхий менежер, Лүнгээгийн Эрдэнэбат Хот төлөвлөлт, судалгааны институцийн ерөнхий менежер, Пүрэвдоржийн Энхболд Хот төлөвлөлт, судалгааны институцийн эдийн засагч, Саруулын Анхбаяр Хот төлөвлөлт судалгааны институцийн Зам тээвэр судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Бямбажаргалын Лхагвасүрэн Хот төлөвлөлт судалгааны институт дэд бүтцийн хэлтсийн дарга, Хадаагийн Мөнхнаран Хот төлөвлөлт судалгааны институт Захиргаа менежментийн хэлтсийн дарга, Лувсанренчингийн Ганбат Хот төлөвлөлт, судалгааны институцийн зөвлөх архитектор, Замбын Батжаргал Хот төлөвлөлт, судалгааны институт Байгаль орчны зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууя.

Н.Номтойбаяр: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр энэ түүхэн бодлогын баримт бичиг Их Хурлаар орж ирж үндсэндээ Монгол төрийн түүхэнд анх удаагаа төв нийслэл хотынхоо ерөнхий төлөвлөгөөг батлах гэж байна. Яагаад анх удаа гэж байна гэхээр 1984 он хүртэл бол Монгол төрийн бодлого 100 хувь шингэж явж чадаагүй батлагдаж байсан. Ерөнхий төлөвлөлт дизайн бол нэлээн шүүмжлэлтэй хандахуйц л явж байсан. Хэтийн ирээдүйн хөгжлийн төлөвийг

ердөөсөө тооцоогүй. 2002 онд тэр үеийн нийслэлийн энэ бодлого төлөвлөлтийн хүрээн дэх боловсон хүчний бодлого маань төдийлөн өндөр хэмжээнд бас хөгжөөгүй. Хотын хэтийн хөгжлийн төлөвлөгөө бас хол орж чадаагүй. Тэгээд үүний хэрэгжилт нь үндсэндээ хорин хэдхэн хувьтай гарсан. Тэгээд бодит хэрэгжилт нь маш муу байсныг өнөөдөр Улаанбаатар хотод тулгамдаж байгаа бүхий л асуудлууд нотлоод өгч байгаа. Тэгэхээр энэ 2040 ерөнхий төлөвлөгөөтэй холбогдуулаад мэдээж дэмжиж байгаа. Асуух хэдэн асуулт байгаад байгаа юм. Ерөнхий суурь эдийн засгийнхаа системийг ямар систем дээр авсан бэ? Энэ асуултаа задлаад асуувал ер нь зүүний чиг баримжаатай социалист эдийн засгийн тогтолцооны суурь дээр авбал нөгөө төрийн алба, нөгөө төрийн өмчит үйлдвэрийн газрууд энэ маань ер нь бахь байдгаараа байна л гэсэн үг.

Хэрвээ илүү барууны консерватив чиглэлийн чиг баримжаатай эдийн засгийн суурин дээр авбал энэ хотын захиргаа маань хийх ёстой зохицуулах ажлуудаа хийгээд илүү хувийн хэвшлийг дэмжих иргэдийнхээ оролцоог хангах ийм зарчмаар явна л гэсэн үг. Тэгэхээр энэ 2040 ерөнхий төлөвлөгөөний цаад эдийн засгийн суурь систем нь яг юун дээр үндэслэв ээ? Энэ анхнаасаа их тодорхой баймаар байгаад байгаа юм. Хэрвээ барууны чиг баримжаатай явна гэвэл үүнээс үүдэлтэй ямар төрлийн шинэ бизнесүүд гарах юм. Татварын бааз суурь маань яаж нэмэгдэх юм. Макро эдийн засгийн шинэ түвшнээ бид нар хэр хэмжээнд харах юм. Төсвийн орлого маань хэр тэлэх юм. Түүнээс бүрдэж байгаа хөрөнгө оруулалтаар бид нар ямар ямар асуудлуудыг шийдэх юм гээд ийм шат дараалалтай олон цогц ийм одоо эко бизнес системийн л асуудлууд үүсэх гээд байгаа юм л даа. Тэгээд энэ дээр нэг тодорхой байр суурь авмаар байх юм.

Өнөөдөр энэ хүрээндээ хотын захиргаад маань хэчнээн алба нэгжүүд байна. Нийтдээ одоо хэдэн хүн ажиллаад байна. Жилийнх нь урсгал зардал юу байна. Энэ жилийн нийслэлийн өөрийнх нь орлого болон төсвөөс баталж өгсөн төсвийн нийлбэр дүн нь 5.3 их наяд байгаа. Энэ чинь саяхныг л хүртэлх нийт улсын төсвийн бараг 50 хувьтай тэнцэхүйц хэмжээний хөрөнгө байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ маань цаашдаа энэ эдийн засгийнхаа бааз суурь тодорхойлох системийн хүрээнд чухам яаж явах вэ? Энийг л маш сайн ойлгогчид байгаа юм.

Дээрээс нь 2 дахь асуух гээд байгаа зүйл юу вэ гэхээр энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Их Хурлын хүлээх үүрэг хариуцлага маш өндөр байгаа. Өнөөдрийн байгаа эрх зүйн орчны хүрээнд энэ төлөвлөгөө биежихэд биеллээ олоход хангалтгүй. Ихэнх хуулиуд нь хааж боосон, хязгаарласан, ихэнх чиглэлээрээ хуулиар зохицуулсан асуудлууд байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ 2040-ийн хэрэгжилтийг бодитой хангахын тулд магадгүй нэг 10-аад жилийн дараа энэ төлөвлөгөөнийхөө биелэлтийг бид эргээд ярихад угтуулж бид нар ямар хууль эрх зүйн орчныг хөндөх вэ? Их Хурал дээр ямар үүрэг хариуцлага ирэх вэ? Энэний талаар хийсэн тооцоо судалгаанууд байгаа юу?

Энэ 2-ын хүрээнд тодорхой байр суурь сонсмоор байна аа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: 2040-ийг оруулж ирж байгаа бас шалтгаан би түрүүн бас үгэндээ хэлсэн. Номтойбаяр гишүүнтэй санал нэг байна. Яг ерөнхий төлөвлөгөө нийслэл Улаанбаатар хотыг парламент, олон нийт хамтдаа маш сайн ойлгох ёстой болчихоод байгаа юм. Ерөнхий сайд ч гэсэн энэ шуурхай штаб байгуулаад ажиллаж

байгаа нь ерөөсөө ойлголтуудыг л нэгтгэе гэж бодоод байгаа юм. Маш их олон төслүүд байна. Төслүүд хоорондоо эрэм үнэлэгдээгүй. ЗТЯ-ан дээр эхлүүлсэн их олон төслүүд ЭХЯ-ан дээр эхлүүлсэн олон төслүүд нийслэл дээр хэрэгжүүлж байгаа олон төслүүд олон улсын байгууллагууд хэрэгжүүлж байгаа хувийн хэвشلүүд хэрэгжүүлж байгаа гээд энэ бүх төслүүдийг нэгдсэн эрэмбэ буюу тэр контрол товерт бид нар оруулж чадаагүйгээс болоод маш их цаг алдчихсан, ТЭЗҮ-үүд нь зөрчихсөн ийм асуудлууд байгаа.

Тийм учраас 2040-ийг оруулж ирж байгаа. Энэ ингээд нэлээн том хэмжээний хэлэлцүүлэг болоосой гэж бодож байгаа. Хамтдаа хотоо бүтэн ойлгоё. Жишээлбэл газрын доор ингээд шугам булчихсан, энэ шугамуудын хөрөнгө оруулалт хийхгүй байсаар байгаад одоо энэ маань ингээд хийвэл багадаа л 2 тэрбум доллар. Гэтэл нэг тэрбум долларын хөрөнгө оруулалт хийхэд л бид нар төлбөрийн тэнцэл дээр алдаа гардаг. Тэгвэл энийг бид нар улсын төсвөөр хийж чадах уу үгүй юу. Нийт энэ төслүүдийг хэрэгжүүлэхэд багадаа 70 орчим тэрбум долларын шаардлага нийслэл Улаанбаатар хотод төвлөрчихсөн байж байгаа. Бүсүүдийг оруулахгүйгээр. Энийг бид нар яаж босгох юм. Улсын төсвөө хүлээгээд одоо бид нар жишээлбэл улсын төсвөөрөө 70 тэрбум доллар босгоно гэвэл 30 жил Улаанбаатар яг хэвээрээ байна. Энэ гашуун үнэн. Энэ дээр парламентаас Засгийн газар, нийслэл ч гэсэн дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай байгаа.

Тийм ч учраас бид нар ил тод энэ асуудлуудаа ярих нь зүйтэй. Засгийн газраас энэ асуудлуудыг эрэмбэлж байгаа. Жишээлбэл хаврын чуулганаар бид нар татвар, нийгмийн даатгал, хөрөнгө оруулалт, тендерийн багц хуулийг дөрвүүлэнг нь оруулж ирнэ. Энэ өөрөө юу вэ гэхлээр бизнес хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх байдлаар хөрөнгө оруулалтыг яаж татах вэ гэдэг дээр асуудлууд гаргана. Нийслэл Улаанбаатар хот болон Барилга, хот байгуулалтын яам бол энэ төслүүдийг эрэмбэлэх нь зүйтэй гэж би Ерөнхий сайдын хувьд шахаж байгаа юм.

Ингээд бид нар аль нь хувийн хэвشلээр байх юм? Аль нь ВОТ хэлбэртэй байх юм, аль нь концессоор хийгдэх юм, аль нь жишээлбэл бүтээгдэхүүн солилцооны менежментээр хийгдэх юм гэдэг энэ зүйлээ эрэмбэлэхгүйгээр одоо байгаа хурдаараа явбал Улаанбаатар хот хэвээрээ л байна. Тийм учраас энэ бол ерөнхий төлөвлөгөө батлах биш ерөнхий төлөвлөгөөн дээр байгаа үзэл санааг нийслэлчүүд улсын хэмжээнд нийт парламентын гишүүд маань ойлгож хамтдаа нийслэл Улаанбаатар хотод юу хэрэгтэй байгаа, ямар үе шатаар яаж шийдэх вэ гэдгээ ойлгох нь зүйтэй. Хэн ч хаанаас ч цагаан морьтой ханхүү хүрч ирж гэнэт нийслэлийг өөрчлөхгүй. Үе шаттай төслүүдээ хэрэгжүүлж, ерөнхий төлөвлөгөөгөө хэрэгжүүлээд, ерөнхий төлөвлөгөөний дагуу явж байж л хэрэгжинэ.

Тийм учраас энэ төслүүд болон концепцын эрэмбэ санаан дээр тогтох нь зүйтэй гэдэг энэ агуу.

Д.Амарбаясгалан: Хотын дарга Нямбаатар нэмэлт хариулт өгье. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Баярлалаа. 2040-ийн эдийн засгийн үндсэн суурь тооцооллын хэрхэн яаж тооцсон бэ гэдэг талаар Номтойбаяр гишүүн асуулаа. Тэгэхээр яах вэ манай ажлын хэсэг энэ 2040 он хүртэл ДНБ-ийг 40 тэрбум ам.доллар-т хүрнэ ээ. Нэг хүнд ноогдох ДНБ-ийг 18 мянган долларт хүргэнэ. Монгол Улсын төсвийг жилд 90 их наяд байхаар ингэж ерөнхий тэнцвэрийн онолын дагуу тооцоолсон. 2040 он

хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд бид 242 их наяд төгрөгийг энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж тооцоолсон. Энэ хүрээнд энэ 242 их наядын 120 орчим их наядыг улсын.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулья.

Х.Нямбаатар: 242 их наядын 120 их наядыг нь улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэе ээ. Үлдсэн 120 их наядыг нь хувийн хэвшлийн санхүүжилтээр хийх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл энэ 2040 хэрэгжих эдийн засгийн суурь нөхцөл, баталгаа бол төр, хувийн хэвшлийн түншлэл юм гэдэг ийм агуулгаар тооцоолсон. Би ганцхан тоо хэлэхэд 2035 он гэхэд Улаанбаатар хотын эрчим хүчний үндсэн хэрэглээ 3 гега давна. Одоо бол мянга гаран гегатай явж байгаа. Энэ жилийн хамгийн оргил ачааллын үед Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем 1680-д хүрч байсан. Тэгвэл энэ эдийн засгийн эрчимтэй өсөлтийн явцад Улаанбаатар хотын эрчим хүчний хэрэглээ яг 10 жилийн дараа гэхэд 3 мянган Мвт-ыг давахаар байгаа. Энэ тохиолдолд зөвхөн эрчим хүчний дамжуулах шугамыг өргөтгөн шинэчлэхэд 2 тэрбум ам.доллар буюу 7 их наяд төгрөг шаардлагатай гэдэг.

Д.Амарбаясгалан: Чинбатын Ундрам гишүүн асуулт асууя.

Ч.Ундрам: Монгол Улс дангаараа өөрсдөө хот байгуулж байсан түүх байхгүй ээ. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гээд бүгдээрээ Оросуудын оролцоотой байгуулж байсан. Хамгийн сүүлд 1980 онд Багануурын район гээд бас оросуудын оролцоотойгоор дагуул хот байгуулж байсан. Тэгээд тэр үед Монгол талаас ажиллаж байсан хүмүүс бол одоо ер нь байхгүй болсон биз. Тийм ч учраас өмнөх 20 жилийн энэ Улаанбаатарын төлөвлөгөө гүйцэтгэл өнөөдөр 20 хувьтай байна гээд маш муу хийгдсэн байгаа. Тэгээд сая Ерөнхий сайд илтгэлдээ хэлж байна. Тухайн үед энэ төлөвлөгөөгөө ажлын төлөвлөгөө нь муу байсан уялдаагүй төсөв санхүү нь тодорхойгүй хариуцлага тооцдог тогтолцоо байхгүй тийм учраас өнөөдөр хэрэгжилт хориод хувьтай явж байна гээд ингээд яригдаж байна.

Тэгэхээр бид нар 2040 онд дахиад хэрэгжилт эдгээр асуудлаас болоод 20 хувьтай байна гээд сууж баймааргүй байна. Энэ алдаануудыг засах ямар төлөвлөгөө байгаа юм. Яаж засах юм? Энийг 1 дүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт одоо жишээлбэл энэ холбогдох хуулиуд нь ерөөсөө энэ төлөвлөгөөтэй уялдахгүй байгаа юм шиг санагдаж байна. Ногоон байгууламж гээд жишээ авъя л даа. Нэг хүнд ноогдох ногоон байгууламж өнөөдөр 8м² гэж байна 2040 онд 35м² болгоно гээд төлөвлөгөө гаргачихсан байдаг. Гэтэл энэ хот байгуулалтын хуулиар хэрвээ ААН газар аваад барилга барих зорилгоор газар авах юм бол 70 хувьд нь байшин бариад 30 хувьд нь машины зогсоол хүүхдийн тоглоомын талбай ногоон байгууламж ба бусад гэгчихсэн байгаа.

Тэгэхээр ААН-үүд чинь ерөөсөө ногоон байгууламж байгуулдаггүй. Ашигтай ажиллагаагаа бодоод л дүүрэн машины зогсоол, хүүхдийн тоглоомын талбай л байгуулчихдаг. Тэгээд энэ хэрэгждэггүй. Газрын тухай хууль бас 10 хувь л гэгчихсэн байгаа. Машины зогсоол болон бусад. Тэгэхээр энэ хуулиуд чинь хоорондоо ерөөсөө уялдахгүй тэгээд энэ зорилгодоо бид нар одоогийн хууль эрх зүйн орчинд хүрч чадахгүй харагдаж байгаа юм.

Тэгэхээр энийг өөрчлөх ямар төлөвлөгөө боловсруулж байгаа юм бэ? Яг одоо энэ орж ирсэн тогтоолын төслийг дагаад энэ хуулийн өөрчлөлтүүд орж ирээгүй байна. Энэ хуулийг энэ төлөвлөгөөг та бүхэн ганцхан сар хэлэлцүүлсэн байгаа байхгүй юу ард иргэддээ. 3 жилийн өмнө 3 жил 4 сарын өмнө буюу 2021 оны 9 сарын 29-өөс 10 сарын 29 хүртэл. Энэ хэлэлцүүлгийг дахиж хиймээр байна аа. Ингээд ганцхан сар 3 жилийн өмнө хийсэн хэлэлцүүлгийг чинь өгсөн саналууд өнөөдрийн ард иргэдийн саналууд бас өөрчлөгдсөн байгаа шүү дээ. Эцэст нь энэ хаягжилтын ажлын хэсгийг би ажлыг нь хүлээгээд жил болж байна. Барилга хот байгуулалтын яаман дээр 4 жилийн өмнө энэ ажлын хэсэг байгуулагдаад тэгээд өнөөдөр хүртэл юу ч Улсын Их Хурлаар ч юм уу энд тэнд яригдахгүй байна л даа.

Энэ ажлын хэсэг хэр явж байгаа юм? Энэ Улаанбаатарын хаягжилт чинь бүр маш замбараагүй явж байна шүү дээ. Хэн хаана байгаа нь мэдэгдэхгүй. Тэгээд энийгээ дагаад бусад үйлчилгээнүүд нь ч гэсэн олигтой явагдахгүй. Тэгэхээр ийм хэдэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хотын дарга Нямбаатар хариулт өгье. Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Би сүүлийнх нь асуултуудаас хариулаад явчихъя. Хаягжилтын асуудал дээр Барилга хот байгуулалтын яамны ТНБД хариулт өгөх байх аа. Энэ 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг 2017 оноос хойш ажиллаж байгаа. Энэ хугацаанд салбар салбарын эрдэмтдийн төлөөлөлтэй төрийн байгууллагуудын төлөөлөлтэй бүх сегментийн төлөөллүүдтэй үндсэндээ 8 жилийн хугацаанд энэ 2040-ийг боловсруулах ажил хийгдсэн. Үүнээс гадна Сөүл хотын хот байгуулалтын чиглэлийн архитектур төлөвлөлтийн чиглэлийн компаниас консалтинг авч энэ боловсронгуй болгох ажлууд давхар хийгдсэн. Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу ажлын хэсэг гарсны дараа иргэдээр хэлэлцүүлэх энэ ажлууд цаашид үргэлжилж явна гэдэгт итгэл төгс байна. Ундрам гишүүн нэг зүйлийг бид нар хэлэхэд Хот байгуулалтын тухай хууль 70, 30 гэсэн харьцаатай байгаа. Сүүлд бид нарын 2023 оны 12 дугаар сард батлуулсан Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах авто замын түгжрэлийг бууруулах анхдагч хуулийн төслөөр 60, 40-ийн харьцаатай болгосон. Энэ 60, 40-ийнхөө дагуу бид нарыг ер нь Улаанбаатар хотод дахин төлөвлөж орон сууцжуулах газрын нөөцтэй бүс бол зөвхөн гэр хорооллын бүс байгаа. Тэгэхээр тэр гэр хорооллын бүсүүд дээр бид нар нөгөө хэдэн дэд төвүүдээ байгуулж байгаа. Дэд төвүүдийнхээ төлөвлөлтийг 60, 40-ийн харьцаатай болгож ингээд өөрчлөн зохион байгуулж байгаа. Хамгийн эхнийх нь төлөвлөлт бол Сэлбийн тендер энэ 2 дугаар сард зарлагдана гэдгийг хэлье.

Ер нь бол бид нар энэ өмнөх хот байгуулалтын бүх алдаануудаа дахиж гаргахгүй давтахгүй гэдэг үүднээс төлөвлөлтүүд дээрээ маш их анхаарч явж байгаа. Нөгөө талдаа бид нар энэ гэр хорооллын дахин төлөвлөлт гэдэг бол бидэнд энэ хот төлөвлөлтийнхөө алдааг засах том боломж гэдэг утгаар харж байгаа гэдгийг хэлье ээ.

Бид дангаараа хот байгуулсан түүх байхгүй ээ гэсэн. Тэгэхээр цаашид бид нар Улаанбаатар хот гэдэг маань өөрөө маш том дэд бүтцийн төвлөрөл эрчим хүчний төвлөрөл, ААН байгууллагуудын төвлөрөл, эдийн засгийн 60 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа энэ том дэд бүтцүүд дээрээ бид нар шинээр төлөвлөлтийнхөө бүх алдааг л засъя гэж байгаа юм. Би товчхон ганцхан жишээ татаж хэлье. 1986 оны

ЗХУ-ын Гипагорын эрдэмтэн судлаачдын хийсэн энэ Улаанбаатар хот бол үндсэндээ нэг 600-аас 700 мянга орчим хүн амтай байхаар төлөвлөсөн хотод өнөөдөр яг 2 сая хүн амьдарч байна. 84 мянган машин зорчино оо гэсэн. Өнөөдөр зорчих зам дээр 804 мянган машин явж байгаа юм. Тэгэхээр бид нар үндсэндээ шинээр Улаанбаатар хотыг энэ 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөгөөр цоо шинээр хийхээр төлөвлөж байгаа гэсэн үг.

Тэгэхээр урдах алдаагаа яаж давтахгүй байх вэ? Өөрөөр хэлбэл өмнөх 29.3 хувийн хэрэгжилт дээр гарсан 3 том алдаа байгаа.

Нэгдүгээрт энэ санхүүгийн эдийн засгийн чадавхгүй байдлаас болж дэд бүтэц татаагүй байна аа.

Д.Амарбаясгалан: Нямбаатар даргын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Х.Нямбаатар: Тийм нөгөө өмнөх ерөнхий төлөвлөгөөний 3 том алдаа байгаа юм хэрэгжээгүй.

Нэгдүгээрт эдийн засгийн чадавхгүй байдал, 2 дугаарт хууль тогтоомжийн зөрчилдөөнтэй байдал, 3 дугаарт нөгөө авлига албан тушаалын байдлаас болж газрыг замбараагүй болгосон гээд. Тэгээд суурь шалтгаанаа хэдүүлээ эргээд хөөж байгаа юм л даа бид нар. Өнгөрсөн оны хүртэл 1м²-ыг халаах манай төвийн эрчим хүчний халаалтын зардал 506 төгрөг байсан. Тэгэхээр ерөөсөө тэр шугам сүлжээ рүүгээ бүгд шавж газар олголтыг авлигалын үндсэн дээр хийгдсэн. Хүүхдийн ногоон байгууламж, хүүхдийн сургууль, цэцэрлэгийн талбай бүгдийг нь барилга байгууламж болгосон нь ерөөсөө л нөгөө централ хийдинг системээ дагаж энэ явагдсантай том алдаа байгаа. 1984 оноос хойш Улаанбаатар хотод нэг ч том ДЦС баригдаагүй нь бидний эдийн засгийн чадавхгүй байдлыг илэрхийлсэн. Үүнээс болж төлөвлөлтийн хамаг том суурь алдаанууд үүнийг дагасан газрын авлигал явагдсан гэдгийг бүгд мэдэж байгаа. Тэгэхээр энэ алдааг засахын тулд дэд бүтэц дээрээ хөрөнгө оруулалт хийе.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 20 номерын микрофон өгье. Хариулт өгье.

Ц.Баярбат: Ундрaм гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яамны газрын дарга Баярбат.

2024 оныг хүртэл бол хуучнаар Барилга хот байгуулалтын яаман дээр энэ хаягжуулалтын хууль, нийслэл болон орон нутгийн энэ хаягжуулалтыг хийхтэй холбоотой ажлын хэсэг ажиллаж явсан. 2024 онд Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орсноор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжсэн. Тэгээд үүнтэй холбогдуулаад хаягжуулалтын хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг бол Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар дээр ингээд хийгдээд явж байна. Хуулийн төслийн боловсруулах ажил бол эхний төслүүдийг гаргасан. Ийм байдалтай байгаа.

Д.Амарбаясгалан: Чинбатын Ундрaм гишүүн тодруулж асууя.

Ч.Ундрaм: Тэгэхээр өмнөх төлөвлөгөө маань биелээгүй бас нэг том шалтгаан нь энэ ерөнхий төлөвлөгөөг зөрчиж газар олгодог байсан хариуцлагын системээ гэж ярьж байна. Тэгэхээр одоо энэ төлөвлөгөө маань батлагдаад энэ төлөвлөгөөг

зөрчиж газар олгох юм бол яг ийм хуулийн хариуцлага хүлээлгэнэ ээ гэсэн ийм санц орж ирэх юм уу гэдэг тодруулга.

Хоёрдугаарт энэ Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө бол ганцхан хотын нийслэлийн асуудал биш шүү. Энэ бүх яамны Засгийн газрын асуудал шүү гэдгийг хариуцлагатай хэлмээр байна. Ганцхан БХБЯ-ны ажил биш ногоон байгууламж гэхэд Байгаль орчны яам, ЗТЯ, ЭХЯ гээд бүх яам өмнө нь энэ бусад яамнууд нийслэлд л ерөөсөө үлдээчихсэн учраас энэ төлөвлөгөө чинь хэрэгжээгүй. Тэгэхээр бүх Засгийн газрын ажил шүү гэдгийг бас хариуцлагатайгаар хэлмээр байна.

Х.Булгантуяа: Чинбатын Ундром гишүүн үг хэллээ. Санц байгаа юм уу? Хотын дарга Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Би Ундром гишүүний асуултад хариулъя.

Яг ерөөсөө өнгөрсөн ерөнхий төлөвлөгөө батлагдаад бид бас нэг хийж чадаагүй ажил бол хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдээ батлаагүй юм байна лээ. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний араас барилгажилтын төслөө батлаагүй. Тэгээд даргыг хэн сайн таньдаг хүн нь хот байгуулалт дээр 5 давхар барих газраа 10 давхар 20 давхраар батлуулдаг ийм гажиг тогтолцоо явж байсан. Тэгэхээр бид нар энэ 2040-ийг батлуулсны дараа олон улсын нээлттэй тендер зарлаад Улаанбаатар хотыг 14 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг бид нар гаднын зураг төслийн компаниудаар хийлгэх гэж байгаа юм. Энэний араас тэр 14 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний араас 42 нэгж хорооллынхоо барилгажилтын төслийг бас давхар зуруулах гэж байгаа юм. Ингээд ирэхээр хотын даргыг таньдаг ч таньдаггүй ч ерөөсөө ямар нэгэн байдлаар барилгын илүү дутуу давхрын өөрчлөлт талбай хэтрүүлэх, ногоон байгууламж руу орж барих асуудал бүхэлдээ зогсоно. Өөрөөр хэлбэл хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл хоёроо бид нар.

Х.Булгантуяа: Нямбаатар даргын микрофоныг өгье.

Х.Нямбаатар: Дахиж цаашид бид нар яг ингээд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөө батлуулаад барилгажилтын төслүүдээ батлуулчихсаны дараа энийгээ бид нар Засгийн газрын хуралдаанаар батлуулчихна. Энэ тохиолдолд бид нар ерөөсөө барилгатай холбоотой элдэв зөвшөөрөл өгөхгүй. Өөрөөр хэлбэл А-ийн даалгавар гэж өгөөд А-ийн даалгаврын дагуу эскиз зурагдаад эскизийн дараа барилгын зураг зурагддаг явдлыг ер нь больё гэж байгаа юм.

Дээр нь бид нар Лувсанжамц гишүүн Барилга хот байгуулалтын яам бид хэд нэг зүйл дээр хот гуравласан байдлаар судалгааны ажил хийгээд явж байгаа нь гаднын ялангуяа Скандиновын хойгийн орнуудын Барилгын хууль, Хот байгуулалтын хууль, норм дүрмийг бид нар нутагшуулъя.

Дамдинням гишүүн болохоор бас Канадын төв мужуудын энэ барилгажилтын норм дүрмүүдийг нутагшуулъя гэж байгаа юм. Манайх шиг ерөөсөө байна шүү дээ тэ зураг зураад түүнийг нь батлаад түүнд нь хяналт тавьж явдаг ийм гаж тогтолцоо ерөөсөө байхгүй. Бид нар энэ барилгажилтын төслөө бариад тэрэн дээрээ хүн нь өөрөө барилгаа өөрөө зураад.../минут дуусав/

Х.Булгантуяа: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Энэ Улаанбаатарт орсон асуудлыг шийдвэрлэхээр оруулж ирж байгаа энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгэхээр Ерөнхий сайдыг байгаа дээр нэг асуудлыг бас ярих нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Тэгэхээр нийслэл Улаанбаатартаа өнгөрсөн хугацаанд анхаараад л бүх үйлчилгээ, бүх зүйлийг энд хамгийн сайн хийдэг болохоор тэр одоо сумаас ирж байгаа хүмүүс бүгдээрээ 2 мянган км явж үйлчилгээ байнга үзүүлж байхын оронд ерөөсөө Улаанбаатар руу шилжчихье гээд ингээд шилжилт хөдөлгөөн явагдаад тэрнээсээ болоод Улаанбаатар хотын ачаалал ихдэж байгаа юм. Тэгэхээр энэний эсрэг ямар арга хэмжээ авах ёстой вэ гэхээр бүсүүд төвтэй өөрөөр хэлбэл өсөлтийн төвтэй байх ёстой. Тэр бүсийн төвүүд нь Улаанбаатар хотод үзүүлж байгаа тэр үйлчилгээтэй адилхан үйлчилгээ үзүүлдэг нийгэм эдийн засгийн асуудлаа шийдвэрлэдэг ийм байх ёстой.

Тэгээд дээрээс нь тэр бүсүүдийн төвүүд нь Улаанбаатар хотын эсрэг татах хүч болох ёстой байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл тэр бүсийн төв дээрээ очоод л бүх зүйлээ асуудлаа шийдвэрлэдэг ийм л болчих юм бол заавал Улаанбаатар хот руу шилжих энэ хөдөлгөөн чинь багасна аа.

Тийм учраас манай одоогоор бол нийслэл хот Дархан, Эрдэнэт, Хархорум гээд улсын зэрэглэлтэй хоттой байгаа. Цаашдаа Чойбалсан, Даланзадгад, тэгээд өөрсөд чинь Чойбалсан мөн баруун бүс 5 аймагтай учраас Улиастайг ингээд 5 хотыг нэмж улсын зэрэглэлтэй хот болгох ёстой. Ингэх юм бол тэнд бүгдээрээ ямарваа нэгэн асуудал бүх тэр Улаанбаатар хоттой адилхан л үйлчилгээ үзүүлээд явах юм бол заавал Улаанбаатар хот руу ирж энэ өндөр өртөгтэй хотод амьдрах ямар ч шаардлага байхгүй болох юм байхгүй юу даа.

Тийм учраас энэ асуудлыг шийдвэрлэх ялангуяа энэ талаарх хууль эрх зүйн бичиг баримтыг оруулж ирэх тэр ажлыг хийх ёстой. Ер нь цаашдаа сумууд ч гэсэн яг энэ эдийн засгийн онцлог болон бусад нийгэм эдийн засгийн онцлогоос шалтгаалаад таталцлын төвтэй. Ингээд болох юм бол яах вэ тэр сумаас гарч байгаа хүн нь эхлээд таталцлын төв сум руугаа шилжинэ. Тэрний дараа аймаг руу шилжинэ. Аймаг дээр ирээд цаашаа Улаанбаатар хот руу шилжих үе шаттай тэр шилжилт хөдөлгөөнийг бий болгохгүй бол ер нь энэ Улаанбаатар хот чинь хөгжих хэрээр л тэр хүмүүсийн энд суурьшдаг тийм газар болж хувирна шүү. Тэгэхээр энэ дээрээ бас нэг хууль эрх зүйн юмнуудыг оруулж ирээрэй гэж хүсэж байна. Тэгэхээр энэ хуулийн дагуу бол нэлээн олон ажлуудыг хийнэ. Шинээр маш том том бүтээн байгуулалтууд хийнэ.

Ойролцоогоор 70 тэрбум долларын бүтээн байгуулалт явагдах юм байна. Тэгээд энийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийнэ гэж байхгүй. Барахгүй. Тэгэх юм бол жил болгоны улсын төсөв хүлээсэн ийм хөгжил гэж байхгүй.

Тийм учраас валью эксченж буюу ирээдүйд олох орлогоороо тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлдэг. Жишээ нь 5 дугаар цахилгаан станц гэж байж байхад тэнд ирээдүйд орлох орлогоороо бас нэг зарим нэг хөрөнгө оруулалтыг нь шийдэж өгдөг нөгөө хэсэг хэсгийг нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдээд тэрнийгээ концессоор шийдээд барих ашиг шилжүүлэх маягаар маягаар төлбөрөө аваад явдаг ийм системийг оруулж ирэхгүй бол энэ бүтээн байгуулалт чинь бараг явахгүй ээ.

Тийм учраас энэ дээр одоо би ажлын хэсэгт оръё гэж бодож байна. Тэгээд яг энэ асуудлыг бас нэг хурдтайгаар асуудлаа шийдвэрлэхийн тулд тэр хөрөнгө

оруулалтын асуудлыг шийдвэрлэх тэр концепц дээр нь бол орж ажиллая гэсэн ийм бодолтой байна. Тэгээд энэ талаар бас Ерөнхий сайдын хариултыг сонсьё.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Пүрэвдорж даргын асуултад хариулъя. Түрүүн Нямбаатар даргын бас хариулж байгаа зүйл дээр би бас нэмээд улс төрийн дүгнэлт гэх юм уу өнгөрсөн хугацаанд хот яагаад асуудалд орсон бэ? Үндсэн 3 шалтгаан байсан.

Нэгдүгээрт эрчим хүчнийхээ үнийг нэмэхээс айгаад нэг ч цахилгаан станц барьж чадаагүй. Тийм учраас цахилгаан станцаа дагасан дэд бүтэц дээр алаан болсон. Ингээд төлөвлөлтгүй газруудад газар олголтыг хийх ийм зүйл рүү улсаараа бүгдээрээ орсон. Ингээд цэцэрлэгийн арын газруудаас авхуулаад бүх дэд бүтэцтэй газруудад ийм арын хаалгаар ерөнхий төлөвлөгөөний бус газар олголт хийгдсэн. Энэ бол 1 дүгээр шалтгаан байсан.

Хоёрдугаарт хот мөнгө байгаагүй ээ. Парламент дээр орон нутаг дандаа олонх байдаг байсан, жижиг мажоритар тогтолцоотой байсан. Улсын төсвийн хөрөнгийг аваачаад уул уулын цаана нэг нэг ийм байшин болгоод ингээд явсан. Энэ тогтолцоогоор анх удаа хотоос сонгогдсон гишүүд жагсаалтынх нь парламентын олонх болж байгаа анхны тохиолдол. Тийм ч учраас бүсчлэгдэж байгаа энэ агуулга дээр энэ жилийн улсын төсвөөс авхуулаад эерэг хандлагууд олон байна аа.

Тийм учраас нийслэл Улаанбаатар хотын асуудал бол нийслэлийн асуудал биш гэдэг Ундрам гишүүнтэй би санал нэг байна. Энэ бид бүгдийн хамтын асуудал. Дээрээс нь хотынхоо ч асуудлыг шийдээд орон нутгийнхаа ч асуудлыг шийднэ гэхгүй бол зөвхөн орон нутаг хөгжсөнөөр Улаанбаатар хот хүнгүй болно гэдэг концепц бол энэ буруу концепц гэж би хувьдаа боддог. Яагаад гэхээр хот өөрөө хүнтэй байж байж зах зээлтэй байна аа.

Манайд нэг их тийм айхтар олон хот баригдах их хэмжээний ийм хүн ам байхгүй ээ. Тийм учраас 2-оос 3 том хот холдоо Хархорин мэдээж уул уурхайн томоохон бүсийн төвүүд, тэгээд Богд уулын цаана баригдсан Хөшигийн хөндий онгоцны буудлаа түшиглэсэн ийм л хот ирээдүйд баригдана. Өөр ямар ч гарц байхгүй.

Дээрээс нь Улаанбаатар хотод эрх мэдэл байгаагүй ээ. Яамдууд дээрээс нь ажлыг нь аваад хэсэгчлээд номерыг нь ч ЗТЯ салгаж аваад, дэд бүтцийг нь ч ЭХЯ салгаж аваад газар олголтыг нь хот байгуулалт нь салгаж аваад ингээд дундаа асуудал болдог байсан. Байгаль орчны яам хүртэл Богд уулыг нь аваачаад зарчихсан. Ийм асуудлууд ингээд явчихсан учраас нийслэл контрол алдаж эхэлсэн. Ингээд дарга буюу том улс төрчдөө дагаад ингээд том улс төрчдийн газрынх нь асуудлыг барилга барьсных нь дараа зөвшөөрлийг нь олгоод дүүрсэн хэрэг гээд л ингээд л явцгаасан байх үе үеийн хотын дарга нар. Тийм учраас энэ 2040-д бид нар бүгдээрээ дүгнэлт хийх ёстой. 2040 батлагдсанаараа одоо 3D хэлбэр дээр босгох ёстой гэж бодож байгаа хотыг.

Иргэд үүнийг мэдэх ёстой. Хаана байшин баригдахгүй вэ гэдгээ иргэд мэдэж хамгаалдаг байх ёстой гээд. Санхүүгийн модельтой холбоотой энэ.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофонд нэмэлт цаг өгөөрэй.

Л.Оюун-Эрдэнэ: Санхүүтэй холбоотой парламентын дэд дарга ийм асуудлыг хөндөж байгаад би талархаж байна. Парламентын гишүүддээ хэлэхэд ингээд төсөв алдагдалгүй болчихсон төсвөөр ямар ч том төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гэсэн үг. Нэг ч том төсөл хэрэгжихгүй болсон. Зөвхөн сургууль, цэцэрлэг, батлан хамгаалах болон төрийн үйлчилгээний зардал л цаашид төсвөөс санхүүжнэ. Засгийн газар баяртай байгаа. Энэ дээрээ бид нар хатуу зогсоно. Ирэх жилийн төсөв алдагдалгүй орж байна. Тэгвэл бид нар яах вэ гэдэг асуудал. Мэдээж бид нар төр хувийн хэвшлийн түншлэлээр хийнэ. Төр хувийн хэвшлийн түншлэлээр хийх төсөл ашигтай байх ёстой, ашиггүй байгаа төсөл рүү хувийн хэвшлийнхэн орох боломжгүй. Тэгэхлээр ВОТ-ийн төслүүдийг бид нар их сайн бодохгүй бол болохгүй ээ.

Хоёрдугаарт бид нарт байгалийн баялаг ялангуяа эрчим хүч болон эрчим хүчний нүүрс байна. Бусад одоо жишээлбэл БНХАУ ч юм уу дэд бүтцүүд байна. Үүнийг бид нар яаж бүтээгдэхүүн солилцох вэ гэдэг эрх зүйг нээхгүй бол яг одоо байгаа хурдаараа бас явахгүй ээ. Энэ бол бодитой зүйл.

Дээрээс нь концесстой холбоотой бас бусад асуудлууд дээрээ яаж зөв эрх зүйн орчин олох вэ гэдгээ шийдэхгүй бол болохгүй.

Дээрээс нь тендерийн хуулиа өөрчлөхгүй бол ерөөсөө том төслүүд явахгүй ээ Тендерийн хууль. Энийг Сангийн яам эд нар үнэнээ ярих ёстой. Одоо ингээд нөгөө нэг бүх зүйл дээр ингээд нөгөө энэ дээр чинь ингэчихвэл буруу харагдчих болов уу ингэчихвэл яах болов уу гэж явсаар байгаад одоо нөгөө эрчим хүчнийхээ үнийг нэмэхгүй 30 жил болчихдог шиг. Тендерийн хууль юу вэ гэхээр шүүх тендер шалгаруулах л хууль манай хууль. Одоо наад нийт мега төслүүдийн чинь 60 хувь шүүх дээр шийдэгдчихсэн байгаа. Шүүгч нар л очоод барилгын асуудлыг шийдчихсэн, шүүгч нар л тэнд байшин барьсан. Тэгээд хуулийн байгууллагынхны л яг үнэнийг хэлэхэд Тендерийн хууль болчихсон. Одоо энийгээ парламент зоригтой шийдэхгүй бол энэ.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмээд өгчхөөрэй. 1, 1 минутаар өгөөд байхаар.

Л.Оюун-Эрдэнэ: Ерөөсөө дээрээс нь гадаад эксперт, гадаад мэргэжилтнээс айдаг зүйлээ болих ёстой. Бид чадахгүй бол гаднын мэргэжилтнүүдийг авчрах ёстой ажиллуулах, ёстой цалинг нь өгөх ёстой. Тэгэхгүй бол нөгөө нэг хүнээр юм хийлгэхгүй, хийх хүнийг ажиллуулахгүй. Тэгээд нөгөө Тангадын хараал гэдэг шиг тэ өөрөө юм хийхгүй. Хийдэг хүнийг ажиллуулахгүй, мөнгө байхгүй, хөрөнгө оруулалт хийе гэхлээр хийлгэхгүй. Нэг ийм байдалтай асуудал дээрээ энэ парламентад би дүн шинжилгээ хийж чадах юм байна гэж бас бодоод байгаа юм. Энэ том төслүүд дээр ч гэсэн. Тэгээд л нэг ордон тойроод жагсахаар л нэг 20 хүн төсөл болгон дээр жагсаж байдаг. Тэгээд дундаас нь мөнгө авч байдаг. Тэгээд мессеж бичээд айлгаж байдаг. Тэгээд ийм нөхдүүдээс айгаад байвал улс яаж урагшлах юм.

Тийм учраас хотын асуудлыг ч гэсэн шийдье гэвэл одоо энэ эрх зүйн орчин түрүүн үнэн. Ерөнхий төлөвлөгөөгөө хэрэгжихгүй бол энэ тэгээд л ялтай л байх ёстой шүү дээ. Тэгэхгүй бол ерөнхий төлөвлөгөө батлаад яах юм. Тийм учраас ийм ийм асуудлуудаа хэдүүлээ энэ 2040-ийн хүрээнд цогц байдлаар ярья аа. Нийслэлийг дэмжих жил болгоод зарласан энэ цаг үедээ асуудлуудаа сууриар нь

шийдэж авъя гэдэг л ийм агуулгаар бас өнөөдөр энэ илүү тийм нээлттэй хэлэлцэх нь туйлын чухал гэж бас бодож байгаа. Тэгээд Засгийн газрын хувьд оруулаад ирж болно.

Их Хурал дэмжиж байгаа тохиолдолд хэдүүлээ төлбөрийн ямар нөхцөл байх вэ гэдгээ нээлттэй ярилцъя.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Нийслэл Улаанбаатар хотын хуримтлагдсан асуудал бид бүгдийн л сайнтай муутайгаа бид бүгдийн л хамтын бүтээл. Тэгэхээр энэ бас ирээдүйн төлөвлөлтийг харсан баримт бичиг орж ирж байгаа нь бас их зөв зүйтэй. Зүгээр энэн дээр хэдэн зүйлийг цөөхөн зүйлийг бас нэмж энэ үзэл баримтлалынх нь түвшинд бас хэлэлцэж эхэлж байгаа болохоор тодруулъя санаа бодлоо хуваалцъя гэж байна.

Нэгдүгээрт нь Улаанбаатар хотын төлөвлөлтийн асуудал ирэх 40 он хүртэл төлөвлөлтийн асуудал орж ирж байна аа. Улаанбаатар хот маань өнөөдөр Монгол Улсын хувьд хүн амын тал нь амьдардаг. Эдийн засгийнх нь дал орчим хувь нь багтдаг ийм бараг Монгол Улс шахуу болчихсон ийм засаг захиргааны нэгж. Гэтэл яг энэ Монгол улсынхаа асуудлыг нийтэд нь бид нар томьёолж нэг удаа харахгүйгээр Монгол Улсын нутагшил суурьшлын ерөнхий төлөвлөгөө гэдэг бодлогын баримт бичиг бас гарах ёстой. Энийгээ нийтэд нь ярихгүйгээр шууд улсын эдийн засгийн дийлэнх хүн амын талаас их хүн амьдарч байгаа энэ бүтцийг дангааранг нь ингэж тасдаж аваад эхлээд батлах нь өөрөө хэр зохистой вэ? Эхлээд батлах нь.

Тэр Хархорум хот ямар чиглэлтэй байх юм, хэдэн хүн амтай байх юм. Бусад аймгийн төвүүдийн хөгжлийг яаж харж байгаа юм. Энэ том газар нутаг дээрээ бид нар хүн ам, соёл бас тусгаар тогтнолынхоо хувьд яаж амьдрах юм гэдэг энэ том асуудлаасаа Улаанбаатар хотын асуудлаа бас эндээсээ салаалж ярихгүй болохоор шууд тусад нь аваад Улаанбаатар хотын хөгжлийг ярих нь зүйтэй ч гэсэн түрүүлж ярихаар. Тэгэхээр эндээс тэр нутагшил суурьшлын ерөнхий төлөвлөгөө гэдэг бодлогын баримт бичиг хаана явж байгаа вэ тэр тэр лав л шинэчлэгдээгүй ойрын үед. Тэгэхээр энэнээсээ асуудлаа эхлэх ёстой байсан уу энэ тухай нэг тайлбар өгөөч, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь Улаанбаатар хотын төлөвлөгөө хөгжлийн төлөвлөгөөг харж байна л даа. Дэд бүтцийн маш их олон ажлуудыг энэ дээр ингээд төлөвлөгдөж энэ бол мэдээж зөв зүйтэй. Тэгэхдээ аливаа ажлыг эхлэхэд аливаа ажлыг эхлэхэд тэр тусмаа хот гэдэг өөрөө амьд бүтэц, амьд систем, амьд систем, өөрийн онцлогтой, ялгаралтай, динамиктай, өөрийн характертай байдаг. Тэгэхээр Улаанбаатар хотыг бид нар ингээд хатуу дэд бүтцийг нь ярихаасаа урьдаар Улаанбаатар хот гэдэг цаашдаа ямар онцлогтой, ямар ялгаралтай, ямар характертай ийм нийгмийн байгуулал байх юм. Энийгээ энэ бодлогын баримт бичиг дээрээ тодорхойлоод энэнд чиглэсэн тэр хард дэд бүтцүүд маань ингэж явна. Улаанбаатар хот өрнө дорнын соёлын огтлолцол дээр байгаа Төв Азийн хот юм уу? Магадгүй ирээдүйд ИТ залуучууд Индастриал чиглэлийн санхүүгийн төв тал руугаа хөгжих юм уу? Яг яаж түүхэн хот юм уу? Эзэнт гүрний улбаа юм уу? Энийгээ тодорхойлж энэн дээрээ том ач холбогдол өгч энэ концепт гэдэг энэ зүйл дээрээ ач холбогдол өгөөд энэний одоо

дараа хард зүйл рүүгээ орохгүй болохоор шууд ингээд баахан хард зүйл энэ дээр харагдаад байна л даа.

Тэгэхээр тэр бодлогын баримт бичиг үзэл баримтлал гэдэг концепт гэдэг Улаанбаатар хот ер нь ямар характертай юм. Тэр тусмаа Улаанбаатар хотын онцлог ялгааг ярихын тулд магадгүй энийг бид нар үнэхээр ач холбогдол өгч зөв томъёолох юм бол Улаанбаатар хотын нэрийн асуудал хүртэл энэн дээр яригдах л ёстой. Тэр концептод тэр үзэл баримтлалд тэр онцлог ялгаралд тэр ирээдүйд чиглэж яг Улаанбаатар гэдэг энэ нэр маань жишээ нь нийцэж байгаа юм уу үгүй юм уу гэх мэтээр тэр онцлог ялгарал, тэр софт зүйл, энэ зүйл рүү хэрхэн яаж анхаарч байгаа вэ гэдэг зүйл дээр нэг бас нэг тайлбар өгөөч. Тэгэхээр энэ үзэл баримтлалын шинжтэй зүйлүүдээс ингээд тодруулъя. Деталь олон зүйлүүд дээр дараа дараагийн хэлэлцүүлгүүд дээр ярих боломж бололцоонууд бас гарах байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Баярлалаа. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа алсын хараа 2050 бодлогын баримт бичиг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлж бид нар тодорхойлсон. Энэ ерөнхий төлөвлөгөөгөө бид нар маш олон жил явж байна Цогтгэрэл гишүүн ээ.

2021 онд яг ингээд Их Хурал руу оруулах гэж байхад яг саяын таных шиг зүйлүүдийг тухайн үед бас Засгийн газрын зарим гишүүд ярьсаар байгаад ингээд үндсэндээ 4 жил энэ ерөнхий төлөвлөгөөг ингээд хойш нь татсан. Би таны ярьж байгаа энэ дүр төрх гэж бид нар оруулсан л даа 2040 дээр Улаанбаатар хотын дүр төрхийг иргэдийн олон нийтийн хэлэлцүүлэг AI олон зүйл ашиглаж яахад Улаанбаатар нь 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаснаар байгаль орчинд ээлтэй, оршин суугчдын амьдрах таатай орчин бүрдсэн зөөлөн хотын дараах үндсэн шинж чанаруудыг агуулсан олон төвт хот болж хөгжинө.

Үүнд оршин суугчдын ая тухтай амьдрах орчин аюулгүй, орчны хүртээмжтэй, нийгмийн үйлчилгээний хүртээмж буюу 20 минутын хотын шинжийг хадгалсан олон төрлийн орон сууцын хангамжтай оршин суугч иргэдийн оролцоотой хот төлөвлөлт хөгжилд оршин суугч иргэдийн санаа бодлыг тусгаж хамтын ажиллагаатай байх хууль эрх зүйн орчны тогтолцоотой ийм хот болон хөгжинө гэсэн ийм зорилтыг дэвшүүлж байгаа юм. Зүгээр ер нь Улаанбаатар хот газар зүйн байршлын хувьд яг Сибирийн газар зүйн бүтцийн төгсгөл тал хээрийн эхлэлийн дунд оршдог ийм онцлогтой хот гэж үздэг. Нөгөө талаасаа Улаанбаатар хот бол бас эртний түүхийн археологийн олон олдвор эд зүйлс олдсон ийм хот байгаа. Түүх ярих юм бол Улаанбаатар хотын түүхийг бол Өндөр гэгээнийг Ширээт цагаан нууранд хаан ширээнд залснаас хойш 1639 оноос хойш Улаанбаатар хотын түүхийг эдүгээчлэл хүртэл татаж үздэг ийм бас түүх талаасаа онцлогтой хот. Би тэгээд таны энэ Улаанбаатар хот яг ямар хот болж харагдах гээд байгаа дүр төрхийг бид нар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгажилтынхаа төслүүдээр гаргая гээд анх удаагаа Улаанбаатар хот олон улсын нээлттэй тендерийг зарлахаар бэлдэж байгаа. Майскигийн тэмдэглэлд 100 жилийн өмнөх тэмдэглэлд Улаанбаатар хотыг дорнын хот байна их тийм өвөрмөц онцлогтой хот байна гэж тэмдэглэж 1921 онд Эрхүүд хэвлэгдсэн тэмдэглэлд дурдсан байдаг.

1960-аад оноос хойш Улаанбаатар хот маань өмнөд хөршийн тусламжаар нэлээдгүй барилга байгууламж баригдсан нэлээн сонгодог хэлбэрийн барилга байгууламжууд баригдсан. 1960-аад оны сүүлээс Оросын Зөвлөлтийн барилгачид орж ирээд нэлээд тийм модерн хэв маягтай болсон. Одоо СТӨ дуурийн театр хоёр 2 өөр улсын дэмжлэгээр баригдсан. Тэгэхээр бид цаашид энэ хотынхоо өнгө төрх.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын Ерөнхий сайдын микрофоныг өгье. Бүсийн хөгжилтэй холбоотой.

Л.Оюун-Эрдэнэ: Цогтгэрэл даргатай санал нэг байгаа. Нийслэл Улаанбаатар хотын асуудлыг 21 аймаг, бүсийн төвүүдтэйгээ хамт авч үзэж таталцлыг, хот хөдөөг хамтад нь хөгжүүлэх ийм концепц бол туйлын чухал. Одоо энэ ч агуулгаараа тойрог бүсчлэгдсэн. Тийм учраас илүү тийм том төслүүд яригдах агуулгыг томоор нь харах. Аймгууд бие биедээ байгаа боломжийг харах ийм боломж үүссэн гэж үзэж байгаа. Сая аймгийн дарга нар томилогдоод хурлын дарга нартай хамт цугласан. Засгийн газар өргөтгөсөн хурал хийсэн. Энэ дээр бас энэ асуудлыг ярьсан. Одоо чуулган завсарлаад би бас гишүүддээ мэдээлэл өгөхөд цагаан сарын ард талд наадмын өмнөхөн буюу хаврын чуулган дуусахаас өмнө бүх бүсүүд дээр одоо бүсийн зөвлөлийн хурлууд зохион байгуулагдана. Тэр хурал дээр парламентын бүсээс сонгогдсон гишүүд аймгуудаас 3 аймаг байлаа гэхэд бүх иргэдийн хурлын төлөөлөгчид, тэгээд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ очиж бас ийм хамтарсан хурал хийе ээ гэж. Гэхдээ мэдээж албан ёсны шийдвэр гаргахгүй, зөвлөмж гаргая. Энэ агуулга дээр юу байх вэ гэхээр 2040 он хүртэлх нийслэлийн энэхүү ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан байдлаар бүх бүсүүд 2040 оны ерөнхий төлөвлөгөөг гаргах энэ агуулгаа танилцуулъя гэж байгаа.

Хоёрдугаарт нь ер нь бүсийн эрх зүйн бүтэц зохион байгуулалт цаашдаа ямар байх юм бэ гэдэг асуудал. Нутаг дэвсгэрийн нэгжийн хуульдаа өөрчлөлт оруулах юм уу, төсвөө яаж бүрдүүлдэг байх юм. 3 аймаг гэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтарч хуралддаг механизм байх уу үгүй юу зэрэг бүтэц зохион байгуулалтын хувьд хэдүүлээ хамт нэг ярилцъя. Төслүүдээ яаж хэрэгжүүлдэг байх юм бэ? Орон нутгийн сангуудыг хэрхэн нэгтгэх юм бэ зэрэг ийм асуудлууд байгаа. 2026 оны улсын төсвийн саналыг Сангийн яамнаас авъя гэдэг ийм 4 үндсэн бүлэгтэйгээр энэ уулзалтуудыг хийе ээ гэж байгаа юм. Тэгээд энэ уулзалтуудыг хийгээд одоо наадмын үед улсын төсөв хэлэлцэх үед илүү бүсүүдийн мэдээлэл дээр мөн бүсүүдэд ингээд гаргачихсан. Энэ дээрээ тулгуурлаад хоттой яаж уялдах вэ гэдэг энэ зүйлийг бид нар эрх зүйн хувьд нэлээн мэдээлэлтэй болчихсон байх нь зүйтэй болов уу. Гэхдээ нийслэл Улаанбаатар хотын төлөвлөгөөг бүсүүдийн төлөвлөгөө гарсны дараа хийнэ гэхээр цаг алдана. Өмнө нь 3 ч удаа ороод энэ нэгтгэгдчихсэн хувилбар гэсэн үг.

Тийм учраас энэ төлөвлөгөөгөө баталж хэрэгжүүлээд эрх зүйн хувьд нь хариуцлага тооцох бүх механизмуудаа гаргаад яаралтай тэр 3D рүү ороод Улаанбаатар хот барилгажилт болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөө хийж байх үед бүсүүдийн ерөнхий төлөвлөгөөн дээр бид нар.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Суух нь хугацааны хувьд зөв болов уу? Батсуурь сайд хариулах байх. Ер нь бид нар орон нутаг аймгууд бол ерөнхий төлөвлөгөөгүй яваад ирчихсэн гэж ер нь бараг хэлж болно. Ерөнхий төлөвлөгөөг өөр өөрийнхөөрөө

ойлгоод ирчихсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон барилгын зураг бол манайд бүүр ингээд гардаггүй. Түүнийг 3D ч юм уу оруулсан ийм зүйл байхгүй учраас одоо л бид нар үүнийг бүс бүсээр хийх нь зүйтэй юм гэж үзэж байгаа.

Дээрээс нь би бас парламентын гишүүддээ нэг зүйлийг бас уриалаад Ерөнхий сайдын хувьд би бас байр сууриа эртхэн илэрхийлчих нь зүйтэй болов уу гэж бодож байгаа юм. 2028 оны сонгуулийг бүсчилж хийхгүй ээ гээд манай гишүүд маань ингээд аймаг аймгийн Засаг дарга нартай яриад байгаа юм байна лээ. Буцаад бид нар аймаг руу ингээд жижгэрвэл тэгээд энэ улсын энэ төвлөрөл бүүр л илүү их хүндэрнэ шүү. Дархан, Сэлэнгэ 2 нэг нь хоттой, нэг нь газар нутаггүй болохоос эхлээд л буцаад л асуудлууд болно.

Тийм учраас нэгэнтээ бид нар ингээд бүсчлэгдчихсэн юм чинь бид нар энэ бүсчилсэн энэ үзэл санаанаасаа ухрахгүйгээр харин бүсчилсэн үзэл баримтлалаа яаж бид нар илүү эрх зүйн хувьд баталгаажуулах вэ гэдэг рүүгээ л явах нь хамгийн зөв болов уу.

Энэ дээр би Ерөнхий сайдын хувьд хатуугийн хатуу байр суурьтай цаашдаа зогсоно аа. Нийгэмд уриална. Орон нутгуудаар явж би бүсийн хөгжилтэй холбоотой энэ асуудлыг ярьж иргэдтэй шууд уулзалт хийнэ. Тийм учраас парламентын гишүүд маань бүсийн хөгжлөөс өөрийнхөө сонгогдох эрх ашгийн төлөө татгалзана гэдэг бол дэндүү харалган бодлого шүү. Хангалттай гучаад жил явлаа 34 жил. Одоо бид нар асуудлыг том агуулгаар нь өөрчлөх ийм зориг гаргах цаг шүү. Тэгэхгүй бол 30 жилийн дараа бахь байдгаараа л байна.

Тийм учраас энэ дээр бас бид нар парламентын эрхэм гишүүд, ялангуяа бүсээс сонгогдсон, орон нутгаас сонгогдсон парламентын гишүүд маань бас дэмжиж улс төрийн хувьд нэгдмэл байр суурьтай байхыг Засгийн газрын тэргүүний хувьд бас хичээнгүйлэн хүсье ээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал.

О.Батнайрамдал: Баярлалаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бас бий болсон 126 гишүүнтэй бас анхны парламентын бас анхны ээлжит чуулган бас завсарлах өдөр тохиож байна. Яг өнөөдөр бид нар энэ парламентын ордонд суугаад ингээд шийдвэр гаргаж байгаа энэ үйл явц парламентын засаглал Монголд байх уу үгүй юу гэдэг түүхэн шийдвэрт бас онцгой үүрэг гүйцэтгэсэн бас нэг түүхэн манлайлагчийг өнөөдөр бид нар яг энэ өдөр үдэн гаргаж байна. Бидний анхны ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат бас нэр хүндтэй, нэр нүүртэй өөрийн гэсэн бас өвөө үлдээсэн зөв шударга ард түмнийхээ талд дандаа зогсож чадсан ард түмнийхээ хайрыг бас хүлээж чадсан ийм төр нийгмийн зүтгэлтэн байж болдгийг залуу үе бид нартай харуулж чадсан орчин цагийн Монголын бас нэгэн томоохон манлайлагч гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэхүү завшааныг ашиглаад бас түүний гэр бүлд гүн эмгэнэл илэрхийлье.

Бидний хойч үе энэ хүний бас хийсэн бүтээсэн өвийг үргэлж бас санаж явах учиртай гэж бодож байгаа юм.

Миний хувьд нийслэлийн Улаанбаатар хот 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөө маань ингээд орж ирж байна. Талархалтай хүлээж авч байна. Эдийн засагчийн хувьд хөрөнгө оруулалттай холбоотой хэдэн асуулт байгаа юм аа. Бид

нар ер нь бол томоохон төслүүдийг дараагийн 2040 он хүртлээ урагшлуулъя гэж байна. Хамгийн том бидний даваа бол ерөөсөө л санхүүжилттэй холбоотой. Энэ дээр нэг зүйл байгаа юм. 2025-аас 2030 ондоо бид нар нэг 96 тэрбум төгрөг их наяд төгрөгийг төслүүдийг явуулъя. Энэний төсвөөс 59 хувийг, хувийн хэвшлээс үлдсэнийг нь гээд. Гэхдээ 2030-2040 улам цаашлах тусам урт хугацаандаа бид нар илүү хувийн хэвшил давамгайлсан хувийн хэвшил нийтдээ нийт санхүүжилтийн 57 хувийг босгохоор ингэж орж ирж байна л даа. Тэгэхээр энэ миний хувьд зөв гэж бодож байгаа юм. Тэгээд ер нь дэлхийн томоохон хотуудын бас урт хугацааны ерөнхий төлөвлөгөөг харлаа. Сөүл, Лондон, Сингапур.

Тэгэхээр ер нь бол ер нь аягүй ойролцоо юм байна лээ. Санхүүжилтийн хэлбэрийн хувьд. Харин эд нар дээр гарч ирсэн бас нэг цоо шинэ хөрөнгө оруулалтын хэлбэр гарч ирсэн байна. Бараг сүүлийн бараг 5, 6 жил гарч ирсэн крауд фаундинг буюу олон нийтийн санхүүжилтийн хэлбэр гэсэн үг. Ер нь Сөүл, Лондон, Сингапур бүгдээрээ урт хугацааны санхүүжилтээ 5-аас 10 хувийг нь олон нийтийн санхүүжилтээсээ босгоё гэж тодорхойлсон байна лээ. Энэ нь яг юу гэсэн үг вэ гэхээрээ орон сууцны нэг хэсэг иргэд дундаа байгаа одоо жишээлбэл ногоон байгууламжаа дундаасаа буюу олон нийтийн санхүүжилтээр босгоод. Ингэхээр нөгөө олон нийт иргэдийн оролцоог улам сайжруулж тэрнийгээ илүү хайрлах, урт хугацаандаа ашиглах тэр бас хөшүүргийг нь давхар өгч чаддаг болохоор энэ өөрөө бас аягүй инновацлаг шинэ гарч ирсэн хөрөнгө оруулалтын хэлбэр байгаа юм. Тэгэхээр энийг ч гэсэн бас манай Улаанбаатар хот цаашдаа хөрөнгө оруулалтын хэлбэртээ бас тусгаж аваасай гэж 1 дүгээрт бодож байгаа юм.

Хоёрдугаарт бас энэ хэлэлцүүлгийг бас Улаанбаатар хотын олон иргэд үзээд сууж байгаа байх гэж бодож байгаа юм. Тэр дундаа манай Сүхбаатар, Чингэлтэйн 14, 18 дугаар хороон дээр баригдаж байгаа Сэлбэ дэд төвийг түшиглэсэн гэр хорооллыг бас орон сууцжуулж байгаа бас нэлээн том хүлээлттэй төсөл маань амжилттай хэрэгжээд явж байгаа. Даргаа цагаа сунгаад авчихъя.

Нийт иргэдийн би энэ дээр хэлмээр байгаа юм 96.5 хувийн дэмжлэгтэйгээр 158 га газрыг бид нар амжилттай чөлөөлж чадсан 300 орчим тэрбум төгрөгийн нөхөн ор олговрыг бид нар санхүүжүүлж чадсан. Одоо энэ дээрээ 12 мянган айлын орон сууцыг бонд босгож барихаар төлөвлөж байгаа. Тэгэхээр энэ ажил маань бас хэр яваа бол. Манай сонгогчдоос бас нэлээн асууж байгаа. Ер нь цаашдаа бас бид нар Улаанбаатар хотын гэр хорооллыг энэ ерөнхий төлөвлөгөөнийхөө хүрээнд орон сууцжуулах дээр бас та тодорхой бас энийг үзээд сууж байгаа иргэддээ бас хариулт өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Баярлалаа.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар дарга хариулах уу?

Х.Нямбаатар: Баярлалаа. Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах авто замын түгжрэлийг бууруулах гэдэг ийм анхдагч хуулийн төслийг 2023 оны 12 сард Улсын Их Хурлаар батлуулсан. Энэ хуулийг дагаад Улаанбаатар хотод цаашид газар олгох журам газар албадан чөлөөлөх журам бас батлагдсан. Энэний дагуу бид нар Сэлбэ дэд төв, Чингэлтэй, СБД-ийн нутаг дэвсгэрийг дамнасан 158 га газар дээр байгаа. 2206 айлыг чөлөөлж 12 мянган айлын орон сууцын төсөл хэрэгжүүлэх ийм төслийг эхлүүлсэн.

Өнөөдрийн байдлаар үндсэндээ 2206-аас газар чөлөөлөх боломжгүй. Төрийн байгууллагууд том капитал барилгуудтай 200 гаруй нэгж талбар байна аа. Ингээд бид нар 2 мянгыг чөлөөлөхөөс 1800 айлыг нь чөлөөлчихсөн байна. 200 орчим айл дээр бичиг баримтын зөрчилтэй болон үнэ дээрээ ойлголцох асуудлууд яригдаж байгаа. Бид 4, 5 сар гэхэд үндсэндээ энэ газар чөлөөлөлтийн ажил дуусна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Тендер сонгон шалгаруулалтын ажил бол 2 дугаар сарын 28-аас өмнө тендерийн 4 багц 12 мянган айлын орон сууцын 4 багц тендерийг зарлах бэлтгэл ажил ингээд хангаад тендерийн баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна. Зураг төсөв барилгын хийцийнхээ асуудлыг эцэслэсэн. Ингээд бид нар олон метр квадратуудын давхартай сонголттой, доороо зоорийн давхартай автомашины дулаан зогсоолуудтай, байрны дундах байгууламжуудыг нь ногоон байгууламж голчилсон ийм байдлаар төлөвлөлт хийж байгаа. 20 минутынхаа хот гэдэг концепцыг шингээж байгаа.

Нэмж 3 ЕБС 5 цэцэрлэг барихаар бас төлөвлөж байгаа. 60, 40-ийн харьцаатай анхны Улаанбаатар хотын ийм ногоон байгууламж бүхий 20 минутын хот байхаар ингээд төлөвлөөд явж байгаа. Тендер сонгон шалгаруулалтын ажил ингээд 28 гэхэд тендер нь зарлагдана ажлын 20 хоног тендерээ хүлээж авна, 20 хоногийн дараа. Ингээд цаашид ер нь бид нар аль болох хугацаа сунгахгүйгээр тодруулгуудыг тухай бүрд нь өгч явъя тендер сонгон шалгаруулалтаа нэлээн шуурхай явуулъя гэдэг ийм төлөвлөлттэй байгаа. Ингэж явж чадвал бид нар нэг 4 сарын сүүл 5 сар гэхэд гэрээ байгуулаад ажил эхлүүлнэ ээ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Санхүүжилтийн 500 сая ам.доллар ороод ирчихсэн байгаа. Сая бид нар оны өмнө оруулж ирсэн. Валютын нөөц бас 500 сая доллароор нэмэгдсэн байгаа. Эрсдэлийг бууруулах зорилгоор бид нар арилжааны банкнуудад босгосон зээлийн хүүгээсээ арай нэмүү зээлийн хүүгийн өртгөөр арилжааны банкнуудад тендер сонгон шалгаруулалтаар мөнгөө байрлуулаад хадгалж байгаа. Тэгээд 6 сараас эхлээд гүйцэтгэлээр санхүүжилт хийнэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Би Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ, хотын дарга Нямбаатар 2-оос асуулт асууна аа. Асуултыг асуухаас өмнө ерөнхий 1 удиртгал хэлэхэд сая бид нар 11 сард парламент стратеги төлөвлөгөөгөө 4 жилээр баталсан эндээ бол 5 тулгууртай гээд Булгантуяа дарга ахалсан. Эндээ 1 дүгээрт нь болох юм бол хүн төвтэй гэдэг энэ зарчмыг оруулчхаж байгаа юм. Тэгэхээр өөрөөр хэлбэл Улсын Их Хурлаас гарч байгаа бүх шийдвэрүүд хүн төвтэй байх энэ шалгуур үзүүлэлтийг хангах ёстой гэсэн нэг зүйл.

Хоёрдугаарт бид нар ингээд төсөв яригдаад төсөв батлах энэ процесс явсан. Төсвийг 2025 оны хөгжлийн хөтөлбөр дагуулж орж ирсэн. Нэгд эдийн засаг, 2-т бүсчилсэн хөгжил, 3-д Монгол хүн, 4-д Монгол хүний эрх чөлөө. Тэгэнгүүт энд нэг дунд нь нэг алдаа гараад байгаа юм. Юу гэхээр төсвийг үндэсний аюулгүй байдлын бодлогын бичиг баримтад нийцэж байгаа эсэхийг Аудитын газар хянах ёстой. Дүгнэлт дээрээ хянахгүй орж ирээд байгаа юм. Яагаад хянаагүй юм бэ гэхээрээ ҮАБЗ-өөс бичиг баримтад төсөв нийцэж байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох ёстой хууль дээрээ. Гэхдээ шалгуур үзүүлэлт нь гараагүй. Тийм учраас та ҮАБЗ-ийн гишүүний хувьд энэ шалгуур үзүүлэлтийг яаралтай гаргаач ээ гэж байгаа

юм. Энэ шалгуур үзүүлэлтүүд гарч байж аюулгүй байдал болон энэ төсөв шийдвэр гаргалтууд чинь хоорондоо уялдах гээд байгаа юм. Яагаад Үндэсний аюулгүй байдал яриад байгаа юм бэ гэхээрээ Нямбаатар дарга руу чиглэж байгаа асуулт нь болохоор Улаанбаатар хотын яг ингээд алсын дүүргүүдээ оруулахаар 4700 км квадрат байгаа юм. Тойрсон 3 аймгаа ингээд тооцохоор 118469 мянган км квадрат, 350 мянган хүн энэ тойрсон 3 аймагт нийтдээ Улаанбаатар хотын иргэдтэй нийлээд 2 сая 300 мянган хүн. 1000565 мянган км квадрат нутаг дэвсгэрээс асар бага нэгж дээр хүн амын бараг жараад хувь нь оршиж орж байгаа.

Ингээд утаа орчны бохирдол гээд энэ аюул нь өөрөө үндэсний аюулгүй байдлын түвшинд буюу зэрэглэлд хүрчихсэн байгаад байгаа юм. Тийм учраас өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа 2050 алсын хараа болон бусад 10 нийт 11 бодлогын бичиг баримтын нэг нь бол Улаанбаатар хотын энэ 2040 хөтөлбөр байгаад байгаа юм. Энэ утгаараа энэ бичиг баримт өөрөө үндэсний аюулгүй байдлын түвшинд хүрсэн асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ? 2 асуудлыг.

Нэгдүгээрт нь болохоороо энэ төлөвлөгөөн дээр 30 он гэхэд 42 мянган орон сууц барьж, агаарын бохирдол 55.6 хувьтай болгоно гэсэн. 40 он гэхэд 78500 өрхийг орон сууцжуулаад агаарын бохирдол 37.8 хувьд хүрэх буюу 63 хувиар агаарын бохирдлыг шийднэ гэж байгаа юм. Энэ бид нар 15 жилийн тухай ярьж байгаа. 15 жилийн тухай ярьж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр жишээлбэл өдөрт хорт хавдраар 14 хүн нас барж байна. Жилд 3, 4 мянган хүн хорт хавдартай болж байна гэж байгаа юм. Миний хэлэх гэж байгаа санаа болохоор энэ хөтөлбөрийг бүхэлд нь дэмжиж байгаа Нямбаатар дарга аа. Гэхдээ 2040 он хүртэл хэтэрхий удаан байна гэж үзэж байгаа юм. 15 жил дахиад агаарын бохирдолтой ийм удаан аргаар тэмцмээргүй байна аа. Яагаад гэвэл энэ үндэсний аюулгүй байдлын түвшинд хүрчихсэн учраас. Нөгөө өвчлөл дээр цохилтын тун гэдэг шиг бүүр хурдтайгаар явмаар байгаа юм. Энийг бол зүгээр нэг яам хоорондын ЭМЯ ч юм уу, байгаль орчин, уур амьсгалын яам хоорондын ч юм уу салбарын асуудал гэхээс илүүтэйгээр сүүлийн 10 гаран жилийн хугацаанд энэ агаарын бохирдолтой тэмцэх субъект нь өөрөө 8 удаа өөрчлөгдсөн байх жишээтэй.

Тийм учраас энэ дээр Их Хурлаас ч юм уу энэ сонсголууд явагдаж байна. Түр хороо байгуулаад энэ дээр тодорхой тооны ил тод зарцуулалттай төсвийг зарцуулаад энэ агаарын бохирдлын асуудал Монгол Улсын хүний иргэний амьд явах эрүүл аюулгүй орчинд ноцтойгоор хохирол учруулж байгаа асуудалтай ингэж холбож авч үзмээр байгаа юм. Их Хурлын гишүүддээ ч гэсэн уриалахад энэ бол дан нийслэлийн асуудал юм уу салбар яамдын асуудал биш. Энэ бас бидний дундын асуудал байгаа юм аа. Тэгээд Нямбаатар даргад би бас урам өгөхийг хүсэж байгаа. Зурагтаар ингээд хүн загнаад байдаг их түрэмгий хүн юм байх гэж бодсон. Гэхдээ яг ингээд нөгөө талаасаа асуудлыг шийдэх гээд байгаа зоригийг нь үнэлж байгаа юм. Тэр утгаараа энэ агаарын бохирдол орчны бохирдол гэсэн энэ асуудлуудыг энэ том бодлогын бичиг дотроо ингээд.

Х.Булгантуяа: Нэг минут нэмж өгье. Эрдэнэболд гишүүнд.

С.Эрдэнэболд: Эрэмбийнхээ эхний хэсэг рүү оруулаад заавал 15 жилийн хугацаа гэж сунгалгүйгээр маш хурдтайгаар энэ утааны яндангүй болгох тэр 170, 180 мянган эх сурвалж нийтдээ өрх гэрээс гадна 190-ээд мянган энэ голомтыг байхгүй болгох буюу орон сууц сууцжуулах ажлыг ингэж хойш нь тавилгүйгээр бүр хурдтайгаар хөрөнгө оруулалтыг хиймээр байна аа. Энэ дээр хариулт авъя аа.

Эхний асуулт Ерөнхий сайдаас яг тэр шалгуур үзүүлэлтийг гаргаагүй байгаад байгаа. Үүнийг ойрын хугацаанд гаргах боломжтой юу гэж асууя. Нямбаатар даргаас сүүлийн асуултуудыг асууя.

Х.Булгантуяа: Эхлээд Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ төлөвлөгөө хүн төвтэй яаж амьдралын чанарыг дээшлүүлэх вэ л гэдэг л ийм төлөвлөгөө. Бусад хотын төлөвлөгөө ч гэсэн тийм л байгаа. Яг үзвэл ногоон байгууламжийн стандартыг 20 минутын концепцын дагуу дээшлүүлэх, сургууль, цэцэрлэг, онцгой, цагдаа гээд төрийн үйлчилгээ 20 минут дотроо байх. 20 минут дотроо дэд бүтэцтэй байх, 20 минут дотроо төрийн үйлчилгээгээ авдаг болох гэдэг ийм стандарт руу энэ төлөвлөгөө чиглэгдэж байгаа гэж ойлгож болно. Хүнээр бол Улаанбаатар хот маань нэлээн өвдөөд ингээд мэс заслын ширээн дээр байж байгаа учраас арга буюу өнөөдөр бид нар ингээд нөгөө дэд бүтцийнх нь төслүүдийг л илүү яриад байгаа болж харагдаад байгаа юм. Яагаад гэхээр эрчим хүчгүй болчихсон шугам нь бүгдээрээ эвдэрчихсэн бүгдээрээ зэвтэй болчихсон. Тэгэхээр энэ асуудлуудыг шийдэхгүйгээр бид нар орон сууцжуулах ч юм уу шийдэх боломжгүй байгаа учраас эхлээд томоохон энэ эмчилгээ хийгдэх дэд бүтцийнх нь асуудлуудыг л шийдэх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Таны хэлж байгаатай санал нэг байна. Нийслэл Улаанбаатар хотод олон асуудлууд байгаа. Гэхдээ хамгийн их тулгамдаж байгаа 2 асуудал байгаа.

Нэг нь түгжрэл, нэг нь утаа. Утааны асуудлыг бид нар коксожсон нүүрс рүү буюу кокс түлш рүү буюу судлаачдын надад ойлгуулснаар жигнэж байгаа ийм технологиор нэг алхам ахих тэр нь түүхий нүүрснээс өнөөдрийг хүртэл явж байгаа сайжруулсан түлшний дараагийн алхам. Тэрний дараа газ тэгээд орон сууцжуулсан дэд бүтэцтэйгээ холбогдох энэ дарааллын дагуу явж байгаа. Энэ технологи руу шилжихэд бол 1.5 жил орчим хугацаа хэрэгтэй. Энэ дээр нийслэл Улаанбаатар хот төлөвлөлт гаргаад явж байгаа. Хэсэгчилсэн бас яндангүй бүс тогтоох асуудлыг бараг 2040 дээрээ тулгуурласан ийм Их Хурлын тогтоол гаргаад ингээд явчихвал илүү хялбар юм байна лээ. Энэ төлөвлөгөөг бас Хотын дарга Их Хурлын гишүүддээ бас нэг сайн танилцуулаад Одонтуяа дарга ч гэсэн тэр нөгөө үйл явц болон тэр нөгөө нэг үзүүлэлтүүдээ бас ингээд Их Хурлын гишүүддээ бас мэдээллээ өгчих нь илүү тустай байх болов уу гэж бодож байна. Түгжрэлийн хувьд маш энгийн шийдэл бол баруунаас зүүн тийш хойноос урагш нэмэх тэмдэг бүхий 2 хурдны зам баригдах түүнийгээ холбох 2 тойрог зам баригдах дээр л нийслэл Улаанбаатар хот нэгийг нь бусдыг нь мөнгийг нь босгож өгөөд зураг төсөв гаргах ийм л ажил руу явж байгаа. Энэ тохиолдолд одоо байгаа түгжрэл хамгийн багадаа 30-аас 40 хувь. Гэхдээ байгаа машин дээрээ шүү. Жил бүхэн эдийн засаг өсөөд л баахан машин орж ирээд байвал энэ тэгээд хүндрэлтэй л байх хэвээрээ л байх болов уу гэж бодож байгаа. Энэ тохиолдолд бол байгаа түгжрэлийн километрээр тооцох хурд бол багадаа 40-өөс 50 хувь.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Боломжтой байгаа. Зүгээр 2040-ийн хувьд энэ маш чухал гэж би дахин дахин хэлээд байгаа нь энэ төслүүдийг парламентын гишүүд маань бүгдээрээ нөгөө нэгдсэн ойлголттой л болчихмоор байгаа юм. Нийтдээ нэг 20-оод төсөл байх юм байна. Энэ нь тэр контрол таувер буюу хяналтын цамхгаас харвал 1 дүгээрт энэ нь байх юм байна, 2 дугаарт энэ нь байх юм байна 3 дахь нь 5 дахьтайгаа холбоотой юм байна. 5 нь 6 долоотойгоо холбоотой юм байна гэдэг л

нэгдсэн ийм уялдаа холбооны шийдлийг л контрол таувер гэж нэрлэдэг юм байна лээ. Монгол Улсад хэрэгжсэн төслүүд энэ дээрээ л алдаа гаргасан гэж үзээд байгаа. Тийм учраас ерөнхий төлөвлөгөө ингээд батлагдсанаас цааш 3D дээр барьснаас хойш одоо ийм замбараагүй олон төслүүд ярих биш бид нар 3D дээр хотоо харна л гэсэн үг. Хаана, юу баригдах юм, яах юм, ийх юм гэдгийг зүгээр кино театрт үздэг болгочихъё л гэж байгаа юм. Би зүгээр хотынхны шахаад байгаа зүйл нь тэр. Энэ олон мега төслүүдийг заавал иргэд ойлгох албатай биш. Энэ бол төрийн бодлогын баримт бичиг. Харин энэ төслүүд хэрэгжсэнээрээ ямар үр дүн гарах гээд байгаа вэ гэдгээ л маш энгийн байдлаар ойлгуул. Энэ зүйлээ салшгүй нэг хэсэг гэж үз ээ. Үүнийг парламентын гишүүд ч гэсэн яг адилхан ойлгох ёстой. Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид адилхан ойлгох хэрэгтэй. Хувийн хэвшлийнхэн бас хамтдаа яг адилхан одоо мэдээллийн зөрүүгүй болчихвол хүлээлт ямар түвшинд үүсэх юм, ямар түвшинд бид нар тэвчих ёстой юм? Аль шийдвэрүүдийг ямар дараалалтай гаргах юм бэ гэдэг бидний контрол таувер ажиллаж эхэлнэ ээ л гэж үзэж байгаа юм. Үлдсэнийг нь хотын дарга, Батсуурь сайд, манай 20 минутын хотын сайд энэ стандарт 20 минутын хот гэдэг бол ер нь хүнд ээлтэй хотыг л хэлж байгаа стандарт.

Х.Булгантуяа: 2 дахь асуултад эхлээд ажлын хэсгээс Нямбаатар дарга хариулах уу? Тэгээд араас нь Эрдэнэбүрэн сайд хариулчихъя.

Х.Нямбаатар: Яах вэ бид нар энэ 2040-ийн хэрэгжилтийг хэрхэн хангах вэ гээд дотоодын нийт бүтээгдэхүүнийг ойрын 15 жилд хэрхэн өсөх вэ гэдгийг тодорхой аргачлалын дагуу гаргаж ирсэн. Тэгээд таны ярьж байгаа зүйл бол шууд энэ бүх зүйлийг барилгажуул, маш хурдтай хөдөлөе л гэж байгаа. Тэгэхээр Монголд нэг үг байдаг. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийхээс өөр арга алга байна. Бид нар 15 жилийн дараа ДНБ-ийг 40 тэрбум ам.доллар-т хүргэе гэж байгаа юм. Өнөөдөр 20 тэрбум байгаа. Манай өмнөд хөршийн ӨМӨЗО-ы GDP 360 тэрбум төгрөг доллар байгаа. Зөвхөн Өвөр Монголынх. Манай Монгол Улсын нийт GDP 20 тэрбум доллар байгаа. Бид нарын жилийн төсөв 30 их наяд. Үүнийхээ 20 орчим хувийг хөрөнгө оруулалт зарцуулдаг. 20 орчим хувь буюу 6 их наяд төгрөгийг 21 аймаг.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 18 номерын микрофоныг нэмж өгье. Тэгэхээр бид нар нэг 6 их наяд төгрөгийг 21 аймаг 360 сумд хувааж тараадаг ийм төсөвтэй байгаа. Тэгэхээр бид нар өнөөдөр бас тодорхой зүйлийг бодитой тооцоотой судалгаатай гаргахын тулд энэ 2040-ийг олон матриц дээр бодож байж ингэж гаргаж байгаа. Үүнийхээ бид дэд бүтцээ хийгээд өгвөл хувийн хэвшлийн тухайн салбарт хөрөнгө оруулалт оруулах энэ тэр боломж сонирхлыг өдөөх замаар энэ барилгажуулах төслийг явуулъя л гэж байгаа юм. Ингээд бид нар 2040 он хүртэл нийт айл өрхүүдийнхээ 80 орчим хувийг орон сууцжуулъя аа. Энэ болтол утаатайгаа униартайгаа байлгахгүй үүднээс нийслэл Улаанбаатар хотоос Засгийн газар тодорхой санхүүгийн татаасыг шийдэх юм бол бид нар 2030, 2031 он гэхэд айл өрхүүддээ хатуу түлш хэрэглэдэггүй газ LNG, LPG шилжилт рүү явъя гэдэг ТЭЗҮ боловсруулаад явж байна. Эхнийхээ ажлын зургуудыг хийж байна. Ханган нийлүүлэлт хийх байгууллагуудтайгаа эхний хэлэлцээрүүдийг хийгээд явж байна.

Х.Булгантуяа: Эрдэнэбүрэн сайд нэмж хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Ерөнхий сайд ч хэллээ. Нямбаатар дарга ч ярьж байна. Энэ ерөөсөө энэ өмнөх ерөнхий төлөвлөгөөний хувьд хэрэгжээгүй хүн төвтэй биш хүнээ бодсон биш байсан асуудал бол ерөөсөө цэвэр дэд бүтэц хөрөнгө мөнгө байхгүйгээс болоод байгаа жоохон дэд бүтэц дээрээ л бөөгнөрсөн л асуудал болсон

шүү дээ. Тэгээд одоо бол бид нар энэ ерөнхий төлөвлөгөө батлагдангуут араас нь энийгээ задлаад 14 хот 42 нэгж дээр барилгажилтын төлөвлөгөө асар хурдан энэ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө барилгажилтын төлөвлөгөөгөө хийгээд тэгээд 3D болгоод энэ иргэддээ ойлгуулах тийм юм болно. Энэ төлөвлөгөөг хийх явцад ямар асуудал гарч ирэх вэ гэхээр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд хийхлээр эх үүсвэрүүдийн асуудлууд гарч ирнэ. Эх үүсвэрүүдээ хэрхэн хийвэл үр дүнтэй байх юм бэ гэдэг ийм зүйлүүд гарч ирнэ. Дулааны станц, цэвэрлэх байгууламж, усан сангууд.

Х.Булгантуяа: Эрдэнэбүрэн сайдын микрофоныг нэмж өгье.

Р.Эрдэнэбүрэн: Ингэхийн тулд бол хэд хэдэн ажлууд нь хаврын чуулганаар бас дахиж орж ирэхээр байгаа. 20 минутын хотын үзэл баримтлал 2-т нь бол энэ 2025 оны 6 сарын 1-ээс эхэлж хэрэгжиж эхлэх Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн бэлтгэл ажилтай холбоотой ийм 2 асуултыг бол Их Хурлаар оруулж ирэхээр ингээд бэлтгэж байгаа. Ажлын хэсгийг манай Лувсанжамц гишүүн, Алдаржавхлан гишүүн ахлаад ингээд ажлуудаа дуусгаж байгаа, бэлэн болж байгаа гэдгийг хэлмээр байна аа.

Х.Булгантуяа: Батсуурь сайд нэмж хариулья.

Ж.Батсуурь: Тэгэхээр ер нь энэ 2040 нэг онцлогтой л доо. Зарим гишүүд бид нар хот байгуулж ирсэн түүх байхгүй энэ тэр гээд. Тэгэхээр ер нь бид нарын энэ шүүмжлээд байгаа Улаанбаатар хот дотор бол өөр нийгэмд өөр улс төрийн нөхцөл байдалтай ийм байсан. Тэр үед өмчгүй үеийн хувийн өмчгүй үеийн ийм нээлттэй нийгэм биш үеийн хот төлөвлөлт. Тийм учраас энэ дагуулж орж ирж байгаа Хүннү, Смарт хот, энэ хотын дауул хотууд шинээр төлөвлөж байгаа хотуудыг бид нар жинхэнэ өөрсдөө Монголчууд өөрсдөө барьж байгуулах дээр нь зах зээлийн ардчиллын энэ чөлөөт нийгмийг хувийн өмчтэйгөө хамтарсан энэ хотыг байгуулах л ийм төлөвлөгөөний гол зорилт болж явж байгаа юм. Орон сууцын хувьд бол маш хурдтайгаар гаднын хөрөнгө оруулагч нартай ингээд барьж болох боловч хэд хэдэн зүйлүүд байж байгаа. Нэгдүгээрт дулааны хангамжийн асуудал сая Ерөнхий сайд хэллээ. Мөн дэд бүтэц.

Х.Булгантуяа: Батсуурь сайдын микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Дулааны хангамжийн асуудал байж байна. Дэд бүтцийн асуудал байж байна. Дээр нь худалдан авах чадварын асуудал байж байна. Тийм учраас бид бүхний хувьд янданг цөөлөх, утаагүй болох, түгжрэлгүй болох, мөн ирээдүйн сайхан хот байх энэ бүх цогц төлөвлөгөөг нийтээр нь харж байгаад энэ 2040 гэсэн 40 он хүртэлх сая одоо хөнжлийнхөө хэрээр хөлөө жийе гэсэн байгаа боломждоо хамгийн хурдтай, хамгийн боломжтой, хамгийн ирээдүйг харсан ийм төлөвлөлтийг оруулж байгаа гэж хэлэх гэсэн юм. Тэгээд минут дуусчихлаа.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэболд: Ерөнхий сайдаас товчхон. Түрүүн ингэж асуусан байхгүй юу. Нөгөө УАБЗ-ийн гишүүний хувьд энэ төсөл хөтөлбөрүүд явж байгаа энэ санхүүгийн дизайнууд чинь бүгдээрээ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хянагдах тэр хяналтыг нь аудит хийх ёстой. Гэтэл хэмжих нэгж тодорхойгүй гээд хянахгүй байгаагаас болоод аюулгүй байдлын зэрэглэлийн үнэлэмж нь гарч өгөхгүй байгаа

юм аа. Тэгэхээр аюулгүй байдлын зөвлөлийн гишүүний хувьд энэ хэмжүүрийг гаргамаар байна л гэдэг саналаа энэ боломжтой юу л гэдэг саналыг би асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт тэр Эрдэнэбүрэн сайд эд нар хэлээд байна. Бид нарт мөнгөгүй байсан эд нар гээд. Мөнгө бол байсан шүү. Харалган байсан, хулгайч байсан эх орныхоо эсрэг үйлдэл хийсэн газраа зарсан. Энэ Богд уулыг тойроод отог гэдэг нэртэй баахан хаус хорооллууд барьсан гээд энэ хариуцлагын асуудал шүү. Хариуцлага байхгүй байсан. Одоо ямар ч бодлогын бичиг баримтын тухай ярьж байгаа тохиолдолд бид нар ард нь хавсаргаад хариуцлагын тухай эзэн биетэй байх тухай л яримаар байгаад байгаа. Тэгээд энийг тодорхой болгохын тулд Ерөнхий сайд энэ одоо хэмжих нэгжийг гаргахад.

Х.Булгантуяа: Эрдэнэболд гишүүн санал хэллээ. Авлигатай тэмцэх дээр ажиллах ёстой шүү гэж. Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Баярлалаа. Өдрийн мэнд. Энэ бол Улаанбаатар хотын 6 дахь төлөвлөлт. Сүүлийнх нь 2006 онд батлагдсан ерөнхий төлөвлөгөө. Түүний хэрэгжилт хангалттай нь 29 хувьтай буюу хэрэгжиж чадаагүй. Тийм учраас Нямбаатар даргад маш их ажил, маш их даалгавар бий болж байгаа юм. Энэ бүгдийг хэрхэн цэгцлэх вэ хэрхэн ажил хийх вэ гэдэг өнгөрсөн хугацаанд Улаанбаатар хотод эрчим хүч, цахилгаан, дулаан гээд нийгмийн дэд бүтцээ нэг ч удаа өргөтгөж шинэчлэгдээгүй. Тийм учраас байгаа дэд бүтэц дээрээ шавар алдсаар байгаад өнөөдрийн Улаанбаатар хот бий болсон. Энэ Улаанбаатар хот өнөөдөр төлөвлөлтгүй, төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүй, замбараагүй, дахиад хэлэхэд томоос том тосгон болж хувирсан. Энийг цэгцлэх юм байна гэж ойлгож байгаа.

Яагаад гэвэл Улаанбаатар хотын түүхэнд байгаагүй хамгийн их төсөв мөнгөтэй хотын дарга бас та. 2002 онд Бат-Үүл Улаанбаатар хотын дарга болж байхад 337 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан бол өнөөдөр 3 их наяд 800 тэрбум. Нэмэх нь 500 сая бондын ийм төсөвтэй байгаа. Тэгээд надад үндсэндээ 4 асуулт байна. Эхнийх нь Улаанбаатар хотод нэг ч бүтэн биеийн тамирын талбайтай үлдсэн сургууль, цэцэрлэг, өөрийн цэцэрлэгт хүрээлэн, гадаах ногоон байгууламжтай үлдсэн эмнэлэг байхгүй ээ. Энийг үе үеийн Улаанбаатар хотын газрын дарга нар газрыг нь олгоод ерөнхий архитектур тэрэн дээр нь орон сууцын барилга барьж болно гэж баталж өгөөд бүгдийг нь барилга орон сууц болгосон. Энэ дээр ямар хариуцлага тооцсон бэ? Тооцох вэ?

Хоёрдугаарх нь Их тэнгэрийн амнаас бусад Богд уулын бүх амыг аялал жуулчлал отог нэрийн дор үе үеийн байгаль орчны сайд нар олгочихсон. Эд нар бас бүгдээрээ орон сууц болсон. Яг анхны зориулалтаараа ашиглагдаж байгаа аялал жуулчлалын хэлбэрээр ашиглагдаж байгаа энэ газар маш цөөхөн. Тэгээд энэ дээр бас ямар арга хэмжээ авах вэ?

Гуравдугаарх нь Улаанбаатар хот өөрөө Баян Богд гээд нүүрсний ордтой. Мөн дэд бүтцүүдээ ашиглаад нүүрсний уурхайнуудыг ашиглаад уурхайн дээрээ цахилгаан станцуудыг бий болгоод Улаанбаатар хотыг цахилгаанаар хангах мөн бүсүүдийг цахилгаанаар хангах боломжууд хэр байгаа вэ. Энэ дээр хийсэн судалгаа байгаа юу? Дахиад хэлье. Үе үеийн Улаанбаатар хотын газрын албаны дарга нар болон Ерөнхий архитектур, хүүхдийн цэцэрлэгийн талбай, сургуулийн талбай,

эмнэлгийн газар байж болох бүх ногоон байгууламжийг устгаж түрэн дээр орон сууц барих зөвшөөрлийг олгосон. Энэ дээр хариуцлага тооцох ийм арга хэмжээ авах ажил юу байгаа вэ?

Хоёрдугаарх нь Их тэнгэрийн амнаас бусад бүх Богд уулын амыг бүгдийг нь аялал жуулчлал нэрээр худалдаж борлуулж орон сууц барьсан. Үүн дээр ямар арга хэмжээ авах вэ?

Гуравдугаарх нь тэр эрчим хүчний нүүрс болон Баянбогд нүүрснийхээ ордыг ашиглаад Улаанбаатар хотыг цахилгааны дутагдлаас сэргийлэх энэ дээр барьсан цахилгаан станцууд ашиглан бүсүүдийг цахилгаанаар хангах боломж хэр байгаа вэ?

Х.Булгантуяа: Хотын дарга, Ерөнхий сайд эхлээд хариулъя. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Шулуухан асуулт шулуухан хариулъя. Одоо байгаа Ерөнхий шүүгч Ганзориг байгаа тохиолдолд нэг ч газрын наймаачинд хариуцлага тооцож чадахгүй ээ. Яагаад гэхээр энэ бүх газруудын цаана нууцаар байранд орсон СӨХ-той хуйвалдсан нөхдүүд бүгдээрээ шүүгч нар байгаа. Удахгүй Алтангэрэл сайд тэр шүүхийн юуг оруулж ирэх байх. Шүүгч нар хэргээ ч хянаж чадахаа больсон. Тийм учраас би парламентыг уриалж байна. Энэ дээр сонсгол хийх ёстой. Олон нийтийн мэдэх эрхийг хангах ёстой.

Хоёрдугаарт өнгөрсөн 7 хоногийн Засгийн газрын хуралдаан дээр энэ отгуудыг ярьсан. Одонтуяа дарга бас энэ дээр бас хариулт өгчих нь зүйтэй байх аа. Ерөнхий сайдын байр суурь бол Байгаль орчны яам газар олгох утгагүй гэж үзэж байгаа юм. Яагаад гэхээр отог гэдэг би дахиад хэлье. Буулгаад авч явж болдог ийм аялал жуулчлалын байгууламжийг л отог гэнэ гэж ойлгоод байгаа юм. Харамсалтай нь Зайсанд баригдсан отгууд маань буухгүйгээр ийм том хотууд болчихсон байна. Одоо бид нар энийг ингээд шийдэхээс өөр яах вэ. Парламент ингээд нээлттэй ажлын хэсэг гаргаад энэ отгуудаа яах вэ гэдгээ бас ингээд ярих нь зүйтэй байх. Тэгээд би бол Одонтуяа даргыг наад отгуудаа тэгээд бүгдийг нь хотод өг гэж байгаа юм. Цаашдаа харин 2040 батлагдаад отог байшин болдоггүй юмыг л хэдүүлээ хийх ёстой. Гэхдээ би Алтангэрэл сайдтай санал нэг байгаа юм. Хариуцлага тооцохгүйгээр явбал бид нар дахиад л отог байшин болох юм явна. Дүүргийн захирамж, нийслэлийн захирамж болно гэж нэг хэсэг нэг баахан шуурга болдог байсан.

Тийм учраас энэ алдаагаа 2040-ийг батлаад хэдүүлээ давтахгүй байх ёстой гэж бодож байгаа. Тэгээд парламентад би дахиад хэлье. Одоо парламентаар олон намын төлөөлөл ороод ирчихсэн байна. Яг ингээд л авлигалтай тэмцээд эхлэхлээр манай парламентын гишүүдээс авхуулаад л өөрсдөө өрөвдөөд эхэлдэг шүү. Нэг мэдэхэд л нөгөө талд гарчихсан байж байдаг. Одоо энэ ер нь ингээд л энэ авлигалтай тэмцээд л ер нь манай ах дүү хамаатан садныг шалгах гээд байгаа юм биш үү? Тэр дунд нь мань мэт орооцолдчихсон байх вий дээ балрах вий дээ гээд л ингээд л нэг мэдэхэд л блокчлохсон. Тэгээд л нэг юм 5, 6 хүний гарт улсаараа орчихсон. Тэгээд л энэнээсээ гарч чаддаггүй шүү. Тэгээд л нэг мэдэхэд ганцаархнаа үлдчихсэн байдаг. Тэгээд жоохон гайгүй болоод ирэнгүүт авлигалтай яагаад яагаад тэнцэхгүй байгаа юм бэ л гэдэг. Тэгээд тэмцээд эхлэхлээр дарангуйлал тогтоох гээд байгаа юм биш үү, эрх чөлөөнд халдаад байгаа юм биш үү, хувийн өмчийг дээрэмдэх гээд байгаа юм биш үү болоод л явчихдаг шүү.

Тийм учраас энэ авлигалтай холбоотой энэ асуудал дээр үнэхээр хэдүүлээ тэмцье гэж байгаа бол нэг талдаа гараад тэмцмээр байгаа юм. Эсвэл тэгээд больчихмоор байгаа юм бас. Тэгэхгүй тэгээд л ингээд нэг ийм хэрэг нь хаанаа гацаад байгаа нь тодорхой. Гэхдээ тэрийгээ шүүмжилж чадахгүй. Байшин хэнийх нь.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье. Байшин хэнийх нь хийгдээд байгаа нь тодорхой. Буулгая гэхлээр хувийн өмчид халдаад байна гээд бүгдээрээ яриад байдаг. Тэгвэл больчихъё гэхээр дараагийнх нь тийм байшин баригдчихна. Энэ чинь л таны яриад байгаа отог байшин болсон түүх байхгүй юу. Отог байшин болчихсон газар ямар юмны ерөнхий төлөвлөгөө байх юм бэ? Юун ерөнхий төлөвлөгөө. Отог байшин болчихсон хотод ерөнхий төлөвлөгөө байх боломжгүй байхгүй юу. Цаашдаа ч ийм байна.

Тийм учраас энэ дээр би бас Ундрам гишүүн парламентын гишүүддээ бас талархаж байна. Энэ дээр үнэхээр ерөнхий төлөвлөгөө зөрчвөл ямар хариуцлага байх вэ гэдгийг өмнөхөө больё уу уучилъя. Бас аливаа нэг зүйл асуудалтай шилжилтийн үе байсныг ойлгож байна. Харин 2040 батлагдсанаас хойш өмнөх алдаануудаа хэрвээ давтал маш уйтгартай. Тийм учраас энийг ингээд цэглээд л 76-тай парламент тэгээд 126-тай парламент гэж 2 хуваагдаж бичигдэж байгаатай адилхан 126-тай парламент болсноос хойш Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө тэгээд л яс хэрэгждэг л байг. Ингэж л хийж чадахгүй бол бид нар үүн дээр асуудал болно. Тэгээд шүүхийнхэнд хандаж хэлэхэд Ерөнхий сайдыг огцруулах гээд Ерөнхий зөвлөлийн гишүүдээ архидуулаад явж байхын оронд наад авлигачтайгаа тэмц. Байшин байгаа одоо энэ бүх мега төслүүдийн ард байгаа авлигач шүүгч нартай чинь энэ асуудлыг задлах ийм зүйлийг бас нэг өдөр парламент ярина гэдэгт би огт эргэлзэхгүй байгаа.

Шүүгч нар нь өөрөө авлигач улс яаж авлигатай тэмцэх юм. Одоо энэ СӨХ дээр байгаа бүх материалуудыг гаргаад та нар үзээрэй. Бүх байшинд орц орцоор нь тэд нар л орсон байгаа юм. Мега төслүүдийн ард байгаа бүх зүйлийг ард нь үзээрэй. Бүгд захиргааны хэргийн шүүх дээр л гацсан байгаа. Одоо Тавантолгойн цахилгаан станц хаана гацаж байгаа юм. Шүүх дээр л гацаж байгаа шүү дээ. Ард нь юу болж байгаа юм авлигалын асуудал байгаа юм. Энийг мэдсэн ч мэдээгүй юм шиг ингээд хэчнээн жил явах юм.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар дарга дараа нь Одонтуяа сайд нутагтай холбоотой асуултад нэмээд хариулчихъя.

Х.Нямбаатар: Өнгөрсөн 2017-2021 онд таныг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байхад том ажлын хэсэг гарч шалгалт хийгдээд хууль хяналтын байгууллага дээр энэ Байгаль орчны яамнаас олгогдсон дархан цаазат газруудад газар олголтын талаарх бүх хяналт шалгалтын ажлууд нэгдсэн дүнгүүд хууль хяналтын байгууллагын ажлын хэсэг дээр шалгагдсан байгаа гэдгийг бас хэлье. Эрдэнэс Баянбогд дээр нүүрсний орд байгаа. Гэхдээ энэ бол хүрэн нүүрсний орд. Дунджаар 3 мянган кил калори илчлэгтэй нүүрсний орд байгаа. Энэ дээр бид нар төр хувийн хэвшлийн түншлэлийн хэд хэдэн ийм урилгуудыг байгууллагуудад хүргүүлсэн боловчиг нийслэл нэг 20-оос доошгүй хувийн EQT амлаж байж энэ станцууд баригдах нөхцөлтэй юм байна лээ.

Бид нар бол тодорхой хэмжээнд урьдчилгаа гаргахгүйгээр ингээд.

Х.Булгантуяа: Нямбаатар даргын микрофоныг өгье.

Эрчим хүчний нүүрс түшиглээд станц байгуулъя гэхээр заавал 20-оос доошгүй хувийн урьдчилгаа хувийн сектор шаардаад байгаа. Энийг одоо бид нар тэгээд жоохон 10, 15 хувь болтол хэлэлцээрүүд явагдаж байгаа энэ шийдэгдвэл тэгээд бид нар энэ 300мвт-ын цахилгаан станц тэнд баригдана гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Дээр нь хотоос 5 дугаар цахилгаан станц гэсэн нэг төслийг хэрэгжүүлээд төслийн нэгжээ байгуулчихсан явж байгаа. Удахгүй төр хувийн хэвшлийн түншлэлийн тендер зарлагдана аа. Ер нь бол Шижир гишүүн ээ маш ойлгомжтой хэлэхэд 2040 батлагдсаны дараа бид нар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүдээ батлуулаад барилгажилтын төслөө батлуулаад засгаар оруулчих юм бол ямар ч ерөнхий архитектур ямар ч хот байгуулалтынхан дүрэм зөрчиж барилгын зөвшөөрөл олгодоггүй болно. Дээр нь А-ийн даалгавар гэдэг эскиз батлах тухай ойлголт бүрмөсөн халагдана. Яг тэр барилгажилтын төслийн дагуу өөрийнхөө эзэмшиж байгаа газар дээр тэр хэмжээ дамжаагаар нь барилгаа барьдаг ийм тогтолцоо руу бид нар 2026 он гэхэд бүрэн шилжихээр төлөвлөж байгаа гэдгийг хэлье ээ.

Х.Булгантуяа: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Харин тийм тэгэхгүй бол нөгөө хотын төлөвлөгөө чинь байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Баталдаг тэгээд байхгүй болчихдог. Тэрэн дээр нь ингээд хууль бус барилга байгууламжууд барьдаг, тэрийг араас нь зөвшөөрлийг нь хөөцөлддөг хүлээж авдаг. Тийм учраас Улаанбаатар хот чинь төлөвлөгөөгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд Нямбаатар даргаас дахиад тодруулъя. Улаанбаатар хотын төвийн бүс А, Б гээд хуваадаг. Энэ бүсэд үйл ажиллагаа явуулдаг сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийгмийн байгууламж нийтийн цэцэрлэгт хүрээлэнгээс яг өнөөдөр анхны төлөвлөлтөөрөө олгогдсон газартайгаа үлдсэн барилга байшин болоогүй ийм газар ийм байгууламж хэдэн ширхэг байгаа вэ гэдэг асуулт.

Яагаад гэвэл өнөөдөр Улаанбаатарын бүх сургууль, цэцэрлэг бүгдээрээ барилгын газрыг нь худалдаад тэрэн дээр нь барилга барих зөвшөөрлийг нь өгөөд яг нүүрэн дээр нь сургууль, цэцэрлэгийнх нь нүүрэн дээр эмнэлгийнх нь нүүрэн дээр нь тулгаад тулгаад байшингууд барьчихсан байна шүү дээ. Тэгэхээр эд нар чинь ингээд маш их хүний эрхийн зөрчил бий болж байгаа байхгүй юу.

Х.Булгантуяа: Ажлын хэсгээс Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Яах вэ та бол юуг хэлж байна тиймээ? Их тойруу, Бага тойруу доторх энэ төрийн байгууллагууд, тэдгээрийн хуучин одоо анх олгогдсон эдэлбэр газраараа байгаа асуудлыг судалгаа хийж үзсэн үү гээд ер нь бол маш цөөхөн барилга байгууламж эдэлбэр газар өмнө нь анх олгогдсон тэр хэмжээ дамжаагаараа үлдсэн нийтийн эзэмшлийн бусад бүх талбайнууд барилгажсан оффис болсон орон сууцын барилга болоод ингээд шийдэгдсэн юм. Шалтгаан нь ерөөсөө л маш энгийн. Төвийн эрчим хүчний систем, төвийн дулаан хангамжийн системийн өртөг 1м2-ыг халаах өртөг 506 төгрөг байсан. Энийг дагасан газар олголтын түүнийг дагасан барилгажилтын ийм үндсэндээ 20 гаран жилийн хүчтэй ийм давлагаа явагдсанаас шалтгаалаад таны хэлж байгаа тэр сургууль

цэцэрлэгийн гаднах хүүхдийн тоглоомын талбай бүгд энэ барилгажилтын золиос болж нэрвэгдсэн. Үүнийг дагасан.

Х.Булгантуяа: Одонтуяа сайд нэмж хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ 2040 төлөвлөгөөнд Байгаль орчин ба аялал жуулчлал гэсэн тусгайлан бүлэг байгаа. Энэ бүлэгт бол ойн санг хэрхэн нэмэгдүүлэх юм энэ хөвд цөөрөм, усан санг хэрхэн хийх юм? Тусгай хамгаалалттай газар нутгаа яаж хамгаалах юм гээд энэ зүйлүүд тусгайлан бүлэг болгоод орсон байгаа. Таны хөндсөн энэ Богд уулыг тойрсон замбараагүй газар олголт бол үнэхээр олон жил ингээд хийгдэж ирсэн. Би бол ажлаа аваад одоогоор нэг ч шинээр газар олголт хийгээгүй байна аа. Учир нь манай дээр ажлаа авахад шүүхийн 130 маргаан байгаа 130 маргаан. Тэгэхээр энэ 130 маргаан юутай холбоотой юм бэ гэхээр өмнө нь олгосон тэрийг нь цуцалсан гээд энэ янз бүрийн асуудлууд.

Дээрээс нь БЗД, Хан-Уул дүүрэг, Зайсангийн иргэдийн бас маргаан байдаг. Нийтдээ нэг 4.

Х.Булгантуяа: Одонтуяа сайдын микрофоныг нэмж өгье.

С.Одонтуяа: Иргэдийн газрын маргаан бол энэ нэлээд олон сайдыг дамжаад ингээд бас байгаа. Тэгэхээр ер нь бид энэ Отго нэрээр аваад олон давхар орон сууц барьдаг асуудал тэгээд дараа нь энэ иргэд нь гэрчилгээгээ авч чаддаггүй энэ газруудад нь сургууль цэцэрлэг байхгүй гээд ийм нэг төлөвлөлтгүй энэ замбараагүй байдлыг бид нар таслан зогсооно.

Тийм учраас Нямбаатар даргатай манай яам энэ 2040 дээр хамтарч ажиллаж байгаа. Нэг зүйлийг мэдээлэхэд одоо энэ сая намрын чуулганаар арай амжсангүй. Хаврын чуулганаар ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барьж байгаа. Энэ өргөн барьж байгаа хууль бол энэ гишүүдийн асуугаад байгаа энэ бүх асуудлууд маргаантай асуудлыг зохицуулахаар яг олон улсын жишигт нь тааруулж зохицуулахаар ингээд зохицуулалтууд орж байгаа.

Тэгэхээр энэ хуулиа өргөн барихын өмнө бид нар бас энэ гишүүдээрээ хэлэлцүүлж бас санал авна гэж тооцоолсон байгаа.

Х.Булгантуяа: Шижир гишүүн хангалтгүй гэж үзэх юм бол дахиж нэг минут тодруулах эрхтэй байгаа. Шижир гишүүн нэг минут тодруулъя.

Ө.Шижир: Харин тийм Одонтуяа сайдын одоо энэ асуудлыг нэг тийш нь шийдэхгүй бол энэ чинь өөрөө юу болоод байна вэ гэхээр иргэдийн хөрөнгө үнэгүйдээд байгаа байхгүй юу. Гэрчилгээ нь гардаггүй. Эргээд эдийн засгийн эргэлтэд ордоггүй. Тэгээд энийг нэг тийш нь ингээд тодорхой болгоод шийдэхгүй бол нэгэнт ингээд анхнаас нь отог нэрээр олгоод тэнд нь орон сууцын хорооллууд тэдэн мянгаараа баригдаад иргэд нь нүүгээд орчихсон тэгээд буцаад эдийн засгийн эргэлтэд оруулах гэхээр гэрчилгээ нь гардаггүй гээд маш их ийм асуудлууд байгаа юм.

Тийм учраас би энэ 2040 гэж энэ Улаанбаатар хотын төлөвлөгөөг ерөнхийдөө бол ингээд маш сайн дэмжээд байгаа юм. Бас нэлээн сайн уншиж харлаа. Бас нийгмийн асуудлуудаа шийдэх чухал зүйлүүд байна. Тийм учраас одоо энэ

хэлэлцэх хэсэг нь яваад хаврын чуулганаар хэлэлцээд батлагдах байх дагасан энэ хуулиудын өөрчлөлтүүд дээр маш сайн анхаараад энэ асуудлаа шийдэхгүй бол дахиад л энэ проблем үүсээд байвал яах вэ гэж л урьдчилан сэргийлэх байдлаар л би асуугаад байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Шижир гишүүн санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй танилцлаа. Тэгээд эдийн засгийн, байгаль орчны, нийгэм соёлын гээд тус бүрд нь хүчин зүйлс болгоноор нь ер нь дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргасан нь сайн болсон байна, ажлын хэсэг бас сайн ажилласан байна гэж дүгнэж байна. Нөгөө талдаа болохоор асуулт юу байна вэ гэхээр энэ салбар бүрдэх хүчин зүйлс тус бүрээр нь богино, дунд хугацаанд хүрэх зорилго тэр зорилгоо хэмжихийн тулд датагаа яаж цуглуулах юм ямар аргачлал ашиглах юм гэдэг ийм нарийвчилсан төлөвлөгөө ер нь цаанаа туссан байгаа юу гэдэг нэг ийм асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарт болохоор энэ зүгээр Улаанбаатарын хувьд хамгийн тулгамдсан асуудал өвөлдөө яалт ч байхгүй энэ агаарын бохирдол байгаад байгаа шүү дээ. Тэгтэл агаарын бохирдол маань энэ 2040 ерөнхий төлөвлөгөө дотроо ерөөсөө яг ийм хэмжих үзүүлэлттэйгээр хүрэх үр дүнтэйгээр тусгагдаагүй байна уу даа гэж хараад байгаа юм. Яах вэ дэд бүтцийн чиглэлийн хөрөнгө оруулалтууд хийснээрээ яваандаа агаарын бохирдол буурна гэж тооцсон байх. Гэхдээ бол энэ төлөвлөгөөн дээр энэ ингээд бас тодорхой хэмжээнд хэмжих нэгжтэй үр дүнд хүрэх зорилготой ийм байх ёстой болов уу гэж би ер нь санал хэлмээр байгаа юм. Тэгээд яагаад энийг ярьж байна вэ гэхээр НҮБ-ын харьяа 16 байгууллагын дэмжсэн Ухаалаг тогтвортой хөгжлийн хотын нэгдсэн ийм түлхүүр үзүүлэлтүүдийг гаргасан байдаг юм байна аа. Тэгэхээр би одоо яах вэ ажлын хэсэг бас иймэрхүү зүйлийг судалсан байдаг байх. Энийг бас анхаарчхаарай гэж хэлмээр байгаад байгаа юм.

Гуравдугаарт болохоор би Ерөнхий сайдаас асуумаар байгаад байгаа юм. Энэ 15 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 237 их наяд төгрөг хэрэгтэй гэж төсөв дээр тусгачихсан байна төлөвлөгөөнд. Тэгээд ойролцоогоор ингээд харахаар ер нь дэд бүтцийн нийгмийн чиглэлийн бүтээн байгуулалтуудаа төр хариуцна үлдсэнийг нь хувийн сектор оруулна гэж бодох юм бол 142 их наяд төгрөгийг бол хувийн сектор оруулахаар байгаад байна. Гэтэл хувийн сектор маань өнөөдөр болохоор энэ газрын маргаан бизнес хоорондын маргаан. Ингээд л шүүх дээр уддаг асуудал нь шийдэгддэггүй шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр уддаг гээд ийм олон асуудал байдаг учраас өнөөдөр бас хөрөнгө оруулалт хийх тал дээр нэлээн эргэлзсэн байдалтай байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо зөвхөн энэ Улаанбаатар хотын 2040 хүртэлх ерөнхий төлөвлөгөө гэхгүйгээр энэ хувийн сектор өөрөө ингээд бие дааж хөрөнгө оруулах орчныг сайжруулах талаар энэ шүүхтэй холбоотой асуудлууд энэ арилжааны маргааны асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн асуудлыг сайжруулах талаар ер нь Ерөнхий сайдын зүгээс ямар ажлууд хийхээр төлөвлөж байна вэ? Энэ тал дээр ямар арга хэмжээ авах гэж байна вэ гэж асуумаар байна аа.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Бид нар энэ 7 хоногийн Засгийн газрын хуралдаан дээр бизнесийн орчныг сайжруулах асуудлыг цогцоор авч үзье ээ. Үүнийг бас Бахрейн улсын хөрөнгө оруулалт болон эдийн засгаа төрөлжүүлсэн сайн жишээн дээр бас тулгуурлаж үүнийг модель загвар болгоё гэдэг ийм байдлаар Засгийн газрын тогтоол баталсан. Тэгээд үүнийг болохлоор бизнесийн орчинд ээлтэй буюу Бизнес Фрэндли Монголиа гэдэг ийм агуулга доор Эстони дээр бид нар И Монголиа гээд явсан шиг аялал жуулчлал дээр ингээд бас тийм том малгайн доор хийгээд хамтдаа бас нэг ийм богино хугацаанд ахиц гаргасан шиг ийм агуулга руу ингээд явъя гээд. Ингээд Эдийн засгийн манай хөгжил хариуцсан тэргүүн Шадар сайд маань ахлаад Хэрэг эрхлэхийн сайд Учрал дэд даргаар нь ажиллаад ийм ажлын хэсэг гарсан байгаа. Мөн Ерөнхий сайдын дэргэд байгаа Эдийн засгийн зөвлөл дээр олон улсын экспертүүдийг авч ажиллах тэгээд бизнесийн орчиндоо нэгдсэн байдлаар үнэлгээ хийе. Тэрэн дотор компанийг анх байгуулахаас авхуулаад компани дампуурлаа зарлах хүртэлх хугацаа. Шүүхийн процессоос авхуулаад татвар, нийгмийн даатгал, гадаадын хөрөнгө оруулалтын орчин. Би гадаадын хөрөнгө оруулалтын орчин гэдэг нь гадаадын хөрөнгө оруулалтын орчныг бид нар хөрөнгө оруулалт гээд гадаадын гэдэг үгийг авснаас болоод маш ойлгомжгүй болгочихсон юм байна лээ. Компаниудыг яаж корпорац болгох вэ? Дүрмийн санг яаж нэмэгдүүлэх вэ?

Өчигдөр орж ирж байгаа төрийн өмчийн компаниудын засаглалыг хэрхэн сайжруулж ил тод болгох вэ, яаж хувийн хэвшил рүү байгаа боломжийг бид нар гаргах вэ гэдэг агуулгаар 5 ийм багц арга хэмжээг авахаар төлөвлөж байгаа. Үүнийг бид нар хаврын чуулганд багцаар нь оруулж ирнэ. Энэ дээр бас парламентын гишүүд Засгийн газартай бас хамтраад хувийн хэвшлийнхэнд би бас энэ мессежийг өгсөн байгаа.

Ингээд хамтраад хэдүүлээ эрх зүйн орчиндоо дүн шинжилгээ хийгээд. Сайнзориг гишүүн эд нар бас яриад байгаа яг тэр дампуурлын хуулиас авхуулаад парламент дээр байгаа ажлын хэсгүүдийг ингээд нэгтгэж гаргах ингэснээрээ бид нар тендерийн хууль нь ойлгомжтой, хөрөнгө оруулалтын орчин ойлгомжтой бизнесийн орчин ойлгомжтой ВОТ хийх нь ойлгомжтой гэдэг агуулгаар яаж энэ том төслүүд рүү хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчдын мөнгийг татан оролцуулах вэ гэдэг орчныг бүрдүүлэх нь туйлын чухал байгаа. Хөрөнгө оруулалт гадаадын хөрөнгө оруулалтын хуультай холбоотой асуудлыг туршлага судлахын тулд энэ чуулган дууссаны дараа Гантөмөр дарга, Доржханд Шадар сайдаар ахлуулсан ийм ажлын хэсэг явна. Энэ дээр бас парламентын гишүүд маань ороод явж болно. Бахрейн улсын хувьд бол яг манайхтай адилхан 60 хувь нь уг уурхайгаас хамааралтай улс байж байгаад 10 жилийн дотор нийтдээ 11 эдийн засгийн өөр сектороос 15-аас илүүгүй нэг сектор нь байх хэмжээнд төрөлжүүлж чадсан юм байна лээ. Тэр нь ерөөсөө хөрөнгийн биржээ нэмэгдүүлсэн. Тэгээд татварын орчноо маш сайжруулсан. Батцэцэг сайдтай би бас ярьсан байгаа. Жишээлбэл гаднын хамгийн шилдэг экспертүүдийг эх орондоо урьж ажиллуулж чадсан. Тэднийг гадуурхаагүй, тэдний мэдэхгүй байгаа зүйлийг хүндэтгэж чадсан ийм хандлагатай болсон.

Тийм учраас энэ агуулга руу явах ийм томоохон бас ингээд хөтөлбөрийг хийж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн би бас хотыг шахаж байгаа зүйл хот ч гэсэн бизнес фрэндли ийм орчин байх ёстой. Зөвшөөрлөөс авхуулаад энэ олон асуудал дээр бидний хувьд ингээд дүн шинжилгээ хийгээд ингээд явна гэдэг байдлаар ингээд Засгийн газар бол ажиллаад явж байгаа. Парламентын бас дэмжлэг үүн дээр холбоотой байгаа.

Парламентын гишүүддээ би нэг зүйлийг хэлэхэд Засгийн газар тэр шүүхийг яаж ч чаддаггүй шүү. Энийг бас нийгэм манай иргэд ч гэсэн ойлгох ёстой.

Засгийн газрын харьяа мөрдөх байгууллагуудаас гараад л прокурор шүүх дээр очдог. Шүүх дээр очоод л анхан шат юу ч болдгийг мэдэхгүй. Дунд шатын хурал боллоо л гэдэг юм. Дээд шатад очлоо л гэдэг юм буцчихлаа л гэдэг юм, тохирлоо л гэдэг юм мэдэхгүй. Ингээд миний мэдэхээр л лав зарим хэргүүд.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Тэгээд шүүхийн асуудлыг огт ярьж болохгүй байгаад байя гэхээр иргэд шударга ёсоо шахаад байдаг. Та бүхэн одоо жишээлбэл ингээд сонгогчидтойгоо уулзаад орж ирээд парламентын танхимд энэ асуудлыг ярихлаар Ерөнхий сайд ярихаас өөр аргагүй. Тэгээд шүүхийн асуудал ярихлаар яах вэ гэхлээр ШЕЗ дээр аваачаад шүүхийн хараат бус байдалд халдлаа гээд ингээд өгчихдөг. Би ч одоо ер нь бол бараг 2, 3 удаа огцорчхоод явж байгаа шүү дээ ШЕЗ-ийн шийдвэрээр.

Санал хураалт болоод 2 ч удаа огцрох шийдвэр гаргачихсан явж байгаа. Алтангэрэл сайд бас удахгүй ШЕЗ дээр очих сурагтай байна лээ. Гэхдээ бид нар энийг ярихгүй явах уу? Ярихгүй яваад байвал өнгөт хувьсгал болох шинжтэй. Шударга ёс нь тогтохгүй бол яваандаа энэ парламентын асуудал болно. Тийм учраас энэ эрх зүйн орчинтой холбоотой асуудлыг парламент бас авч үзэх зайлшгүй л шаардлагатай та бүхэн маань нүүр тулах байх. Яах вэ нэг нам давамгайлсан үед энийг ингээд яриад байхлаар нэг тийм улс төр хийгээд байгаа ч юм шиг ойлгоод байдаг байсан. Одоо бүх зүйл нээлттэй байгаа. Би худлаа ярьж байж уу үнэн ярьж байж уу? Алтангэрэл сайд саяхан надтай уулзаад шүүх дээр ийм утгагүй асуудал байгаа нь үнэн юм байна гэж хэлсэн. Өмгөөлөгчийн өнцгөөс харах, сайдын өнцгөөс харах өөр юм байна гээд. Одоо шүүх дээр байгаа маш их олон асуудлууд бүүр ингээд шийдэгдэхгүй 2 мянгаад хэрэг шийдэгдэхгүйгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэл Засгийн газрын харьяа агентлаг ажлаа хийж чадахгүй байдалд орчихсон байгаа юм. Энийг парламент руу Алтангэрэл сайд оруулах хэрэгтэй. Одоо ямар энийг дараад байгаад байлтай нь биш. 2 мянган кэйс ял завшсан гэсэн үг. Хууль хэрэгжүүлээгүй. Тэгээд бид парламентын баталж өгсөн хуулийг хэрэгжүүлэх үү эсвэл шүүхийн энэ асуудлыг мэдсэн ч мэдээгүй юм шиг дуугүй яваад байх уу гэдэг сонголттой.

Дээрээс нь яагаад шүүхийн асуудлыг ярих ёстой вэ гэхлээр явж явж хөрөнгө оруулалт бизнесийн орчны асуудал чинь шүүхийн шийдвэртэй холбоотой байдаг. Шүүх нь өөрөө улс төржөөд шийдвэр гаргаад байгаа улстай ямар хүн очиж хөрөнгө оруулалт хийх юм бэ? Хууль хяналтын байгууллагууд нь улс төржөөд хүний хөрөнгийг булааж аваад байгаа тохиолдолд яаж жишээлбэл хөрөнгө оруулалт хийх юм. Яаж бид нар бизнесийнхээ орчныг сайжруулъя гэж ярих юм. Том төслүүд нь очоод тендерийг нь шүүгчид аваад очоод бүх төслүүдийг нь шүүхийн шийдвэр дээр гацаагаад байгаа улстай ямар улс хөрөнгө оруулалтын асуудал ярих юм бэ. Тийм учраас бид нар GDP-ээ тэлье. ДНБ-ийг тэлэх нь гэдэг нь энэ л асуудлаа шийдэх гээд байгаа шүү. 14 мега төсөл гэхээр хол харагдаад, хол санагдаад байгаа гэдэг байдлаар бас тийм фокус группийн судалгаа гарсан байна лээ. Энэ 14 мега төслийг хэрэгжүүлж байж хотын асуудлыг шийдэх мөнгөтэй болох тухай асуудал, орон сууц барих тухай асуудал, хурдны замтай болох тухай асуудал, сургууль цэцэрлэг барих тухай асуудал. Сая Эрдэнэболд гишүүний хэлээд байсан 30 жилийн хугацааг яаж бид нар 10 жил болгох вэ гэдэг хөгжлийн хурдын тухай асуудал.

Тийм учраас мега төсөл хэрэгтэй байна. Тийм учраас мега төсөлд саад болоод байгаа авлигач шүүгч нартай бид нар тэмцэх ёстой болж байгаа юм. Энийг ярихгүй яваад байвал хөгжил хойшлоод л байна. Тийм учраас энэ асуудлыг ярьж байгаа шүү.

Х.Булгантуяа: Ерөнхий сайдын микрофоныг нэмж өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Тийм учраас Соронзонболд гишүүний асуултад шүүхтэй холбоотой асуудалд Ерөнхий сайдын болон Засгийн газрын хүч хүрэхгүй ээ. Энэ дээр парламентын дэмжлэг хэрэгтэй. Та бүхэн мэдээллийг өөрсдийнхөөрөө нягталж үзээрэй. Улс орны аливаа ямар ч асуудлыг Улсын Их Хурал татаж авах ярилцах онцгой бүрэн эрх гагцхүү парламентад байгаа. Бусад бизнесийн орчныг сайжруулахтай холбоотой бүх зүйл дээр Засгийн газар парламентын гишүүдийн та бүхний хэлж байгаа зүйл дээр туйлын ажил хэрэгч хандах болно.

Х.Булгантуяа: Нямбаатар дарга нэмж хариулья.

Х.Нямбаатар: Би Соронзонболд гишүүний асуултад хариулья аа. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө та бүхэнд тараасан энэ гарын авлагын 273 дахь хуудсан дээр бид нар нэлээн дэлгэрэнгүй бичсэн байгаа. Үндсэндээ 2 үе шатаас энэ 2040 маань хэрэгжинэ. Нэг нь 2025-аас 2030 он хүртэл 1 дүгээр үе шат, 2031-ээс 2040 он хүртэл 2 дугаар үе шат гэсэн ийм байдалтайгаар хэрэгжүүлнэ ээ. Хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө бол 2040 өөрөө Их Хурлаар батлагдсан тохиолдолд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гэж тусдаа Засгийн газраар батлуулж хэрэгжилтийн биелэлтийг хангана. 2040-ийг ингээд та бүхэн бас нэлээн дэлгэрэнгүй сайн судалж үзвэл бид нар дандаа хэмжигдэхүйц ийм тоон үзүүлэлт хүрэх үр дүнгүүдээ маш тодорхой тавьсан байгаа. 2040 он гэхэд нийслэл Улаанбаатар хотын хүн ам 2 сая 38 мянга болно. Нийслэл Улаанбаатар хотод амьдрах.

Х.Булгантуяа: Нямбаатар даргын микрофоныг гүйцээж өгье. Ажлын хэсгээс.

Х.Нямбаатар: Надад яг нэг минутын хугацаа өгөөд байгаа байхгүй юу. Би агаарын бохирдлыг бууруулах хамгийн богино хугацаанд хэрэгжүүлэх дунд хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанд ч танилцуулсан. Өчигдөр нийтийн нээлттэй сонсгол дээр ч танилцуулсан. Бид нар энэ LNG-д тэдэн мянган айлыг LPG-д тэдэн мянган айлыг холбох ийм зураг ажлын зураг руугаа орчихсон явж байгаа.

Дээр нь 2022 онд батлагдсан Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас нөгөө хийн шилжилт хийгдсэн айлуудад өгөх татаасны хувь хэмжээг тогтчих юм бол яг мөр тодорхой цаг хугацаатай хэдий хугацаанд бид нар агаарын бохирдлыг нольлох вэ гэдэг ийм дүнг та бүхэнд танилцуулахад бэлэн байгаа. Хагас сайн өдөр Ерөнхий сайд улс төрийн шийдлээ гаргаж өгөх байх. Бид нар хагас сайн өдөр штаб дээр энэ хийн шилжилтийн лаар бас нэлээн нарийвчилсан танилцуулгуудыг хийнэ.

Тэгэхээр Засгийн газраас Сангийн яам Ерөнхий сайд жил болгон хэдэн төгрөгийн татаасыг хийн шилжилт хийсэн.

Х.Булгантуяа: Соронзонболд гишүүн тодруулья.

Л.Соронзонболд: Яах вэ ерөнхийдөө би голлоод хэлээд байгаа нь энэ дээр нөгөө 2040 дээр агаарын бохирдол буюу яг тэрийг нэг тэр үзүүлэлт нь өөрөө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд би асуугаад байгаа юм тийм учраас та бүхэн тэрийгээ бүүр ингээд 2030, 2040 гээд оруулчихвал зөв байх л гэж хэлээд байгаа шүү.

Х.Булгантуяа: Ерөнхий сайд Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Хотын дарга санаа зоволтгүй. Би угаасаа нэг цагаас нэг уулзалттай байгаа. Гарахаар нөгөө нэг арай уртаар хариулах боломж нь хотын даргад олдоод. Тэгэхгүй бол уурлаад нэг минут хариулаад гээд. Тийм Соронзонболд гишүүний энэ нөгөө нэг яг бизнесийн энэ нөгөө юуны холбоотой асуудал дээр Их Хурал дээр бас ажлын хэсэг гаргаад явъя гэж ярьсан байгаа. Энхтүвшин гишүүнтэй ч бас ярьсан зүйлүүд байгаа.

Тэгэхээр та бас өөрөө банкны салбарын хүний хувьд оролцоод ажлын хэсэг дотор хамтраад саналуудаа нэгтгээд хаврын чуулганд бас бэлтгэл ажлаа хангаж болно хамтдаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл.

Б.Мөнхсоёл: Бүгдээрэнгийнх нь өдрийн амгаланг айлтгая аа. Тэгээд 3 асуудлыг хөндье гэж бодсон юм. Нэгдүгээрт нь санхүү, 2 дугаарт нь энэ 2040-ийн төлөвлөгөөг боловсруулсан аргачлал, 3-д нь засаглалын асуудал гээд. Энэ документ бол иж бүрнээрээ маш олон мэдээлэлтэй төлөвлөгөөтэй ирсэн. Тэгээд энэ дээр бусад гишүүд ч гэсэн асуудал хөндөөд байна. Санхүүгийн асуудал. 2030 он хүртэл 96.6 их наяд төгрөг хэрэгтэйгийн улсын төсвөөс 57.4 их наяд гэжээ. Дунджаар жилд 9 их наяд төгрөг хэрэгтэй юм байна. Энийг яг босгох тал дээр бас хувийн секторыг орхиод шүү дээ. Энэ дээр бас санаа зовниж байгаа юм аа.

Хоёрдугаарт аргачлал чухал. Аргачлалын цаана хүрэх зорилт шалгуур үзүүлэлт бас орсон байх ёстой. Орсон гэж хариулж байна. Тэгээд би энэ дээр зүгээр нэмэлт мэдээлэл өгөхөд 2020 онд Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас төсөл хэрэгжүүлсэн. Би өөрөө Монгол болон гадаад багаа удирдаад тэгээд тэрэн дээр болохоор яг энэ гол аргачлал нь болохоор тулгамдсан асуудал, төлөв байдлын үнэлгээ, тэгээд хариу авах арга хэмжээ гээд. Энэний хүрээнд гол 7 асуудал нөгөө салбар асуудал. Эрчим хүч, тээвэр, нийтийн тээвэр, барилга, газар ашиглалт, ус, хог хаягдал гэх мэт энэ салбарын асуудлуудыг бид нар үнэлээд хамгийн эцэст нь 42 бүүр задаргаатай 14 төрлийн төслийн санааг боловсруулсан юм.

Тэгэхээр энэ аргачлалын үр дүн энэ Европын Холбооны 15 хотод хэрэгжсэн. Азиас ганцхан Монгол тухайн үедээ сонгогдож байсан. Тэгээд энэ төслийг хэрхэн босгох вэ гэдэг дээр Грийн клаймэд ченж гэж юу гэж байгаа шүү дээ. Тэр олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөрөнгө мөнгө босгох ийм боломжтой. Түүний тулд энэ төлөвлөгөөгөө Ногоон хотын үйл ажиллагааны төлөвлөгөө гэдгийг боловсруулсан. Тэрний хэрэгжилт ямар байгааг өнөөдөр би сайн мэдэхгүй байна. Тухайн үед бол хотын захиргаа баталсан байдаг. Мэдээлэл олоход санхүү талдаа аргачлал талдаа маш их ийм жишээ болохуйц ашиглагдахуйц ийм ажил байдаг юм шүү гэдгийг мэдээлэл болгоод өгчихье.

Өнөөдрийн энэ гаргасан энэ 2040 төлөвлөгөө маань одоогийн байгаа хотын юу гэдэг юм засаг захиргааны бүтэц, менежмент мөн засаглалын байдалд энэ нь хэрэгжих боломжтой юу үгүй юу гэдэг дээр хариулт өгөөч ээ. Тэгээд санхүүгийн сая санхүүжилтийн юун дээр нэмэлт мэдээлэл өгвөл талархана баярлалаа.

Х.Булгантуяа: Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Тэгэхээр нийтдээ 240-өөд их наяд төгрөгийн 50 орчим хувийг нь улс нийслэл болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудаа санхүүжүүлэх зарчмыг бид нар гаргаж ирж байгаа. Ингэхийн тулд бид нар дэд бүтцийн төсөл тус бүр дээрээ төслүүдээ ТЭЗҮ-ээ банкайбл болгох гээд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тухайлах юм бол хамгийн эхний байнгын ажиллагаатай ажлын хэсэг ЭХЯ, нийслэл 2-ын дундаас гарчихсан ажиллаж байна. Бид нийслэлийн дамжуулах шугамын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлэхэд ойролцоогоор 2 тэрбум ам.доллар болно. Эдгээр төслүүд дотор 35-ын шугамууд 05-ын шугамууд, 110-ын шугамууд 500-гийн шугамуудыг бүхэлд нь бид нар шинэчилж байж 2035 он гэхэд Улаанбаатар хот 3 мянган Мвт-ын эрчим хүчний хэрэглээг дамжуулах ийм техникийн саадгүй дамжуулах ийм боломж бүрдэнэ ээ. Энэ төсөл дээр гэхэд бид нар Бүс ба зам ABRD, ADB гээд олон улсын донор байгууллагуудтай бид нар дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг энэ зарчмынх нь дагуу ТЭЗҮ-ээ банкны шаардлагад нийцүүлэх энэ ажлууд дээр ажиллаж байгаа. Мөн төсвийн цаашдын өсөлт тэлэлт. Би түрүүн эхэндээ хэлсэн бид нар цаашид 40 тэрбум ам.доллар-ын GDP-тэй болох энэ түвшнийг тодорхой шалгуур үзүүлэлтээр гаргаж тавьсан. Энэнийхээ дагуу улс нийслэлийн төсвийн тодорхой хувийг дэд бүтцийн санхүүжилтэд тавина гэсэн ийм хосолсон байдлаар бид нар энэ 120 их наядынхаа санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэж явж байгаа.

Эцэст нь товчхондоо хэлэхэд дэд бүтцийнхээ бүх төслүүдийг бид нар олон улсын банкуудын шаардлагад нийцүүлж боловсруулах ажил руугаа хэдийн орчихсон явж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат гишүүн. Мөнхсоёл гишүүн нэмж тодруулах уу?

Б.Мөнхсоёл: Тэгэхээр тэр өмнө гарсан төслүүдийг бас сонирхвол зүгээр юм байна гэж бодлоо.

Хоёрдугаарт нь манайд Монголд цаас баримт бичиг эрх зүйн орчин харьцангуй бас сайн гэж дүгнэгддэг. Ялангуяа шилжилтийн эдийн засагтай орнууд Азийн улсуудтай зарим улсуудтай харьцуулахад. Тэр хэрэгжилт маш их чухал байдаг шүү. Бид нар тухайн үед бас байгаа документ, баримт бичиг, бодлогын төлөвлөгөө энэ тэрд судалгаа хийхэд тухайн үед нийтдээ наад зах нь 50 орчим ийм баримт бичиг бодлого байсан. Тэгэхээр цаасан дээр сайн ажиллаад байдаг хэрэгжилт маш чухал. Тэгээд хэрэгжилт дээр маш олон талын оролцоо болон маш олон хүчин зүйлст нөлөөлж байгаа. Түрүүн бас Ерөнхий сайд олон асуудлуудыг яриад байх шиг байна. Тэгээд хэрэгжилт дээрээ сайн анхаарах ёстой юм байна лээ шүү гэдгийг сануулж хэлье ээ.

Х.Булгантуяа: Мөнхсоёл гишүүн сая санал хэллээ. Идэрбат гишүүнд микрофоныг нь өгье.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Таныг одоо Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн ХЗДХ-ийн сайдын ажлаа өгөөд Улаанбаатар хот руу явж байхад энэ танхимд Улсын Их Хурлын гишүүд бас олон зүйлийг захиж хэлж байсан. Аж ахуйтай холбоотой, өдөр тутамтай холбоотой, дээрээс нь бодлогын шинж чанартай олон зүйлийг бас тухайн үеийн гишүүд бас хэлж байсан. Тэгээд өнөөдөр бол харин ингээд Монгол Улсын Засгийн газраас ингээд том дэмжлэг аваад ингээд Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2040 гээд ингээд том бодлогын бичиг баримт оруулж ирж байгаад их баяртай байна. Нийтийн тээврийн асуудлууд ч ярьж л байсан ингээд олон зүйл байгаа. Одоо нийтийн тээвэр гэхэд би хааяа суугаад явчихдаг. Давгүй л сайхан аятайхан л болж эхэлж байгаа юм байна лээ шүү дээ ер нь бол. Ингээд нааштай зүйлүүд би байна гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Тэгээд хотын ажил өөрөө хэцүү л дээ. Тэгээд өглөө босоход л нэг асуудал үүсчихсэн, бөөн бухимдал үүсгэчихсэн. Ингэж л байдаг. Асуудал ундарч байдаг ийм л онцлогтой алба. Гэхдээ харин хотын даргын хувьд бол харин асуудлаас зугтаагүй нүүр тулдаг бас шийдэл гаргалгаа ярьчихдаг. Бас хүнийхээ хувьд бол бас тийм нэлээн үзээтэй ингээд байгаад байх нь бол бас энэ хотын энэ олон өдөр тутмын олон тулгамдсан асуудлуудтай харин шийдэхэд их дөхөмтэй байгаа юм болов уу гэж миний хувьд хардаг. Тэгээд зам барьсан чиг л шүүмжлэл дагуулж байдаг. Яасан чиг л шүүмжлэл дагуулж байдаг. Замаа засахаар бордюр гээд л зөрүүлээд л ороод ирдэг гээд ингээд тэгээд зам засахын тулд бордюр солихоос өөр аргагүй стандарттай ийм л улс шүү дээ бид нар. Тэгэхдээ л энэ болгоныг бас зөв талаас нь тайлбарлаад өнөөдөр ийм том бодол бодлогын бичиг баримт оруулаад ирж байгаад нь би бас амжилт хүсье гэж ингэж бас бодож байгаа юм.

Тэгээд манай Их Хурлын гишүүд бас яг энэ 2040-тэй холбоотой нэлээн бодлогын шинж чанартай асуудлуудыг бас хөндлөө.

Миний хувьд бол нэг зарим нэг зүйлийг би бас нэг тодруулга авах нь зүйтэй юм болов уу. Сүүлийн үед ингээд хараад байх нь ээ манай улс төрчдийн, ялангуяа сонгууль дөхөөд ирэхээр л тэдэн онд метрогоор явж эхэлнэ тэдэн онд утаагүй болно гээд аль бараг арван хэдэн жилийн өмнө ярьсан зүйлүүд өнөөдөр гарч ирээд л нүүр тулж байгаа юмнууд зөндөө байна шүү дээ. Тэгээд өнөөдөр бид нар метрогүй байгаа. Өнөөдөр бид нар утаатайгаа байгаа. Бодит байдал маань ийм байгаа. Харин гаргалгаа одоо бас их сайн яриад байгаа. Би тэгээд нэг 2, 3 зүйл дээр би таныг хугацаа богино байгаа юм байна бас товчхон хариулаад өгөөч ээ гэж.

Нэгдүгээрт ер нь Улаанбаатарчууд ер нь хэзээ яг метротой болох вэ? Энэ ингээд олон жил яригдаж байгаа. Одоо энэ чинь хүмүүс метро ярьж байна, дүүжин тээвэр ярьж байна, трамвай ярьж байна. Яг аль нь хэзээ яаж хэрэгжиж эхлэх вэ? Энэ төлөвлөгөө дээр яаж байгаа вэ? Ажлынх нь явц нь та товчхон бас хариулаад өгөөч.

Дээрээс нь энэ Улаанбаатар хотын өнөөдрөөс эхлээд л гаргагдаад эхэлж байна. Энэ томоохон худалдааны төвүүд өнөөдөр ч юу байх вэ ер нь олон жил яригдаж байгаа. Тэгэхдээ өнөөдөр бол бүүр 2 гуравхан сарын дараа гэдэг зүйлийг ярьсан байна лээ. Тэгэхээр энэ Улаанбаатар хотын суурьшлын бүсүүдэд байгаа энэ том худалдааны төвүүдийг гаргах асуудал энэ бас түгжрэлийн нэлээдгүй хувь нь болдог ийм зүйлүүд тэгээд энэ дээр хувийн хэвшилтэйгээ яаж ойлголцож байгаа вэ? Ер нь хэзээнээс нүүлгэж эхэлнэ гэсэн ийм бас төлөвлөгөөтэй байгаа вэ гэдгийг бас би асууя гэж ингэж бодож байна.

Бид бол бас орон нутгаас сонгогдсон Их Хурлын гишүүн. Орон нутагт ард иргэдтэйгээ уулзаад явж байхад энэ Улаанбаатар хотоос гаргаж байгаа энэ шийдвэрүүд дээр зарим тал дээр бол жишээ нь хөдөөгийн номертой машин орж ирээд гарахад төлбөр төлдөг эд нар гээд энэ зүйлүүдийг бас нэг эргэж харж болдоггүй юм уу та бүхэн гээд ингээд яриад байдаг юм.

Тэгэхээр энэ дээр бас хот ямархуу бодолтой байдаг юм. Энд ингээд тогтмол таксинд яваад байдаг машин хөдөөгөөс нэг мах ачаад ирж байгаа нэг хүүхдээ хүргээд өгч байгаа машин 2-ыг ялгаж салгах бололцоо байна уу?

Хоёрдугаарт дараагийн нэг асуудал энэ өчигдөр болоод өнгөрлөө дөө. Энэ газ дэлбэрснээс болоод Улаанбаатар хот стандартгүй байгаагийн гайгаар ингээд олон айл орох оронгүй болсон. Туйлын харамсалтай. Зүгээр гэртээ унтаж байгаад л нэг шөнө орон гэргүй болсон ийм хүмүүс байгаа. Энэ дээр ер нь ямар шийдвэр гаргаж байгаа вэ? Жил болсон гэж би ингэж бас энэ 4 асуултыг асууя.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Би маш товчхон товчхон хариулъя аа.

Метро 2 сарын 28-ны өдөр нөгөө богино листээ хаана. Богино листээ хааж дуусаад эцсийн сонгон шалгаруулалтаа бид нар 4 сар гэхэд эцэслэн шалгаруулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Метроны ТЭЗҮ эцэслэж дууссан. Ирэх 7 хоногт Барилгын хөгжлийн төв болон тээврийн хөгжлийн төвүүдээр магадлуулна. Ингээд магадалгаа дууссаны дараа ТЭЗҮ-ээ батлагдсан ТЭЗҮ-ийнхээ дагуу эцсийн сонгон шалгаруулалтыг хийнэ. Санхүүжилтийн эх үүсвэр бол UKEF буу Их Британийн Засгийн газрын баталгаагаар бид нар энэ метроны эхний 1 дүгээр шугам буюу 17.7 км энэ шугамыг санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа. UKEF гэдэг энэ санхүүгийн хэрэгслийг санхүүжүүлэх сонирхлоо барууны хэд хэдэн болон Азийн дэд бүтцийн төсөл хөтөлбөр санхүүжүүлдэг банкнууд бас илэрхийлсэн. Бид эхнээсээ уулзалтууд хийгээд явж байгаа. Ингээд санхүүжилтийн хувьд бол ерөнхийдөө шийдэгдсэн гэж товчхондоо ойлгож болно. Бид нар барилгын ажил эхэлснээс хойш 4-өөс 5 жилийн хугацаанд гэсэн ийм төлөвлөлт гаргаж байгаа. Геологийн хүндрэл бусад нөхцөл байдлуудаас шалтгаалах байх. Ер нь өрөмдлөг хайгуулын тайлангууд гарсан. 25 метр орчмын гүнд нийтдээ 17км ийм туннелийн байгууламжаар 2 эгнээ ийм метро явна. 17 стэйшнтэй байхаар ингээд төлөвлөгдсөн. Бид нар энэ 2025 ондоо эхэлж барилгын ажлыг эхлүүлэх ийм шахуу төлөвлөгөөтэй явж байна.

Бид нар анх удаагаа энэ ТЭЗҮ-ийг боловсруулахдаа Фидик буюу олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн дагуу Силвер Бүүкээр EPC гүйцэтгэгчийг шалгаруулахаар ингээд төлөвлөж байгаа гэдгийг хэлье.

Туулын хурдны зам 33 км байна. Бид нар та 5 сарын 1 гэхэд барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа. ТЭЗҮ батлагдсан. 28-ны өдөр байна уу? 1 сарын 28, 29-ний өдрүүдэд тендерээ зарлана. Шалгаруулалтыг бид нар нэг 4 сардаа эцэслээд 5 сарын 1 гэхэд бид нар гэрээгээ хийгээд ажлыг нь эхлүүлэхээр төлөвлөж байгаа. Ажил эхэлснээс хойш 24 сарын дотор дуусна гэдэг ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Тойрог хурдны замыг бид нар 6 сарын 1 гэхэд зарлана. Наадмаас хойш сонгон шалгаруулалт хийж дуусна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Яагаад 6 сарын 1 гэхээр ТЭЗҮ боловсруулах ажил явагдаж байгаа. ТЭЗҮ-ийн дагуу бид нар EBC -ийн нөхцөлөөр хийнэ. Тойрог хурдны зам бол нэг 26 км байхаар урьдчилсан байдлаар

трасс гарсан. Дандаа гэрлэн дохиогүй замууд хэлж байгаа шүү дээ. Ихэнхдээ гүүрэн байгууламжаар явна. Эдгээр замууд орсноор Ерөнхий сайдын тэр тайланд дурдсанаар нэг хөдөлгөөний эрчим 40 орчим хувиар нэмэгдэж дундаж хурд нэмэгдэх ийм төлөвлөгөөтэй байгаа.

Х.Булгантуяа: Нямбаатар дарга хариултаа гүйцэд өгье. Ажлын хэсгээс эхний удаад 3 минутаар.

Х.Нямбаатар: Симуляц хийгээд энэний дүнг удахгүй 40 км цаг руу очихоор ийм бас эерэг тоонууд байгаа. Идэрээ гишүүнээ энэ нэг хүмүүст буруу ойлголт байна. Хөдөөгийн машинуудыг бид нар өндөр татвар аваад байгаа гээд. Яг хуучнаараа байгаа. Махаа оруулж ирээд зараад Нарантуулаар ороод буцахад 2 хоног хангалттай. 2 хоногт мянган төгрөг гэдэг тариф хуучнаараа мөрдөгдөж байгаа. Тэрнээс биш хөдөөгийн машинууд орж ирээд хотын хөдөлгөөн дотор ороод халтуур хийгээд явж байгаа тохиолдолд бид нар 48 цагийн 49 дэх цагаас нь эхлээд өдрийн 5 мянга гэдэг ийм тариф руу шилжиж байгаа. Тэрнээс Хэнтий аймгийн Батноров сумаас 400 км-ийн зайнаас орж ирээд 430 км-ийн зайнаас орж ирээд мянган төгрөгөө угаасаа л пост дээр тушаадаг байсан. Дэнжийн мянга гарч махаа зарчхаад маргааш нь Нарантуулаар орж юмаа авчхаад буцахад яг л хуучин тарифаараа явж байгаа. Энийг иргэдэд зөв ойлголт өгмөөр байна аа.

Худалдааны төвүүдийг 4 сарын.

Х.Булгантуяа: Идэрбат гишүүн нэмж тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм. Би ойлголоо. Тэгээд 4 асуулт маань 2 нь дутуу байгаа.

Нэгдүгээрт энэ худалдааны төвүүд дээр би бас их анхаарал хандуулаад байгаа. Бас нэлээн энэ түгжрэлийн шалтгаан тэр орон сууцын асуудал дээр би бас нэг дахиад гүйцэд хариулт авчихъя гэж ингэж бодож байна.

Х.Булгантуяа: Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Худалдааны төв дээр энэ зарим сайтууд жоохон худлаа ташаа мэдээлэл өгч байна лээ. Бид нар Туулын хурдны замыг эхлүүлчхээд худалдааны төв, Нарантуул, Да хүрээ, Хархорин, Барс зэрэг томоохон худалдааны төвийн удирдлагуудтай эздүүдтэй хэлэлцээр эхлэх гэж байгаа. Одоо бид нарын урьдчилан төлөвлөж байгаагаар Баянзүрх хуучин Баянзүрхийн товчооны тэр орчимд Нарантуул болон Да хүрээ хосолсон байдлаар төлөвлөлт хийе ээ гэсэн ийм эхний ажлын даалгавар боловсруулах ажил явагдаж байна. Баруун талдаа одоогийн байгаа авто худалдааны төв түүний эзэмшээгүй талбай дээр мөн Нарантуул, Да хүрээ хосолсон байдлаар явъя аа. Ингээд Улаанбаатар хот руу оролгүй орж ирэлгүй хурдны замынхаа нэг гарц дээр худалдааны төв нь байдаг заавал хот руу орох шаардлагагүй тэндээсээ худалдаа арилжаагаа хийгээд буцаад гарч явдаг байдлаар төлөвлөө гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

Орон сууц дээр юу гэж асуулаа 207 дугаар байрны тэр нураах юун дээр 3 компани саналаа ирүүлсэн. Удахгүй бид нар нураачихвал энэ компани сонгон шалгаруулаад нураачихвал гүйцэтгэлийг санхүүжүүлэх мөнгөө 25 оны төсөв дээр тавьсан. Хуучин байсан барилгынх нь зургаар тендер шалгаруулна аа. Нураахад нэлээн төвөгтэй байгаа. 2 байшингийн нөгөө дифрагм хананы дунд энэ барилга

дунд нь баригдсан учраас тэсэрч дэлбэлж болохгүй дандаа гар аргаар техник хослуулж ингээд нураахаар байгаа 3 компани нураая гэдэг ийм нураах тендерт саналаа ирүүлсэн. Удахгүй ирэх 7 хоногт бид нар эцсийн сонгон шалгаруулалтыг хийхээр төлөвлөсөн гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууна.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөгөө боловсруулаад оруулж ирж хэлэлцүүлж байгаа Улаанбаатар хотынхонд баярлан талархаж байна аа. Ингээд мөн сүүлийн үед Улаанбаатар хот бол эрчим хүчний салбарт нэлээн томоохон төслүүдийг хэрэгжүүлж хөгжилд нь хувь нэмэр оруулж байгаад салбарын зүгээс маш их талархаж байгаа. Ингээд энэ төлөвлөгөөтэй холбоотой нэг 6 асуултыг асууя гэж бодож байна аа.

Нэгдүгээрт болохоор ер нь Улаанбаатар хотод цахилгаан дамжуулах түгээх сүлжээг барьж байгуулахад газрын асуудал маш хүнд болсон. Бид нар хэдхэн жилийн өмнө Их тойрог 110 киловольтын шугамыг барьж байгуулахад бараг арваад жилийг зарцуулж байж битүүрүүлж байсан. Гэтэл бусад орнуудын хувьд болохоор сүүлийн үеийн технологиудыг их хэрэглэж байгаа. Тухайлбал давхар утастай шугам хэрэглэж байна.

Дээрээс нь нэг тулгуур дээр хэд хэдэн хүчдэлийн шугамуудыг татаж байна. Дэд станцуудаа газар доор барьж байна гэх мэтчилнээр олон аргуудыг хэрэглэж байна. Түүнээс гадна ингээд Улаанбаатар хотод жишээ нь ингээд гэрлэн дохионы хажууд ингээд зогсож байхад бараг 5, 6 шон ингээд хажууд байж байгаа байхгүй юу. Түгээхийн шугамын шон, гэрэлтүүлгийн шон, замын тэмдэглэгээний шон гээд гэх мэтчилнээр. Гэтэл бусад орнуудын хувьд энд нэгхэн шон дээр бүх энэ асуудлуудыг шийдсэн байдаг.

Тэгэхээр энэ төлөвлөгөөний хувьд Улаанбаатар хотын хувьд энэ цаашдын төлөвлөгөөндөө эдгээр орчин үеийн ялангуяа энэ том хотуудын хувьд авч хэрэгжүүлдэг аргуудыг хэрхэн авч үзэж байгаа вэ? 2 дугаар асуудал нь энэ асуудлыг би их ярьж байгаа. Улаанбаатар хотод цахилгаанаас үүдэлтэй гал түймэр маш их гарч байгаа. Зүгээр л хэдхэн жилийн өмнө хүүхэд эмийн сан руу орох гэж байгаад л бариулаас нь бариад л нас барж байгаа. Тэгэхээр явал энэ цахилгаанаас үүдэлтэй гал түймрийг гаргахгүй байлгах вэ гэдэг тал дээр Улаанбаатар хот, ЭХЯ, Барилга, орон сууцын яам өнөөдөр ач холбогдол өгөх зайлшгүй шаардлагатай болсон.

Барилгын дотор цахилгаан хангамжийн зураг төслийн хувьд нөгөө л дээр үеийнхээ Оросоос хуулсан стандартаа ашигладаг, ерөөсөө шинэчилдэггүй, ач холбогдол өгдөггүй. Хамгийн гол нь стандарт гэдэг маань цаанаа нарийн онол байдаг. Гэтэл тэр онолоор хүмүүсийнхээ тархийг цэнэглэхгүй бол өнөөдөр тэр стандарт бодит амьдрал дээр хэрэглэгдэхгүй ээ. Тэгэхээр энэ чиглэлд ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа вэ? Явал энэ гал түймрийг байхгүй болгох вэ?

Гуравдугаар асуудал болохоор ерөөсөө зөв хөгжлийн үндэс стандарт бас дахин стандарт. Өнөөдөр хөрөнгө оруулалт үргүй болж байгаа. Чанаргүй болж байгаа. Гол асуудал бид нар стандартаа ач холбогдол өгдөггүй. Нөгөө л ихэнх стандартууд Оросоос хуулсан хуучин стандартууд. Сүүлийн үед нэгийг харьцах нь нэг гээд стандартууд маш их орчуулж байна. Тэгээд тэр стандартууд нь нөгөө

Стандарт хэмжил зүйн үндэсний төв гээд нэг байшинд хураагддаг. Ерөөсөө бодит амьдралд хэрэглэгддэггүй. Яагаад гэвэл бас л адилхан стандарт маань нарийн онол байдаг. Тэр стандартаар хүмүүсийнхээ тархийг цэнэглэдэггүй. Тэгэхээр энэ чиглэл дээр ямар ажлуудыг хийх вэ? Бид нар үнэхээр орчин үед зөв хөгжилтэй ийм хотыг бий болгоё гэвэл хамгийн нэн тэргүүнд стандартад ач холбогдол өгдөг хөрөнгө санхүүгээ зарцуулдаг хүн хүчээ зарцуулдаг ийм болж байж л бид нар хөрөнгө оруулалтаа чанартай орчин үеийн зөв хотыг хөгжүүлж чадна аа.

Гуравдугаар асуудал болохоор бид нар нарны панел батарейг айл өрх ААН-үүд суурилуулаад илүүдэл цахилгаанаа сүлжээ рүү борлуулдаг тийм тогтолцоог бий болгоё. Боломжийг бий болгоё гэж зорилт тавьсан. Тэгэхээр энд Улаанбаатар маш их хамааралтай. Тэгэхээр нэг цөөхөн айлуудад энэ нарны панел батарейг суурилуулахаар хөрөнгө оруулалтын хувьд маш өндөр тусаад байгаа. Тэгэхээр энийг бол 10 мянган айл, 20 мянган айлууд дээр мега төсөл байдлаар ялангуяа нарны панел батарей үйлдвэрлэдэг үйлдвэрүүдтэй хамтарч хөтөлбөр болгож хэрэгжүүлдэг. Бусад улсуудын хувьд. Тэгэхээр Улаанбаатар хотын хувьд энэ 2025, 2026 онуудад энэ чиглэлд ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа вэ?

Тавдугаар асуудал болохоор.

Х.Булгантуяа: Энхцэцэг гишүүний микрофоныг нэмж өгье.

М.Энхцэцэг: Тавдугаар асуулт болохоор Улаанбаатар хотын хууль дээр энэ дулаан, цахилгаан, ус хангамжийн байгууллагуудын жилийн орлогын 1.5 хүртэлх хувийг дэд бүтцийн санд төвлөрүүлнэ ээ гэж ингэж заасан байна. Тэгэхээр энэ дээр жилд хэдий хэмжээний хөрөнгө төвлөрнө гэж төлөвлөж байгаа вэ? Энэ сан хэрхэн зарцуулах гэж байгаа вэ? 6 дугаар асуудал болохоор дулааны цахилгаан станц 2-ын байран дээр ДЦС-5-ыг барьж байгуулна гэж Улаанбаатар хот төлөвлөж байгаа. Тэгэхээр энэний санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа вэ? Хэзээ эхлээд хэзээ дуусна гэж төлөвлөлтийг хийсэн байгаа вэ гэсэн ийм 5 асуултыг асууя.

Зургаа дахь нь болохоор ДЦС-5. Тэгэхээр санхүүжилт нь яаж хийгдэх вэ? Хэзээ эхлээд хэзээ дуусахаар төлөвлөж байгаа вэ гэж.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдэд бас хэлэхэд энэ нөгөө даргын дэргэдэх зөвлөл дээр асуудлуудыг хэлэлцэх хугацааг тохирдог. Нийтдээ 4 цаг хэлэлцэхээр тохирсон. Энэ асуулт хариулт аль аль нь ороод тэр. Одоо нийт асуулт асуухаар нэр өгсөн гишүүдийн тал нь орчихсон. Цаг нь тэрнээсээ илүү давчихсан байна шүү. Тэгэхээр ажлын хэсгийн гишүүд маш товч бөгөөд тодорхой. Эхний асуултад хариултад 3 минут өгч байгаа. Тэгээд 1 минутаар сунгаад явах боломжтой байгаа. Тэгэхээр аль болохоор товчхон хариулахгүй бол сүүлийн хэдэн гишүүд маань асуулт асууж хүрэхээргүй болчхож байна.

Х.Нямбаатар: Энхцэцэг гишүүний асуултад хариулья аа.

Өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа ерөнхий төлөвлөгөө гэдэг бол хот суурин газар. Эс үгүй бол бүс нутгийн урт хугацааны хөгжлийн чиглэлийг тодорхойлсон стратегийн баримт бичгийг хэлж байгаа. Тухайн нутаг дэвсгэрийн газар ашиглалт, барилга байгууламжийн байршил, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ, байгаль орчны хамгаалалт зэрэг төлөвлөлт хийхийг, төлөвлөлттэй холбоотой бүхий л асуудлуудыг ерөнхий төлөвлөгөө гэж байгаа юм. Энэ ерөнхий төлөвлөгөө

батлагдсаны дараа салбарын яамдууд энэхүү ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх стандартуудыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл таны шаардаж байгаа саяын стандартын асуудлыг ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа энэ дамжуулах шугамуудыг газраар явуулах уу, дээгүүр явуулах уу, давхар тохох уу гэдгийг ЭХЯ аягүй тодорхой хариулах байх гэж бодож байна.

Газар чөлөөлөлттэй холбоотой асуудал яг үнэн 110-ын шугамыг 10 жил газар чөлөөлөлтөөсөө болоод гацсан. Зайсангийн баруун талд ирээд л гацчихсан. Тэгэхээр бид нар өнгөрсөн жил хуульд өөрчлөлт оруулаад энэ гэр хорооллыг орон сууцжуулах барилгажуулах хууль тухайн траст өртсөн айлуудын 70 хувь нь дэмжсэн тохиолдолд газрыг дэд бүтцийн энэ төсөл хөтөлбөрт зам тавихын тулд албадан чөлөөлөх зохицуулалтыг бид нар анх удаа оруулсан.

Тийм учраас Сэлбийн энэ газар чөлөөлөлт ийм өндөр хувьтай явж байгаа гэж хэлж болно. Сэргээгдэх эрчим хүчин дээр сая бид нар нэлээн бас хүнд байдалтай болсон. 11, 12 сард сэргээгдэх эрчим хүчний маань хэд хэдэн салхин станцууд хэд хоногоор зогссон. Салхи гараагүй бүрхэг өдрүүдэд нөгөө нарны станцуудын маань төвийн эрчим хүчний систем нийлүүлэх чадал дутагдсан. Тэгэхээр энэ сэргээгдэх эрчим хүчийг бид нар цаашид ЭХЯ барьж байгаа бодлоготой бид нар уялдуулж явъя гэж байгаа. Энэ заавал батарей хураагууртай нь хамтад нь шийдэж байж төвийн эрчим хүчний оргил ачааллын үед гэнэтийн ийм огцом ачааг нөгөө ТЭЦ-4, 3-даа үүрүүлэхгүй байх үүднээс заавал хосолж явъя гээд. Тэгээд сая Улаанбаатар хот өнгөрсөн энэ өвлийн улиралд үндсэндээ 200мвт-аар төвийн эрчим хүчний системийн оргил ачааллыг дэмжих ийм хөрөнгө оруулалт хийсэн. Энэ амжилттай болсон. Энэ жил бид нар сэргээгдэх эрчим хүчин дээр ямар бодлого барьж байгаа вэ гэвэл энэ саяын өнөөдрийн Хүннү гэдэг хотын эрчим хүчийг ер нь 100 хувь цэвэр эрчим хүчээр хангая гэдэг ийм тендер сонгон шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байгаа.

Дээр нь одоо бид нар геотерма буюу дулаан хангамж дээр газрын гүний дулааны хайгуулыг Хүннү хот дээр бид нар бас эхлүүлэхээр ингээд явж байгаа. Ингэж чадах юм бол Хүннү хот цэвэр эрчим хүчний хот болно гэж байгаа юм.

Тавдугаар цахилгаан станц дээр бид нар аль болох нөгөө урьдчилгаа төлбөргүйгээр төр хувийн хэвшил дээр ВОТ нөхцөлөөр явах ийм хэлэлцээрүүдийг эхлүүлээд явж байгаа гэдгийг танд товчхондоо хэлье. Дэд бүтцийн сан дээр бид нар яг энэ хуулийг бий болгож чадсаны үр дүнд.

Х.Булгантуяа: Нэг минутаар сунгаад өгчихье. Нэлээн олон асуулт асуусан тул.

Х.Нямбаатар: Яах вэ бид нар энэ сэргээгдэх дээр сая ерөнхий бодлогоо ярилаа. Дэд бүтцийн сан гэдгийг бид нар хуульд зориуд оруулж ирсэн. Ер нь өмнө нь энэ хотын хот суурин газрын дэд бүтцийн сан гэдэг ойлголт ерөөсөө огт байгаагүй. Сая бид нар өнгөрсөн хавар 5 сард хот тосгоны хуулийг батлуулахдаа дэд бүтцийн санг заавал бий болгох дэд бүтцийн сан нь цаашид тухайн төсвийнхөө тодорхой төсвөөс бүрдэж байхаар ийм зохицуулалт хийж өгсөн. Бид нарын 2040-ийн хүрээнд 41 их наядыг энэ дэд бүтцийн сандаа төвлөрүүлж гэдэг ийм төлөвлөлтийг оруулж өгсөн гэдгийг товчхондоо хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин.

Д.Энхтүвшин: Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэж тогтоол батлахыг дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр нэг асуудал байгаа. Тэгээд энэ нийслэлийн хувьд бол мэдээж дэд бүтцүүдийг тэлэх энэ бололцоо боломжууд нэлээн өргөн нээгдэх юм байна гэж харж байгаа. Тэгээд нийслэлийн иргэдийн хувьд 2 л гол асуудал байгаа шүү дээ. Агаарын бохирдол түгжрэлтэй холбоотой. Тэгэхээр түрүүн бас Соронзонболд гишүүн асуусан тэгэхээр яах вэ энэ дээр яг тайланг үзэхээр хамгийн гол 2 чухал үзүүлэлт түгжрэл гэдэг чинь яг тоон үзүүлэлтээр хэмжээд үзэхээр юу юм. Агаарын бохирдол гэдэг чинь хэмжээд үзэхээр юу юм гэдэг үзүүлэлтүүдээ яг тодорхой болгоод өгчихвөл бас амар юм уу гэсэн иймэрхүү бодол тайлангаас үзэхэд тэгж санал харагдлаа.

Тэгэхээр жишээлбэл агаарт ялгагдаж байгаа хийн хувьд бол, жишээлбэл РМ 2.5, 10 гэдэг нь жишээлбэл гэр хорооллын ялгаруулж байгаа болон автомашин нь жишээлбэл 3 дахин зөрүүтэй. Энэ дээр бол автомашины жишээлбэл нөлөөлөл нь өндөртэй нүүрстөрөгчийн дутуу исэл дээр гэр хороолол нь автомашинаасаа 2.5 дахин хүхэрлэг хий дээр автомашинаасаа гэр хороолол нь 18 дахин их азотын давхар исэл дээр автомашин нь илүү нөлөөтэй гэх мэтчилнээр өөр өөр нөлөөтэй үзүүлэлтүүд байгаа харагдаад байгаа. Тэгэхээр энийг нэг болгочихвол Алсын хараа 2050 дээр болохоор зөвхөн РМ2.5, РМ10-ыг жишээлбэл үзүүлэлтийг тавиад 80 хувиар хүртэл буулгана гэж 2025 он хүртэл ийм зорилт тавьсан байгаа. Тэгэхээр энэ агаарын бохирдол дээр 1 дүгээрт түгжрэл дээр ч гэсэн тайлан дээр харахаар бас хэд хэдэн өөр өөр үзүүлэлтүүд харагдаж байна. Автомашины дундаж хурд гэсэн нэг үзүүлэлт явж байна. Замын сүлжээний нягтрал тэгээд оргил цагийн хөдөлгөөний дундаж хурд замын ачаалал гэсэн хэд хэдэн ийм үзүүлэлтүүд ярьж байгаа.

Ер нь агаарын бохирдлууд дээр бол агаарын бохирдлын индекс гээд үзүүлэлтүүд бас гарч байгаа. Дээр нь түгжрэл дээр ч гэсэн түгжрэлийн индекс замын зорчих цагийн индекс ч гэдэг юм уу энэ үзүүлэлтүүдээ дунд нь гарчихсан ийм үзүүлэлтүүд байдаг. Тэгээд ингээд гаргачихвал дараа нь бид хэд ярихад ч гэсэн амар юм уу гэж бодож байна. 2040 гэдэг чинь бараг 4 сонгууль дамжина. Тэгэхээр 1 үзүүлэлтүүдээ агаарын бохирдол гэдэг нь яг юу юм? Түгжрэл гэдэг нь юу юм гэдэг үзүүлэлтүүдээ бүгдээрээ нэгдсэн нэг ойлголттой болоод тэр үзүүлэлтүүдээ бариад л энэ төсөл хөтөлбөрүүд ч гэсэн нэлээн том хөрөнгө оруулалтууд явж байна. Эд нарыг эрэмбэлэхдээ ч гэсэн аль нь илүү яг тэр агаарын чанар гэдэг хэмжигдэж байгаа тэр үзүүлэлтийг буулгачих юм. Аль нь энэ түгжрэлийг бууруулж хэдэн нэгжээр буулгачих юм гэдэг үзүүлэлтүүдээ гаргаад эрэмбэлээд явбал бас их цаашдаа зөв юм болов уу гэсэн ийм бодолтой байна. Тэгэхээр та хэд бас энийг энэ хөтөлбөр батлагдаад ирэхээрээ яг нэг тодорхой үзүүлэлт болгоод тэрийгээ энэ олон нийтэд ч гэсэн бас тодорхой хэмжиж үзүүлээд л. Тэгээд жишээлбэл засаг солигдсон энэ чинь хотын даргууд 2, 3 дахь сонгуулийн дараа өөр байсан ч гэсэн яг л нэг үзүүлэлтээ хараад тэр үзүүлэлт нь хэний үед хэд байж байгаад хэд болгож буурчхав гэдэг ийм 1 нэгдсэн 1 ийм ойлголттой болчихвол зүгээр юм уу гэсэн. санал л хэлчихье дээ.

Асуултын хувьд бол түрүүн Соронзонболд гишүүн асуучихсан учраас ер нь цаашаа ажиллах юм байна гэж ойлгосон. Тэгээд амжилт хүсье.

Х.Булгантуяа: Энхтүвшин гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал.

Ж.Золжаргал: Баярлалаа. Улаанбаатар хот дахин төлөвлөлтийн хүрээнд хуучирсан орон сууцнуудыг дахин төлөвлөхдөө эрчим хүчний хэмнэлтийн А түвшнийг хангана гээд тусгачихсан байсан. Тэгээд олон улсын жишиг нь А, В, С, D гээд байдаг. С-ээс дээшээгээ 20 хувиар хэмнэлттэй байх юм бол хэмнэлттэй гэж үздэг. А бол хэтэрхий чанга. Гэр хорооллын төлөвлөлт дээр мөн ялгаагүй. 50 мянган айлын түвшинд хангана. Тэгвэл ингээд ипотек өгнө. 120-ыг нь бол орон сууцжуулна гээд. Тэгэхээр энэ А гээд тавьчихаар хэтэрхий өндөр яг тийм цэвэр пассив технологи нэг төрлийн өндөр материалтай үнэтэй материалтай юм дэмжсэн ийм хатуу заалт тавих хэрэг байгаа юм уу? Монголын барилгын норм дүрэм дээр чинь С гээд байгаа. Нэмэх нь 20 олон улстай жишгээрээ тооцдог оо. Ингээд хязгаарлачих юм бол нөгөө ипотекийн зээл чинь хүртээмж нь хязгаарлагдчихна шүү дээ. Яагаад ийм хатуу түвшин тавьсан бэ? Зүгээр эрчим хүчний хэмнэлттэй олон улсын жишгээр гэж болоогүй юм уу?

Хоёрдугаарт нь гэр хорооллыг ингээд байшин дулаан сууц орон сууцжуулаад 2030 он хатуу түлш хэрэглэхгүй ээ гэж Нямбаатар дарга хэлсэн. Бас өчигдрийн таны танилцуулга дээр уржигдрын ч билүү. Багануурт хөх нүүрсний үйлдвэр барина гээд. Тэгэхээр тэр чинь хэдэн их наяд төгрөг болно. Хөрөнгө оруулалт татаас нийлээд. Тэгээд барьсаар байтал 28, 29 он болно. Тэгээд ганц жил ашиглах юм уу хатуу түлш 30 онд хэрэглэхгүй наана нь хөх нүүрсний үйлдвэр барьж яах гэж байгаа вэ?

Гурав дахь асуулт нь хийн хоолой тусгачихсан байгаа. Хийн түлшээ Оросоос авах гэж байгаа юм уу эсвэл нөгөө Багануурын нүүрснээс хий үйлдвэрлэх төслөө сэргээх гэж байна уу? Монгол Улс Дэлхийн банкнаас 2.1 сая доллар зээлээд Хятадын инженерингийн том компаниар зундаа бензин, өвөлдөө нийлэг байгалийн хий гаргаж Улаанбаатарыг хангах ТЭЗҮ-ийг хэдэн жилийн өмнө их хийсэн. Тэгээд тэр нь энэ Засгийн яамны дэргэд тэгээд тэрийгээ сэргээх юм уу яах гэж байгаа юм болоо. Зээлийг нь төлсөн юм болов уу яах гэж зээл авсан юм болоо гээд.

Дараа нь 14 хотдоо 14 төвтэй болох нь байна. Тэгэхээр нөгөө хотуудын маань индекс нь инженерийн дэд бүтцийн хөгжлийн түвшнээрээ 1.3-аас 4.7 маш том зөрөөтэй байгаа. Тэгэхээр эдийн засгийн хөгжлийг нь жигдрүүлэх ямар төлөвлөгөө байгаа вэ? Нэг нь бүүр хоцрогдоод нөгөөх нь ингээд урагшаа явчихсан. Иймэрхүү нөхцөлүүд үүсчихээр нөгөө нэг хот гэж явж байсан маань бодлогын хувьд зөрөөд түвшин нь хэтрээд холдоод явчих юм биш биз дээ? Тэгээд туннел нөгөө Богд уулын доогуур явах туннел улсын төсөв дээр байж байгаад байхгүй олдохоо байчихсан. Тэгээд тэр нийслэл дээр байгаа юм уу? Энэ зураг дээр нэг тасархай зураас харагдсан. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч ээ.

0.07 га талбай газраа авч чадаагүй хүмүүс зөндөө олон байна. Ядаж концепцын түвшинд Улаанбаатар ингээд дагуул хот энээ тэрээ хөгжөөд ингээд явахаар тэр шинэ Зуунмод байна уу, Хөшигийн хөндий байна уу ийм хүмүүстэй бүх газрыг нь авч чадаагүй хүмүүст олгох ийм орон зай байна уу. Энэ тал дээр бодсон уу? Тэгээд эцэст нь метро BRT, LRT дүүжин тээвэр гээд олон төрөлтүүдийг тусгасан байна. Тэгээд яармагаас 120 руу явахад метро барих маш үнэтэй хувилбар хэрэггүй санагдах юм. BRT эсвэл LRT буюу тэр трамвайг тооцож байгаа юу хамаагүй хямд шүү дээ. Энийг асууя. Тэгээд дүүжин тээврийг ер нь яагаад заавал хэрэгжүүлэх гээд бид нар зүтгээд байгаа билээ.

Хэрвээ Францдаа уран хийгээд хажуугаар нь гоё төсөл хэрэгжүүлэх шаардлагатай бол ураны гэрээ байгуулагдчихсан. Тэгээд энэ бас нэг их тийм гоё ч зүйл биш их үнэтэй зүйл байгаа. Энэ дээр нэг хариулт өгнө үү? Баярлалаа.

Х.Булгантуяа: Бараг арваад асуулт асуулаа. Нямбаатар даргаас эхэлье.

Х.Нямбаатар: Сүүлийнхээс нь хариулъя. 2019 онд Монгол Улсын Засгийн газар 19 оны нөгөө төгсгөл 20 оны шинэ Засгийн газар гарахын өмнө Монгол Улсын Засгийн газар, Франц улсын Засгийн газрын хооронд энэ дүүжин тээврийн хэлэлцээр байгуулагдсан юм байна лээ. Тэгээд байгуулагдсан гэрээг хот зөрчих эрх байхгүй. Цуцлах эрх байхгүй Золоо гишүүн ээ. Тийм тэгээд бид нар хэрэгжүүлэх л үүрэгтэй. Тэгээд ямар ч байсан нэг шугамыг нь бид нар ингээд ямар ч байсан ашиглалтад оруулъя нэгэнт хийгдчихсэн гэрээ гэдгээр явж байгаа. Тэгээд тэрийг тухайн үед байгуулсан гэрээ хийсэн хүмүүсээс нэмж тодруулна биз.

Яармагаас биш цаашаа нөгөө мөсөн ордон буюу Степ Арианагаас Улаанбаатар хотын төв хүртэл бид нар эхний ээлжид Трамвайны ТЭЗҮ-ийг боловсруулж байгаа. ТЭЗҮ дуусмагц бид нар энэ ондоо багтаж Трамвайны төслийг наашаа хэрэгжүүлэхээр ингээд тендер зарлахаар тендер зарлахаар явж байгаа гэдгийг хэлье.

0.07 га газар бол хот суурин газруудад үндсэндээ гамшиг авчирсан. 0.07 га газар дээр нэг ч инженерийн шугам татах боломжгүй. Хамар хамраараа хашаа барьчихаж байгаа. Харин хашаа болгонд хэд хэдэн жорлонгийн нүх ухаж байгаа. Тэгэхээр би бол Улаанбаатар хотод дахиж 0.07 га газрыг олгох ёсгүй ээ гэдэг ийм байр суурьтай байдаг. Тийм ч учраас тийм хууль санаачилж батлуулсан. Та Хөшгийн хөндийг дахиж жорлонгийн баахан нүх болгох ямар сонирхол байна аа? Би энийг дэмий гэж бодож байна аа.

Туннелтэй холбоотой асуудал төсөв нийслэл дээр байхгүй ээ. Зам тээврийн сайд Дэлгэрсайхан сайд ТЭЗҮ-ийг нь боловсруулах ажил хийгдэж байгаа. Та Дэлгэрсайхан сайдаас дэлгэрэнгүй мэдээлэл аваарай. 14 хот 42 нэгж хорооллын гол үндсэн концепц нь өнөөдрийн бид нарын 2040 гэдэг энэ төлөвлөгөөний гол амин сүнс юм аа. Бид нар жигд хөгжүүлж 20 минутын хот гэдэг энэ концепцоор хотыг хөгжүүлэх гэж байгаа юм аа. Хүн нийгэм соёл эрүүл мэнд, боловсрол, ахуй үйлчилгээгээ өөрийнхөө амьдарч байгаа тэр гэрээсээ 20 минутын зайд алхаад авдаг ийм боломжийг бүрдүүлж чадах юм бол? Хот дамжсан хэрсэн өдөртөө 3 сая автомашины зорчилт хөдөлгөөнийг бид нар багасгах ийм зорилгоор энэ төлөвлөгөөг оруулж ирсэн. Коксын үйлдвэр буюу Багануурт байгуулагдах үйлдвэр Багануурын нүүрсний ордыг түшиглэсэн нүүрс Пиролизын үйлдвэрийн зөвхөн нэг хэсэг нь юм аа.

Хөх нүүрс үйлдвэрлэснээр зөвхөн Улаанбаатарыг хангах гээд байгаа зүйл биш ээ. Бусад аж үйлдвэрийн салбарууд болон бусад хот суурин газруудыг хангах ийм зорилготой нүүрсний үйлдвэр ээ.

Газын төсөл бол бид дэд бүтцээ барья. Засгийн газар татаас олговол бид нар 2030, 2031 оноос нүүрс түлэхээ больё л гэж байгаа. Тэгэхээр засаг эцсийн шийдвэрээ гаргаж өгөөгүй байгаа.

Х.Булгантуяа: Нэлээд олон асуулт байсан учраас нэмэлт нэг минут өгье.

Х.Нямбаатар: Газын шугам сүлжээ бол бүх төрлийн LPG, LNG, CNG тийм ээ, бүх төрлийн газуудыг дэмждэг ийм дэд бүтцийг бол Улаанбаатар хотын гэр хороололд инженерийн шугам сүлжээгүй газруудад татах төлөвлөгөөн дээрээ хот ч хэвээрээ байгаа. Энийг бүхэлд нь хот өөрөө газын шилжилт рүү явахыг Засаг Их Хурал дэмжээд жил болгон татаасыг нь тавьж өгвөл би нөхцөлтэй хэлж байгаа шүү. Татаасыг нь тавьж өгсөн тохиолдолд 2030, 2031 он гэхэд Улаанбаатар хот бүхэлдээ шилжинэ ээ. ОХУ-ын газфром манай Улаанбаатар хотыг LNG-ээр бүрэн хангахад бэлэн байна гэдгээ илэрхийлж байгаа. Цаашид би хэллээ. Энэ татсан дэд бүтэц нь аль ч төрөл рүү хувирч болно. Одоо Нялга Чойрын ордод хэд хэдэн завсрын хийний судалгаа хийгдэж байгаа. Энэ Төв аймгийн Баян сумын нутагт ч гэсэн бас тодорхой судалгааны ажлууд хийгдэж байгаа. Өмнөговьд ч гэсэн эхний илэрцүүд гарчихсан байгаа.

Х.Булгантуяа: Харин тийм. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн. Ажлын хэсгийнхэн маань маш товч бөгөөд тодорхой хариулна шүү.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. 2040 Улаанбаатар хотын энэ шинэ концепцыг дэмжиж байна. Энэ дээр зүгээр яг эрүүл мэндийн салбартай холбоотой 3.6 дээр хотын орон зай төлөвлөлт бүсчилсэн дүрэм гэдэг дотор эрүүл мэндийн асуудал нэлээн хаягдсан мэт надад харагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр би тодруулж асуумаар байгаа юм.

ЭМЯ энэ бодлого дээр нь оролцсон уу? НЭМГ оролцсон уу? Бид ерөөсөө энэ дэлхий нийтийн жишиг бол нэг цонхоор үйлчилгээ авдаг ийм тогтолцоо хийхээр бас төлөвлөөд байна шүү дээ. Тэгээд 100 мянган иргэнд 1 нэгдсэн эмнэлэг байхгүй бол баахан жижиг жижиг клиникүүд тэгээд л нөгөө иргэдийн кармаг хоосолдог. Тэгээд тусламж үйлчилгээ нь олон газар жигд хүргэж чадахгүй байх ийм явдал үүсээд байна. Жишээлбэл одоо сайжруулсан амины орон сууц нам давхрын орон сууц, дунд давхрын орон сууц, холимог бүс гээд л энэ дотор нэгдсэн эмнэлэг гэдэг дээр нэг ч нэмэх чагт байхгүй байна. Нэг ч нэмэх чагт байхгүй байна.

Дээрээс нь түргэн тусламжийн үйлчилгээг нөгөө л төвлөрсөн систем рүү оруулах ийм бодлого яваад байгаа юм. Уг нь энэ гал команд шиг аль болохоор л энэ нэгдсэн эмнэлэг рүүгээ дөхсөн 100 мянган иргэн дотроо үйлчлэх ийм түргэн тусламжийн тогтолцоо энэ тэр гээд ийм том концепцын өөрчлөлтийг эрүүл мэндийн тусламж чиглэлд алга байна аа. Эс үгүй бол энэ дээр тэмдэглээгүй юм болов уу? Энэ дээр нэг хариулт өгөөч. Энэ их зөв асуудал боловч эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс хамаарч иргэдийн ерөөсөө хамгийн чухал зүйл энд байгаа концепц дотор чинь 20 минут дотор эмнэлгийн тусламжаа авна гэсэн концепц байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр яагаад энэ дээр энэ тэмдэглэгээнүүд ороогүй юм бэ? Тэгээд эрүүл мэндтэй холбоотой зүйлүүдийг энэ бидэнд өгсөн материал дотор хайхад ерөөсөө ганцхан ийм л зүйл байна. Энэ дээр тайлбар авъя аа.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар дарга Чинбүрэн гишүүний асуултад хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Чинбүрэн гишүүн ээ нэг зүйлийг хэлэхэд ер нь энэ ерөнхий төлөвлөгөө гэдэг бол орон зайн төлөвлөлтийн асуудал. Таны сая сүүлд

ярьж байгаа нэлээн нарийвчлаад эрүүл мэндийн салбарын бодлого тал руугаа та илүү асууж байна. Зүгээр манай энэ 2040 дээр тэр дагуул хот болгонд таны ярьж байгаа 2 дугаар шатлалын эмнэлгүүдийг бий болгоё. Ингэснээрээ 14937 ор нэмэгдэнэ ээ. Ингэснээрээ 57427 үзлэг өдөр нэмэгдэнэ гэдэг ийм ерөнхий төлөвлөлтүүдийг оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл хүртээмжийг бид нар илүү бий болгоё. 20 минутынхаа хот дотор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 2 дугаар шатлалд авдаг тусламж үйлчилгээг бид нар бий болгож өгье л гэдэг ийм зүйл ярьж байгаа. Энэнээс цааш 2040 батлагдсанаас хойш энэ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ДЭМБ-ын шинээр дэвшүүлж байгаа бодлогын хүрээнд яаж хэрхэн шинэчлэгдэх бол? Тухайн салбарын яам энэ бид нарын бий болгосон хатуу зөөлөн дэд бүтэц дээр энийг илүү боловсронгуй болгох бодлогын асуудлыг тэнд зангидах асуудал байх гэж бодож байна.

Х.Булгантуяа: Чинбүрэн гишүүн нэмж асууя.

Ж.Чинбүрэн: Ойлголоо. Тэгэхээр энэ хөтөлбөр дотроо ер нь тэгэхдээ энэ өгүүлбэр байж байх хэрэгтэй шүү. Ерөөсөө яг энэ дагуул хот суурин газруудад нэгдсэн эмнэлгийн тогтолцоо байна л гээд хэлчихвэл энэ чинь ойлгомжтой болох гээд байгаа юм. Таны хэлж байгаа санаа чинь яг л энэ дээр тусах гээд байгаа шүү. Энийг анхаараарай. Баярлалаа.

Х.Булгантуяа: Чинбүрэн гишүүн санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Энэ 2040 гээд энэ төлөвлөгөөтэй нэлээн сайн танилцсан. Танилцахдаа дандаа орчны бохирдолтой холбоотой хэсгүүдийг нь нэлээн их харлаа. Тэгээд 2040 он гэхэд энэ орчны аливаа бохирдолгүй Улаанбаатар хот бол их сайн байна даа. Тэгээд ямартай ч нэлээн тийм том маш сайн төлөвлөлттэй гэмээр харагдах байдал нь. Тэгээд их зузаан олон зүйлийг авч нэгтгэсэн ийм төлөвлөгөө орж ирлээ гэж бодсон. Тэгээд багийнхан нь бас ирсэн байх шиг байна. Талархал илэрхий хийлэх хэрэгтэй. Их сайн ажлаа хийж байгаа гэж үзэж байгаа.

Орчны бохирдол болохоороо энэ агаарын бохирдлын талаар гишүүд нэлээн асуулаа. Их л ажлууд хийгдэх талаар ярилцсан. Энэ дотоод орчин талдаа харин өгүүлбэр байхгүй байсан. Тэгээд энэ дээр нэмэлт асуулт бас асуучих хэрэгтэй байх юм. Бид нарын энэ сууж байгаа өрөө ч гэсэндээ энэ ашиглагдсан байгаа будаг энэ материалууд бас бид нарын эрүүл мэндэд ер нь энэ стандарттай яг нийцэж байна уу нөгөө олон улсад яригдаад байдаг хар тугалганы хордлого бас энэ ард хар тугалга нь их хэмжээгээр агуулагдаад байна уу гээд олон жишээнүүд яг Их Хурлын гишүүн нэрээр хаяглагдаад төрийн бус байгууллагуудаар ирэх юм.

Тэгээд энэн дээр хэрвээ дотоод орчны бохирдол энэ барилгад хэрэглэгдэж байгаа энэ будаг янз бүрийн зүйлүүдэд нь стандартад нь нийцсэн байх. Одоо энэ хар тугалганы хордлого нь жишээлбэл бага насны хүүхдүүдийн сэтгэл мэдрэлийн асуудалд бас их сөргөөр нөлөөлдөг гэсэн ийм судалгаанууд хүртэл нэлээн олон жилийн өмнө гарч л байсан юм билээ. Тэгээд энэ чиглэлээр үг өгүүлбэр байхгүй байсан учраас яах вэ зүгээр асуултаа юу гэж асуумаар байна гэхээр танай бүтэн багийнхан ирсэн байгаа учраас яг энэ холбогдолтой мэдээллүүдээ сайн мэдэж байгаа судлаачдаас нь мэдээллээ нэгтгээд та хэдэд өгөхөд бэлэн байна. Ингэж өгч болох уу? Яаж өгөх вэ? Стандартууд нь миний л ойлгосноор нэлээн хуучирсан л

байдаг юм шиг байна лээ. Тэгээд ядаж Улаанбаатар хотдоо бид нар ингээд дотор сууж байхдаа эрүүл тийм орчинд байчихвал бас их сайн л байна. Тэгээд энэ дээр л богинохон хариулаад өгөөрэй. Яаж энэ төлөвлөгөөнд яг энэ агуулгаар нь мэдээлэл бэлдэж өгөх вэ? Тэгэх боломжтой биз дээ.

Х.Булгантуяа: Болдын Уянга гишүүн ажлын хэсгийн 20 номерын микрофон. Дотоод орчны агаарын чанарын асуудлаар асуулт асуулаа.

Ц.Баярбат: Уянга гишүүний асуултад хариулъя. Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яамны газрын дарга Баярбат. Гишүүний ярьж байгаа хөндөж байгаа асуудал бол маш чухал байгаа. Энэ асуудлаар манай яам нэлээн анхаарал тавьж ажиллаж байна. Түүнээс гадна энэ дотоод орчны чанарын стандартыг шинэчлэхтэй холбоотой ажлын хэсэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаман дээр бас байгуулагдаад ингээд ажиллаж байгаа. Өмнө бас стандартын төслийг боловсруулаад ажлын хэсгийн түвшинд хэлэлцээд ингээд хийгдсэн байгаа. Цаашид энийг өшөө олон улсын жишиг рүү нь хүргэж илүү шинэчилж, сайжруулах ажлууд үе шаттай ингээд хийгдсэний дараа батлуулах ийм зорилттой ажиллаж байна аа. Түүнээс гадна импортоор орж ирж байгаа барилгын материалууд дээр бид нар тавих хяналтыг ч сайжруулж байгаа. Энэ ажлын хүрээнд бол Замын-Үүд дээр сая хяналт тавих лаборатори маань баригдаж дуусаж ашиглалтад орсон.

Алтанбулаг хилийн боомт дээр бас ийм лаборатори байгуулах ажил хийгдээд явж байна аа. Ингэснээрээ импортоор орж ирж байгаа барилгын материалуудын чанарыг сайжруулах ажил нөхцөл түвшин илүү сайжирна гэж ингэж тооцож байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дотор орчны агаарын чанарын асуудал дээр анхаараарай гэдэг саналыг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Улаанбаатар хот 2040 дээр нэг зүйлийг бас онцгойлон бас давхар тооцож хэрхэн тооцож байгаа вэ гэдэг дээр бас би бас асуулт авмаар байна. Энэ аюулгүй байдлын төлөвлөлт гэдэг зүйлийг хэрхэн хийж байгаа вэ? Би яах вэ энд юун дээр харж байна? Галын аюулгүй байдал, үер усны далан сувагчлал энэ тэр гээд. Газар хөдлөлт гэдэг юм уу нийтийг хамарсан томоохон гал мөн ийм гамшгийн үеэр хэрхэн яаж хамгаалалт хийх ийм төлөвлөгөө хийх вэ? Зөвхөн онцгой байдал гэдэг байдлаар төрийн байгууллагууд гэдэг байдлаасаа төлөвлөх юм бол энэ хэзээ ч дийлэхгүй эрсдэл их өндөр ирдэг.

Тийм учраас энэ тал дээр бол тухайлан барилга орц, гарц мөн иргэдийн оролцоотой байдал гээд. Манай Лувсанжамц гишүүний бас яриад байгаа хотыг төлөвлөхөд дарга дээрээс зөвшөөрдөг байдлаар биш иргэд нь өөрсдөө эхлээд тэр ерөнхий төлөвлөлтдөө хамааруулаад өөрсдөө энд ийм байшин баримаар байна энд нь ийм зам талбай төлөвлөмөөр байна гэдгийг хамгийн сайн өөрсдөө амьдрах учраас тэд нар хамгийн их оролцоотой байх ийм концепцтой гэж би ойлгож байгаа.

Тийм учраас энэ тал дээр хэрхэн яаж төлөвлөж байгаа вэ? Би бол энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны аюулгүй байдал болзошгүй гамшгийн үед энэ хот маань өөрөө хэрхэн бэлэн байдалтай байх вэ гэдэг энэ тал дээр бас энэ хуулийн ажлын хэсэг хэрвээ гарвал энд нэлээн бас идэвхтэй оролцож ажиллах ийм хүсэлтэй байна.

Хоёрдугаарх нэг асуудал нь сая тэр аюулгүй байдалтай холбоотой байхад АНУ-ын Калифорни муж ингээд сая шатлаа. Бараг тэр хот тэр чигээрээ шатлаа л даа. Тэгсэн тэнд гол бас энэ галыг их тархахад гол хүчин нэг зүйл үзүүлсэн нь юу вэ гэхээр хоёрхон сарын өмнө хот хөдөлмөрийн аюулгүй байдлынхаа төсвийг 20 сая доллароор таначихсан юм байна. Нөгөө өндөр өндөр дал моднууд чийгшүүлдэг байсан тэр зардлыг нь үр ашиггүй гаргаж байна гэдэг байдлаар танаад хаячихсан тэгээд тэр нь гайтай юм шиг гал түймрийн үеэр хамгийн их дамжуулах ийм аюул болсон. Тийм учир түүнээс энэ бусад улс орнуудын гарч байгаа гамшгуудаас бас нэлээн сургамж авах энэ тал дээр бид нар давхар тооцож үзэх шаардлагатай юм байна лээ. Манай гэр хорооллуудаар гал гаргахад хамгийн их эрсдэлтэй бүс нь аль вэ? Энд хамгийн тэр иргэдийн оролцоотой юуг яаж хамгаалах вэ гэдэг байдлаар.

Хоёрдугаар асуудал нь нөгөө газ дэлбэрсэн нэг байшин дэлбэрсэн. Тэгээд газ дэлбэрэх томоохон ийм осол гарах болгон дээр нөгөө хотоо буруутгаад хэн нэгэн даргыг барьж авч дүүжлэх гээд байдаг. Нэг ийм л концепцоор явах гээд байдаг л даа. Тэгэхээр бидний хувьд яг ингэмээргүй байгаа. ААН байгууллагууд өөрсдөө тэр аюултай ачаа бараа тээж байгаа бол энийг хаагуур яаж тээх юм? Хэдийд тээх юм? Тэр үеийг нь ямар стандартыг нь барьж явах юм гэдэг дээр хяналт шалгалтын юмыг давхар тавьж байхгүй бол одоо энд тэнд нэг барилга кран нурсан, газ дэлбэрсэн болгон дээр аваачаад энэ хот төлөвлөсөн нөхдүүдийн буруу гээд л бид нар чинь энэ хэн нэгэн хүнийг барьж явж л нийтээрээ дүүжлэх гээд байдаг л асуудал байдаг л даа.

Тийм учраас энэ тал дээр давхар энэ төлөвлөлт дээр.

Х.Булгантуяа: Эрдэнэбат гишүүний микрофоныг нэг минутаар сунгая.

С.Эрдэнэбат: Дээрээс нь бас нэг зүгээр асуултын шинж чанартай энэ зуслангийн газрууд гээд бараг талаас илүү нь айлууд дээр нь зусланг нь өмчлүүлээгүй, эзэмшүүлээгүй гэсэн байх аа. Энийг ер нь хэзээгээр хийх юм ер нь эзэмшүүлэх юм уу, үгүй юм уу гэдэг ийм бас асуулт байна. Тэр Тендерийн хууль бас маш чухал байгаа. Одоо манай Их Хурлаас тендерийн хуулийн ажлын хэсэг гараад ахалсан гишүүнээсээ авхуулаад ерөөсөө ажиллаагүй, яагаад ажиллахгүй байгааг нь би бас гайхаад байгаа юм. Энэ Тендерийн хуулийг нэг тийш нь болгохгүй бол энэ тендерийн хуулийг чинь будилаантуулдаг тэндээс дундаас нь ашиг хайдаг гацаадаг, нөгөө талаар хамгийн бага үнийн арга гэдэг байдлаар хамгийн чанаргүй бөгөөд тийм нөхдүүд л юмаа шахах гэж оролддог. Нэг ийм асуудлууд байгаа юм.

Тийм учраас энийг бол тендерийн хуульд тэр цаг хугацааны орон зайн эдийн засгийн дам болон шууд нөлөөллүүдийг нь давхар тооцсон ийм байдлаараа бас нэг аятайхан тавихгүй энэ олон төсөл хөтөлбөрүүд чинь урагшаа явахад хэцүү. Тэгээд эцсийн байдал дээр шүүх дээр ирдэг шүүх бараг эцсийн байдлаар хайныг нь хагалж анх төлөвлөсөн, хүссэн хэмжээнээс нь шал эсрэг хүртэл байлгадаг. Тэрний нэг нь нөгөө тэр авлигал хороолол гээд байгаа шүү дээ тэ? Одоо ингээд.

Х.Булгантуяа: Хотын дарга.

Х.Нямбаатар: Би эхнийх нь асуултаас хариулъя. Энэ нөгөө галаас авран хамгаалах менежментийн талаар 2040 он хүртэл өргөжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд маш тодорхой хэдэн зүйлийг тусгасан. Тухайлах юм бол MNS 64122013 стандартад нийцүүлээд 20 минутын хот концепцтой уялдуулан 3 км-ийн радиус тутам нэг гал

унтраах ангийг байгуулна гэдэг ийм төлөвлөлтийг орж байгаа. Дээр нь манайд нэг хамгийн том асуудал байгаа. Сая Лос Анжелес чинь гидрантын систем байсан. Гидрантын систем нь өөрөө усгүй байсан нь асуудал үүсгэсэн. Тэр магадгүй нөгөө хөрөнгө мөнгө хэмнэсэнтэй холбоотой. Гэтэл манайд гидрантын систем энэ төв суурин газруудад тавигдаагүй байгаа. Өөрөөр хэлбэл бид нар цаашид энэ 2040-ийнхөө хүрээнд 150 метрийн зайд өндөр барилгуудын ойролцоо ийм байнгын устай гидрантын системийг бий болгох ийм төлөвлөгөө тавьж байгаа. Мэдээж хэрэг энэ нэлээн их тийм том хөрөнгө мөнгө орно гэж бодож байгаа.

Хоёрдугаарт урьдчилан сэргийлэх авран хамгаалах энэ гарцуудыг бий болгох, Улаанбаатар хотоос гарах, одоо энэ гал түймрийн аюул, гамшиг ослын үед гарах гарцуудыг нэмэгдүүлэхээр байгаа. Одоо бид нар Улаанбаатараас гарах ерөөсөө хэдхэн гарцтай шүү дээ. Зүүн, баруун тийшээгээ 1, 1 гарц байна. Урагшаа хойшоогоо 2 гарц байна. Өөр юу ч байхгүй. Тэгэхээр энэ гарцуудыг нэмэгдүүлэх чиглэлээр 2040 дээр бас тодорхой төлөвлөлтүүдийг оруулж ирж байгаа.

Дээр нь урьдчилан сэргийлэх зарлан мэдээлэх энэ тогтолцоо болзошгүй газар хөдлөлт, үер ус, гал түймэр, өвчин тахлын үе, үйлдвэрлэлийн ослын үед олон нийтэд зарлан мэдээлэх энэ цамхаг нэгжүүдийг нэмж байгуулах, цаашлаад сүлжээ станцуудыг байгуулснаар газар хөдлөлтийн чичирхийллийг шууд үнэлэх энэ тухай шуурхай дамжуулах ийм тогтолцоонуудыг бий болгох менежментийг бий болгохоор орж ирж байгаа.

Дараагийнх нь энэ зуслангийн газартай холбоотой. Зуслангийн газрыг ерөөсөө өмчлүүлэх шийдвэр одоогоор гараагүй байгаа. Дандаа эзэмших ашиглах эрхийн хүрээнд зуслангийн газрыг эзэмшиж ашиглаж байгаа. Тэгэхээр цаашид энэ зуслангийн райоона Шарга морьт хот гээд дагуул хот байгуулахаар төлөвлөсөн. Энэ хүрээндээ газрын менежментийг тодорхой болгож оруулж ирэх ер нь ойн сан бүхий газрыг өмчлүүлэх асуудал бол Үндсэн хуульд хориглолттой байдаг учраас энэ эзэмших ашиглах менежментийнхээ хүрээнд явах байх гэж бодож байна. аюултай ачаа тээвэрлэх зам өнөөдөр Улаанбаатар хотод байхгүй. Монгол Улсад бүх бууж байгаа тэсэрч дэлбэрэх бодисууд Улаанбаатар хотод бууж байгаа юм. Улаанбаатар хот тэсэрч дэлбэрэх бодисын нэг ч хэрэглээгүй хэрнээ уул уурхайн компаниуд руу явах тэсэрч дэлбэрэх бодис бүгд Улаанбаатарт бууж байгаа юм.

Тэгэхээр цаашид бид нар энэ аюултай ачааг буулгах, тээвэрлэх, аюултай ачааг тээвэрлэх, хотын гадуурх замын хүртэл төлөвлөлтийг энэ 2040 дээр оруулж ирсэн гэдгийг товчхондоо хэлье.

Х.Булгантуяа: Нямбаа дарга өмнө нь гишүүн сайд байхдаа та яг минутдаа багтаагаад хариулчихдаг байсан чинь бүүр 3 минут дээрээс нь нэмээд нэг минуудыг нэлээн олноор нэмж өгөөд байгаа юм. Нийт нөгөө Улсын Их Хурлын гишүүдийн асуулт асуух гишүүдийг бид нар багтаахын тулд цагтаа та бүгдийг бас хариулахыг хүсэж байна аа.

Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асуухаар байгаа байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе ээ. 6 сараас хойш хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөн дээр та хэдтэйгээ бас 7 хоног бүр уулзаж энэ төлөвлөгөөг нийгмийн гэрээ болгож хэрэгждэг төлөвлөгөө болгохын тулд, ялангуяа бодлого,

тогтолцооны асуудлуудыг зөв болгохын тулд 20 минутын хот буюу хүндээ ээлтэй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, ногоон байгууламж нь хангалттай байдаг. Ийм болгох тал дээр нь маш олон удаа уулзаж, санал солилцож, хамтарч ажилласан. Хотын дарга Нямбаатар, Ерөнхий архитектур Төгсдэлгэр, Ажлын албаны дарга Баттөмөр, Хот төлөвлөлт судалгааны институтын дарга Амартүвшин мөн Тэлмэн зэрэгтэй хамтарч ажилласан багийн бүх гишүүдэд баярлалаа.

2 санал, 2 асуулт байна. Сая олон гишүүд Ерөнхий сайдаас асуусан болохлоор товчилъё. Үнэхээр бид нар ингээд 14 мега төсөл хотын хэмжээнд 24 төслүүдийг хэрэгжүүлээд утаа, түгжрэлийг шийднэ гэсэн. Ийм төслүүдийг хэрэгжүүлэх гэхээр манай энэ Тендерийн тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль дээрээс нь нэмээд гаднын чадварлаг инженерүүдийг авчраад үндэсний архитектор инженерүүд хамтарч ажиллаад энэ том бүтээн байгуулалтыг хамтад нь хийе гэхээр хуулийн төсөл өргөн бариад орохоор тэрнийг нь эсэргүүцээд дарамтлаад Улсын Их Хурлын гишүүдэд шахалт үзүүлээд хуулийн төслийг нь буцааж татуулах хүртэл тийм арга хэмжээ аваад байгаа.

Энэ дээрээ Улсын Их Хурал ч гэсэн Засгийн газар нийслэл бүгдээрээ хамтдаа байгаад нэг чигт бүтээн байгуулалтын төлөө, нийгмийн, хотын асуудлуудыг шийдэхийн төлөө хамтарч ажиллах хэрэгтэй байгаад байгаа. Хууль эрх зүйн хүрээнд ч гэсэн засах ажлыг нь манай Улсын Их Хурлын гишүүд манлайлал үзүүлээд засаж залруулаад явах ёстой болов уу гэж бодож байна.

Хоёр асуулт байна. Хот бол хамтын бүтээлээ. Зөвхөн даргын гарын үсгээр шийдэгддэг тийм зүйл байхгүй. Нийгмийн гэрээ байх ёстой. Олон нийт оршин суугчид ААН-ийн оролцоо маш их чухал. Энэ асуултыг Ерөнхий архитектор Төгсдэлгэрээс асууя.

Өнөөдрийг хүртэл хэдэн санал асуулга аваад энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хэдэн санал нь тусаад байгаа вэ? Цаашдаа хаврын чуулган хүртэл хэдий хугацаанд иргэд оршин суугчдын саналыг авах вэ?

Хоёрдугаар асуулт ерөнхий төлөвлөгөө гэдэг бол бодлогын баримт бичиг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрэгтэй. Бид нар 14 хот дээрээ үүнийг зохиох ёстой. Төлөвлөгөө байна гэдэг нь даргын гарын үсэг даргын зөвшөөрлөөс салах ёстой зүйл байгаад байгаа. Өнөөдөр Улаанбаатар хот ийм чигжчихсэн, түгжрэлтэй, утаатай болчихсон байгаа нь бол үе үеийн ерөнхий архитектурууд газрын албаны дарга нар төлөвлөгөөгүйгээр газар олгож зам ч барих зайгүй болгож хаясан ийм асуудал байгаад байгаа. Төлөвлөгөө тод байгаа цагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ тодорхой, даргаас хамааралгүйгээр асуудлууд шийдэгдээд явдаг. Одоо барилгын зөвшөөрөл газрын зөвшөөрөл энэ бүх зүйлүүдийг нэгтгээд нэгдсэн төлөвлөлтийн тогтолцоонд шилжих ёстой байгаад байгаа. Та залуу хүн олон улсад ажиллаж байсан бас туршлагатай хүн. Энэ дээр ямар тогтолцоог барьж энэ ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх вэ гэсэн 2 дахь асуулт байна.

Гурав дахь нь болохлоор Их Хурлын даргад санал байгаад байгаа юм. Өнөөдөр байхгүй болохоор дэд даргадаа бас саналаа хэлье. Хот байгуулалт хот төлөвлөлт бол эдийн засгийн буюу ажлын байрыг нэмэгдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх тийм бодлого байдаг. Зөвхөн энэ барилга, хот байгуулалтын асуудал биш өргөн хүрээгээрээ энэ эдийн засгийн бодлого байдаг. Хөгжлийн ерөнхий

төлөвлөгөөг одоо зөвхөн Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хэлэлцэхээр орчихсон байгаа. Үүнийг Эдийн засгийн байнгын хороо дээр хэлэлцэж өгөөч ээ гэсэн асуудлыг Байнгын хорооны дарга болон Их хурлын дарга Амарбаясгаланд саналаа хүргүүлсэн.

Хоёрдугаарт нь би мэргэжлийн хүний хувьд Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын хэсгийг ахалж ажиллах хүсэлтэй байна. Мэргэжлийн бөгөөд хариуцлагатай, олон нийтийн оролцоотой, иргэндээ ээлтэй байх байдлаар дутуу зүйлүүдийг нь засаж авах хариуцлагатай ажлыг хиймээр байна аа.

Х.Булгантуяа: Лувсанжамц гишүүний хувьд яах вэ энэ бол эрх зүйн орчноороо Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Төрийн байгуулалтын байнгын хороогоор угаасаа энэ хууль орох ёстой. Ажлын хэсгийг аль болохоор тухайн Байнгын хорооны гишүүн нь ахлах нь зөв зүйтэй. Тэгж байж мэргэжлийн Байнгын хороод энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс тухайн Байнгын хороонд нь харьяалагдаж ажиллаж байгаа.

Танд Төрийн байгуулалтын байнгын хороонд орох уу гэдэг саналыг тавьсан шүү дээ. Төрийн байгуулалтын байнгын хороонд орох уу? Энэ том ажлын хэсгийг та ахлах уу гэдэг саналыг тавьсан. Тэгээд харамсалтай нь Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ өөрөө орох хүсэлгүй Төрийн байгуулалтын байнгын хороонд байгаа хотоос сонгогдсон байдаг юм уу энэ эрх зүйн орчноор бас илүү мэргэшсэн Улсын Их Хурлын бусад гишүүд маань энэ ажлын хэсэгтээ ороод бас ажиллаад явахад бас асуудал байхгүй ээ.

Зарим хуулийн ажлын хэсгүүдийг өргөн барьсан хуулиудын ажлын хэсгийг 2, 3 Байнгын хороо хамтарсан байдлаар бас хэлэлцүүлэх хэрэгцээ шаардлага байдаг. Улаанбаатар хотын асуудал бол яг үнэнийг хэлэхэд энэ том хууль ингээд харахад ганцхан Төрийн байгуулалтын байнгын хороо ч биш энэ эрх зүйн асуудал ч биш өөрийн чинь хэлж байгаа үнэн. Эдийн засгийн асуудал Нийгмийн бодлогын байнгын хороотой холбоотой гэх юм бол нийгмийн бодлого боловсрол гээд олон зүйлд нөгөө байнга бусад Байнгын хороод руу ч гэсэндээ хальж орохоор байгаа нь үнэн. Тэгээд ямар ч байсан эхний шатанд бид нар хэлэлцэх эсэхээ шийдээд тэгээд ажлын хэсэг гарч ажиллаж таарна аа.

Хамгийн эхний асуултад ажлын хэсгээс 19 номерын микрофон хариулъя.

Ч.Төгсдэлгэр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийслэлийн ерөнхий архитектор Төгсдэлгэр байна. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Эхний асуулт нь олон нийтийн санал асуулгын талаарх асуулт байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ удаагийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө гэвэл урьд өмнө нь хийгдэж байсан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнөөс хамгийн онцлог нь үнэхээр нийтийн олон нийтийн санал асуулгыг маш ихээр тусгасан байгаа гэж харж байна. Нийт 48 мянган иргэдийг 2 шатлалтайгаар 48 мянган иргэдийн саналыг хүлээн авсан байгаа. Тэгээд санал бол цаасаар болон цахимаар хэлбэрээр тус тус авч төлөвлөлтийн шийдэлд харгалзан үзсэн байна аа.

Тэгэхээр энэ төлөвлөлтийн саналуудаа бас онцгой олоод хэлэхэд 12 мянган санал нь ерөөсөө л энэ нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургууль цэцэрлэг, эмнэлгийн хүртээмж, ногоон байгууламжийн хүртээмжийн талаарх саналууд голчлон ирсэн байгаа. Тэгэхээр бидний яг энэ яриад байгаа 20 минутын

хот хүртээмжтэй хот байх энэ санал голчлон ирсэн. Тэгэхээр саналаас нийт 50, 60 хувь нь бол төлөвлөлтийн шийдэлтэй давхацсан. Бид бол нэг 30 хувийн төлөлтүүд бол шинээр тусгасан байгаа.

Тэгэхээр санал ирүүлсэн. Энэ дашрамд дурдаад санал ирүүлсэн бүх хүмүүстээ, иргэддээ бас баярлалаа. Та бүхэн Улаанбаатар 2040 фэйсбүүк хуудас болон веб сайтаар ороод санал өгөх эрх нээлттэй байгаа шүү. Та бүхэн дуусаад энэ тавьсан байгаа танилцуулга бол QR кодоор уншуулаад иргэн бүрд нээлттэйгээр бид тавьсан байгаа. Тэгээд 2 дахь асуулт нь болохоороо хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөө төлөвлөлтийн талаарх асуулт зөвшөөрлийн талаарх асуулт гэж ойлгож байна. Уул нь олон улсад нэг хүн эсвэл гарын үсгээр барилгын зөвшөөрөл олгодог систем гэж байдаггүй ээ. Зөвшөөрлийг гарын үсгээр олгохоор л энэ өөрөө ерөөсөө хуучны тогтолцоо. Тэгээд ер нь манайхан гарын үсэг зурах дуртай. Тэгээд тэрүүгээрээ зөвшөөрөл өгч байна гэж төр хардаг юм байна лээ. Тэгэхээр энэ ерөнхий төлөвлөгөө хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөөний дагуу л зөвшөөрөл төлөвлөгөөний дагуу л барилгын зөвшөөрөл олгогдоод явж байх ёстой.

Тийм учраас л энэ төлөвлөгөө хийх асар чухал болж байгаа юм. Тэгээд ерөнхий төлөвлөгөө баталсны дараа хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөө хийгдэнэ ээ гэж олон удаа бас хэллээ. Тэгэхээр яг үүний дагуу бид хийх юм бол олгоод байдаг А даалгавар гэдэг зүйл маань өөрөө хэрэггүй байх. Тэгээд бас гол нэг зүйл нь болохоороо олон төлөвлөлттэй байгаад ирэхээрээ аль төлөвлөлтөө бариад явах нь тодорхойгүй. Ер нь нэг амбицтай л салбар нь ч юм уу салбарын мастер төлөвлөгөө гээд л гаргаад явчихдаг. Олон төлөвлөлттэй байгаад байгаа учраас өнөөдөр энэ хотын асуудал бас үүсэж байгаа гэж харж байна.

Тэгэхээр ерөнхийдөө бид хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө магадалгаа төлөвлөгөө буюу ерөөсөө л нэгдсэн 1 төлөвлөгөө яг энэ цорын ганц төлөвлөгөө байх юм. Үүн дээр үндэслээд хэрэгжүүлэх үе шатын хэмжээ үйл ажиллагааг төлөвлөгөөгөөр тусгаад явна гэсэн ийм л зарчимтайгаар ажиллах мэргэжлийн зарчимтай зөв ажиллана гээд амлая. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Нийслэл Улаанбаатар хотод хуралдсан олон асуудлыг шийдэх зорилготой энэ хөгжлийн ерөнхий их төлөвлөгөөг баталж байгааг бүхэлд нь дэмжиж байгаа. Тэгээд нийслэл маань Монгол Улс доторх нэг том улс бас болчихсон байж байгаа. Хүн ам нь 1.7 саяд хүрсэн байна. Төсөв нь 3.8 их наяд хүрчээ. Тэгээд бид нар бас бодит байдлаа л их сайн эгцэлж харж байх ёстой. Тэгээд ингээд олон барилгатай шилэн өндөр барилгатай болсон. Тэгээд энэ хөгжсөн үү гэвэл хөгжөөгүй ээ. Бид нар иргэндээ ээлгүй, иргэдээ бухимдуулсан ийм өндөр өртөгтэй хот болчихсон. Энийгээ их хүлээн зөвшөөрч эгцэлж харах ёстой. Тэгээд түгжрэл утаа бүх л хүмүүс ярьж байна. Боловсрол эрүүл мэндийн үйлчилгээний асуудал туйлдаа хүртэл доод хэмжээнд ингээд оччихсон байна.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний талаар маш их сонслоо. Гишүүдийн асуултад ажлын хэсгийн хариулж байгааг бас сонслоо. Тэгээд нийслэл маань сүүлийн үед бас 12 мега төсөл гаргая энэ нь тэр түгжрэлтэй тэмцэх, утаатай тэмцэх, бусад гээд ингээд ангилаад бичсэн байсан. Тэгээд ер нь үзэл баримтлалынхаа

хувьд ерөнхий төлөвлөгөөнд хүн төвтэй хүний хөгжлийг дэмжсэн хотыг зорино гэж тавьсан байгаа. Тэгэхээр боловсрол маань өөрөө тэргүүлэх салбар байдаг. Боловсрол маань л хүний хөгжлийг хангадаг ийм байгаа.

Тэгэхээр гишүүдийн асуулттай нэлээн давхацсан учраас би асуултаа бас товчлоод 3 асуулт асууя гэж ингэж бодож байна. Тэгээд хүний хөгжил ерөөсөө л боловсролын чанараас хамаардаг. Нийслэлчүүдийн маань гол хүсэл мөрөөдөл чанартай боловсрол, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах байгаа. Тэгэхээр энэ талаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ямар ямар гол ажлуудыг тусгасан бэ? Одоо жишээлбэл боловсролын талаар 3 брэнд гэж нэрлэх юм уу та бүхэн бүүр хамгийн эхэнд хийх ёстой ажил гэсэн ийм 3 ажил ямар ажлыг төлөвлөсөн байгаа вэ? Энийгээ нэг нэрлэж өгөөч ээ гэдгийг нэгдүгээрт хүсэж байна.

Хоёрдугаарт боловсрол Улаанбаатар хотод чанартай боловсрол олгох нөхцөл бүрдсэн байгаа юу? Манай Нямбаатар дарга энийг юу гэж хардаг вэ? Өнөөдөр бүлэг дүүргэлт нэг сургуульд байх хүүхдийн тоо хэрээс хэтэрсэн байгаа. 40 хүүхэдтэй нормоороо 30 хүүхэдтэй байх ёстой газар 40 болон түүнээс дээш 60-аас дээш хүүхэдтэй анги байна. Би энийг байнга л ярьдаг. Үг хэлэх тоолондоо 1400 хүүхэдтэй сургуулийн хэмжээ нийт нэг сургуульд байх хүүхдийн тоог нормчилсон байдаг бол 1800, 2000, 3000, 4000, 6000 ч гарсан хүүхэдтэй ийм сургуулиуд ингээд байж байна. Тэгэхээр энд бол ингээд эрх ашиг нь зөрчигдөж байгаа гэж үзэж байгаа. Энд ямар явдал болдгийг судлаачийн хувиар олон газар бичиж тавьж байгаа. Тэгээд та бүхнээсээ энэ 152 мянган хүүхэд байгаад байгаа. Энэ ийм эрх нь зөрчигдөөд явж байгаа. Саяын энд 30 биш 40-өөр тооцсон. 1400 биш 1800-гаар тооцсон сургуульд сурч байгаа 152 мянган хүүхэд сурч байна. Тэгэхээр энийг арилгахын тулд дорвитой, далайцтай арга хэмжээ авах ёстой. Нийтдээ 14 хот, 42 төв байгуулна гэж байгаа бол энд нийтдээ хэчнээн сургууль, цэцэрлэг барихаар төлөвлөсөн бэ гэдгийг бас асууя.

Тэгээд та бүхэн нэг зүйл харж байгаа байх. Сурагчдын амралт эхлэхээр энэ түгжрэл маань ингээд алга болчхож байна шүү дээ. Тэгэхээр амраагаад бай гэсэн үг биш. Энэ юунаас ингэж байна гэвэл гэрийнх нь ойр сургууль байвал энэ бас л адилхан. Амарсан амраагүй ялгаа байхгүй. Тэгэхээр гэрийн ойр сургуулиудыг чанартай байлгах тухай ярьж байна. Үүний тулд чанараасаа илүү тэр гэрийн ойр нь сургууль байх нь л чухал байгаад байна. Тэгвэл орон сууцын хороолол шинээр барих тохиолдолд заавал сургууль төлөвлөх тийм норм стандарт журам байдаг.

Тэгээд шинэ архитекторчоос асууя. Сүүлийн үед эскиз батлах архитектур төлөвлөлтийн даалгавар батлах үедээ ийм сургууль байгуулах шаардлагыг хэдэн ийм зураг.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүний асуултад ажлын хэсгээс хотын дарга хариулах уу? Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Тэгэхээр бид нар чанартай боловсрол олгох боломж бол одоогоор бүрдээгүй байгаа. Яагаад гэвэл 1 дүгээрт тухайн анги дүүргэлтийн норм норматив хэтэрчихсэн явж байгаа. Дээр нь тухайн хороололдоо өөрийн гэсэн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг бүрэн бий болгож чадаагүй байгаа. Тэгэхээр 2040 дээр юу гэж тусгасан бэ гэвэл цэцэрлэгийн хүртээмжийг яг Улаанбаатар хотын түвшинд 349 ширхэг цэцэрлэг нэмж барьж байгуулж байж одоогийн хүүхдүүдийг СӨБ-ыг олгох боломж бүрдэнэ ээ. Дагуул хотуудын түвшинд 152 цэцэрлэг барьж

байгуулах шаардлага байна гэдэг ийм төлөвлөлтийг оруулж ирсэн. 2040 дээр одоо байгаа сургуулиуд дээр нэмээд Улаанбаатар хотод 51 ширхэг сургууль, дагуул хотод 72 ширхэг сургууль буюу нийтдээ 123 сургуулийг одоогийнхоо 2040-ийн хэмжээнд нэмэгдүүлж байж бид нар 1 дүгээрт нөгөө таны хэлж байгаачлан анги дүүргэлтийг 30 хүүхэд гэдэг тэр тоонд барина гэдэг ийм төлөвлөлтийг оруулж ирсэн. Энэнээс цааших би нөгөө өөрөө сурганы хүн биш учраас боловсролын нарийн мэдлэг мэдээллүүд алга байна.

Зүгээр миний нэг би сая Галаа багштай бас уулзахдаа ч ярьж байсан. Одоо шинээр энэ байгуулагдаж байгаа бүх хотхонууд дотроо бид нар гэр хорооллыг орон сууцжуулах энэ Сэлбээсээ эхлээд холимог орон сууцын хороолол хийе ээ. Өөрөөр хэлбэл орлогын түвшнээрээ өөр өөр ялгамжтай хүмүүсийг нэг дор амьдруулъя. Ингэхийн тулд тэр хүмүүсийг татах гол таталцал нь юу байх вэ гэхээр нөгөө чанартай тэгээд хөтөлбөртэй сургуулиудыг байгуулъя гээд. Тэгээд бид эхний ээлжид энэ газарчин хотхон дотор нэг Сингапурын 2 мянган долларын хөтөлбөртэй сургууль байна. Тэгээд бид нар бас энэ сургуулийнх нь ТУЗ-ийн удирдлагуудыг энэ сарын 29-ний өдөр хүлээж авъя гэж байгаа юм. Тэгэхээр яагаад ийм хөтөлбөртэй сургуулиудыг бид нар Сэлбэ болон энэ бусад гэр хорооллыг орон сууцжуулж байгаа Баянхошуу, Шар хадны төслүүд дээр оруулж ирж болохгүй гэж. Өөрөөр хэлбэл хүн хүүхдийнхээ боловсролын төлөө ийм хөтөлбөртэй тэгээд төлбөр нь ээж аав нь төлж болохуйц ийм хөтөлбөртэй сургуулиудыг танай бас франчайзингтай сургуулиудыг бас бид нар оруулж ирэх ийм замаар холимог орон сууцын хорооллуудыг дэмжих хөтөлбөртэй болон ердийн сургуулиудыг хольж байгуулах ийм төлөвлөлтийг хийж явж байгаа гэдгийг хэлье.

Ерөнхий архитектор Галбадрах багшийн асуултад хариулъя аа.

Х.Булгантуяа: Яг нарийн бүүр хэдэн сургууль цэцэрлэг гэж асуусан тиймээ. Галбадрах гишүүн. Тэгсэн Ерөнхий архитектор нэмж хариулъя. 19 номерын микрофон.

Ч.Төгсдэлгэр: Галбадрах гишүүний асуултад хариулъя аа.

Нийслэлийн ерөнхий доктор Төгсдэлгэр. Одоо Монгол Улсад мөрдөгдөж байгаа норм дүрмээр 1 мянган хүнд 200 хүүхдийн сургууль байх ёстой гэсэн энэ норм дүрэм байгаа. Мөн таталцлын хүртээмжийн байдлаар бид бас сургуулийг төлөвлөж байгаа. Тэгэхээр жишээлбэл энэ Сэлбэ дэд хот дэд төвд бид яг энэ норм дүрмээ бариад сургууль цэцэрлэгийг төлөвлөж байна аа. Тэгээд ажил авснаасаа хойш 5 сарын хугацаанд бол нийт 19 хотхоны зураг төсөл батлагдсанаас 19-үүлээ сургууль, цэцэрлэгтэйгээр батлагдсан байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Галбадрах гишүүн нэмж тодруулъя.

Ж.Галбадрах: Баярлалаа. 19 хотхоныг батлахдаа бүгдэд нь сургууль, цэцэрлэгийг бас төлөвлөж чадсан гэдэг бас сайн эхлэл байна гэж харж байна. Бид ерөөсөө л энэ одоо баригдчихсан байгаад байгаа хотхонууд байна шүү дээ. Сургууль цэцэрлэгтээ зайлшгүй байх ёстой байтал ингээд ерөөсөө огт бариагүй ингээд яачихсан. Тэгээд энэ сургуулиуд ийм хороололд яаж шийдэх вэ гэдгийг бас асууя.

Дээрээс нь би тэр 14 дүгээр сургууль Офицеруудын ордонд байдаг. Тэгээд зах Нарантуул захаас замын урд тал Энхтайваны өргөн чөлөөнөөс урагшаа байж байгаа ганц сургууль нь тэдний сургууль байна. 6 мянган хүүхэдтэй. Хажууд нь тэр офицер хотхон гээд барьж байна. Баянзүрх хотхон гээд барьж байна. Ахиад тэр хүмүүс бол бид нар хажуудаа улсын тэргүүний 14 дүгээр сургуультай гээд маркетингаа хийгээд барьж байгаа юм. Нөгөө сургууль нь 6 мянга хэтэрчихсэн хэчнээн хүүхэд авах боломжгүй гэж байгаа. Ийм байдлыг яаж зогсоох вэ гэдэг талаар асууя.

Х.Булгантуяа: Хотын дарга Нямбаатар хариулъя.

Х.Нямбаатар: Бид нар бол энийг нөгөө нэг их барилгажилтын золиос болсон хотхонууд гэж үзэж байгаа юм. Тухайлах юм бол энэ 10 дугаар хорооллын урд талын ямар нэртэй билээ? Голден Парк гэдэг хотхон энд очиж бид нар 2 газар газар чөлөөлөлт хийж сургууль, цэцэрлэгийг шинээр тухайн сул орон зай дээр нь дахиж төлөвлөж байна. Өнгөрсөн жил бид нар Эрин хорооллын эрин хувийн сургуулийг худалдаж авах хэлэлцээр хийгээд ингээд улсын сургууль болоод Эрин сургууль маань улсын сургууль болоод явж байгаа. Бид нар юун дээр нөгөө Хүннү 22-ын баруун талд Номин компаниас газрыг нь аваад 960 хүүхдийн сургуулийг бас эхлүүлээд явж байна. Мөн одоо юуны маршал тауны урд талын, Кинг тауверын урд талын газраас бид нар 8 мянган м² газрын.

Х.Булгантуяа: Нямбаатар даргын микрофоныг өгье. Яг манай Баянзүрхийг ярих гэж байх шиг байна.

Х.Нямбаатар: Тийм бид нар ер нь ингээд бүх жишээлбэл БЗД-ийн 36, 26 дээр ерөөсөө улсын сургууль цэцэрлэг төлөвлөгдөөгүй байсан. Одоогийн байдлаар бид нар 36, 26 дээр 2 сургууль, 3 цэцэрлэг нөхөж ингээд тэр барилгажаагүй байгаа хэсгүүдийг нь айл газар эзэмшигчдээс нь авах байдлаар нөхөж барилгажуулах ажлыг нийслэлээс зохион байгуулаад явж байгаа. Би энэ мэтчилний тоо хэлэх юм бол тэр нөгөө барилгажилтын золиос болсон орон сууцын тэр хорооллууд дотор заавал нөхөж бид нар улсын сургууль, цэцэрлэг барих ажлуудыг бүхэлд нь хийж гүйцээж байгаа гэдгийг хэлье. Нэгэнт ингээд баригдчих юм бол одоо та бид бүхэн харж байгаа. ЕБС амарчихсан үед хотын түгжрэл ямар байгаа вэ. Сургууль ирэх 7 хоноогоос эхлэхээр хөдөлгөөний эрчим яаж нэмэгдэх вэ гэдэг бол ерөөсөө бид нар 20 минутынхаа тэр зайд л сургууль, цэцэрлэгийг заавал нөхөж хийх ёстой. Энэний дараа чанартай боловсролын хөтөлбөр рүү орох ёстой л гээд.

Б.Пүрэвдорж: Гишүүд ажлын хэсгийнхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Булгантуяа гишүүн асуулт асууна аа.

Х.Булгантуяа: Хотын 2040 хүртэлх хөгжлийн төлөвлөгөөг дэмжиж байгаа. Нийслэл Улаанбаатар хотоос бас өмнө нь ийм төлөвлөгөө оруулж ирээд Улсын Их Хуралд нэг төгс төгөлдөр зүйл хийх гэж байгаад хойшлуулчихсан. Бид урагшаагаа алхахаас өөр арга байхгүй. Одоо дараа дараагийн олон хотуудыг ярьж байгаа яг энэ цаг үед эхлээд байгаа нийслэл Улаанбаатар хотынхоо сайжруулах асуудлыг яг зэрэг яриад явах ёстой. Бүр хотын асуудал бол Нямбаатар даргын асуудлаас халиад Үндэсний аюулгүй байдлын том асуудал болчихсон. Тэгэхээр Улсын Их Хурал дээр өнөөдөр бас энийг ингээд нээлттэй сайн ярьж байгаа нь зөв гэж бодож байна. Нэг хэд хэдэн зүйл дээр та бүгдийнхээ саналыг сонсох гэсэн юм. Нийслэлийн хэмжээнд нийтдээ төрийн өмчит 163 сургууль, 306 цэцэрлэг байна. Тэрнээс 25

сургууль, 26 цэцэрлэг түүхий нүүрс хэрэглэж байна. Ингээд сая өнгөрсөн энэ 2025 оны төсөв дээр 4 сургуулийг хийн түлшинд холбох төсвийг нь тавьсан гэж байна лээ.

Ингээд нэг 4, 4-өөр нь явах юм бол үүнд 13 жил шаардлагатай юм байна лээ улсын төсвөөр хийхэд. Тэгэхээр энүүний дээр төр хувийн хэвшлийн түншлэлээ ашиглах энэ та бүхэн маань энэ дээр ямар гарц гаргалгаа бодож байна вэ? Хувийн хэвшил хэрвээ хийн түлшинд та бүгдэд холбоод өгчих юм бол урт удаан хугацаанд нь 10 жил, 20 жилээр нь түүнийг нь төлөөд хувийн хэвшилдээ ч хэрэгтэй, төрд ч хэрэгтэй, нийслэл Улаанбаатарт ч хэрэгтэй, хүүхдүүдэд маань ч хэрэгтэй байна аа. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг батлаад удаагүй байгаа ч гэсэндээ олигтой хэрэгжиж чадахгүй байгаа. Хуульд нь асуудал байна гэж бас хүмүүс хэлээд байх шиг байна. Тэгвэл үүнийг та бүхэн маань юу гэж бодож байна вэ? Нийслэлийн татварыг ялгаатай байдлаар тогтоодгийг 0.6-аас үл хөдлөх хөрөнгийг нэг хувиар гэж нийслэл дээр шийдсэн.

Яг үнэнийг хэлэхэд манай БЗД-ийн захын хороодын иргэдийн үл хөдлөх хөрөнгийн татвар бол 0.6 хувьд төлөхөд ч хайран байгаа шүү. Тэнд эргэн тойрон дэд бүтэц юу ч байхгүй, сургууль цэцэрлэг юу ч байхгүй, зам харгуй ерөөсөө байхгүй. Ийм газарт 0.6 хувийн татвар төлөх нь битгий хэл энэ бол бараг нөгөө гоё хэсгүүдтэй, дэд бүтэцтэй, байшинтай, замтай бүх хэсгүүдтэй харьцуулах юм бол 40 хувийн биш 400 хувийн ялгаатай байгаа тэнд байгаа хотын байдал өнөөдөр. Тэгэхээр 40 хувийн биш 400 хувийн ялгаатай нь нэгэнт та бүхэн орчинд амьдруулж байгаа юм бол 400 хувийн ялгаатай татвараа тогтоогооч ээ. Нэгэнт л хүмүүсийг ийм нөхцөлд амьдруулж байгаа юм бол. Тэгэхээр энүүнийгээ та бүхэн маань энэ татварынхаа хуулийн хүрээнд хийх үү.

Дараагийн нэг асуудал энэ хотын агаарын бохирдлын асуудал. 2008 оноос хойш манай улс, манай Засгийн газар агаарын бохирдолд мөнгө тавьсан. Энэ удаагийн 20, 40-ийн төлөвлөгөө бол 2040 он гэхэд түгжрэл агаарын бохирдлыг 80 орчим хувиар бууруулна гэж оруулж ирж байна лээ. 2008 онд төрсөн хүүхэд маань бараг насанд хүрэх гэж байх шиг байна. Тэгэхээр энэ бол ахиад 15 жил гэдэг бол их богинохон цаг хугацаа. Тэгэхээр ийм том ахиц дэвшлийг та бүхэн маань гаргана гэдэгтээ итгэлтэй байна уу? 80 хувиар бууруулах?

Дараагийн нэг том асуудал энэ хог хаягдлын асуудал аа. Одоо 98 хувийг дарж булшилж байгаа. Хэд хэдэн төслүүд ерөнхийдөө хэрэгжиж эхэлж байгаа гэж энэ 2040-ийн төлөвлөгөө дээр тавьсан байна лээ. Тэгэхээр дараа дараагийн үүсэх гэж байгаа энэ олон хотуудынхаа хог хаягдлын асуудлуудыг та бүхэн маань яаж шийдье гэж бодож байгаа юм бэ. Хотын зүгээр нэг наад захын шаардлагууд байдаг. Дэд бүтэцтэй байх ёстой нэг хогоо нэг шийдчихдэг байх хэрэгтэй, тэгээд сургууль, цэцэрлэгтэй, төрийн нэг үйлчилгээнүүдтэй байх ёстой гээд. Гэтэл бид нар аягүй гоё сургууль, цэцэрлэг яриад байдаг. Үнэнийг хэлэхэд хогийнхоо асуудлыг бүгдээрээ шийдэж чадахгүй бол хот биш энэ бол нэг жижигхэн деревня болчих гээд байгаа учраас хэдүүлээ энүүн дээрээ та бүхэн маань ямар ажил хийнэ гэж бодож байгаа юм. Энэ 14 дагуул хот дээрээ.

Дээрээс нь энэ олон хотуудыг нэмж байгуулна. Манай БЗД гэхэд 3 хот болно гэж би ойлгосон. Тэгэхээр яах вэ олон хоттой болох нь нэг бодлын сайн ч гэсэндээ нөгөө талдаа 52 хороо нэмсэн шиг хэдэн хорооны даргатай төрийн үйлчилгээ нь нэмэгдээгүй байх юм бол энэ тус нэмэр их багатай шүү. Үүн дээр бас нэг анхаараарай гэдэг.

Б.Пүрэвдорж: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишгээгийн Нямбаатар хариулна.

Х.Нямбаатар: Булгантуяа даргын асуултад хариулахад нийслэл Улаанбаатар хот татвар тогтоодоггүй. Тогтоосон дээд доод хязгаараас иргэдийн хурлаараа сонгож хэрэглэдэг. Тэгэхээр энэ бол татвар тогтоох асуудал бол ялангуяа үл хөдлөх эд хөрөнгөд оногдуулах татварын хувь хэмжээг тогтоох татварын тэр дээд доодод хязгаар тогтоох асуудал Их Хурлын бүрэн эрхийн асуудал учраас энийг Сангийн сайд болон бусад холбогдох албан тушаалтнуудаас авах нь зөв байх гэж бодож байна. Нийслэл Улаанбаатар хот хууль санаачлах эрх байхгүй. Зүгээр санал өгөх эрхтэй.

Хийн түлшний шилжилт рүү явъя гэдэг дээр би 100 хувь санал 1-тэй байгаа. Энэ Агаарын тухай хуулийг бид нар 2022 онд та бид нар цуг баталсан. Энэ хууль дээр аягүй том ийм зохицуулалт орж ирсэн өнөөдрийг хүртэл амилахгүй байгаа. Энэ нь юу вэ гэвэл хийн түлшний шилжилт хийж байгаа иргэн ААН-д татаас олгох тэр журмыг Засгийн газар батална гэсэн ийм зохицуулалт байгаа. Би тэгээд Монголын хийн түлшний холбооныхонтой хэд хэдэн удаагийн уулзалт хийсэн. Энэ журмыг батлуулчих юм бол бид нар LPG-ээр тодорхой саяын өөрийн чинь хэлж байгаа сургууль, цэцэрлэг, энэ эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, төвийн эрчим хүчний системд холбогдоогүй байгаа байгууллагуудыг бид нар ингээд шилжилт хийе ээ.

Дээр нь нөгөө айл өрхүүд дугуй засвар 8 нэрийн дэлгүүрүүд дээр бид нар энэ маш том шилжилт хийе ээ гээд ийм байдалтай тавьж байгаа. Би тэгээд сая ч Ерөнхий сайдад хандаж хэллээ. Өмнө нь ч хандаж хэллээ. Хийн шилжилт рүү шилжих улс төрийн шийдвэрээ яаралтай хотод гаргаж өгөөч ээ. Өөрөөр хэлбэл шилжье ээ гэдэг улс төрийн шийдвэр гаргавал бид нар бүхэлд нь LNG, LPG дэд бүтцийг татах ажил руу хот ингээд бүүр том хүрээнд ингээд оръё оо. Ингэж орсон тохиолдолд бид нар 2030 он гэхэд хийн шилжилт рүү бүрэн орж чадна гэдгийг хэлэхээр байна. Хог хаягдал дээр манай Улаанбаатар хот өнгөрсөн жил 1 сая 800 мянган тонн хог хаягдал гаргаж булшилсан. Бид нар энэ 2 сардаа багтаад хог хаягдал шатаах үйлдвэрийн сонгон шалгаруулалтаа эцэслээд гэрээгээ хийгээд ажлыг нь эхлүүлнэ. 24 сарын дотор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот анхны хог хаягдал шатаах үйлдвэртэй болно.

Харамсалтай нь манай нийт гарч байгаа хог хаягдлын 40 хувь нь огт шатдаггүй үнс зэрэг барилгын хог хаягдлууд гарч ирж байгаа юм. Барилгын хог хаягдлыг бид нар дахин боловсруулах үйлдвэр байгуулчихсан үнсийг нөгөө хог хаягдал шатаах үйлдвэрээс гарсан үнстэй хольж барилгын материал бий болгох ийм нөхцөлөөр тендерийн баримт бичгээ зарлаад явж байгаа. Манай энэ дагуул болон бусад энэ ойр тойрны байгуу суурин газруудын хогийг ч гэсэн шатаах ба багтаамжтай ийм үйлдвэрийн тендер зарласан гэдгийг хэлье ээ.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа нэмж тодруулна.

Х.Булгантуяа: Хийн халаалт руу шилжих гэдэг миний бодлоор бол энэ улс төрийн шийдвэр биш байх гэж бодож байна. Та бүхэн мэргэжлийн хүмүүс. Бид 126 дотор хийн түлшээр мэргэшсэн хүн бол бараг байхгүй байх. Тэгэхээр хэрвээ та

бүхэн мэргэжлийн шийдэл энэ юм гээд л нийслэл Улаанбаатар хот бидэнд орж ирээд л танилцуулаад л ингээд л орвол нийслэл Улаанбаатар хот дээрээ ч гэсэн байдаг юмуу шийдэх юм бол энэ бүрэн боломжтой гэж бодож байна, 1 дүгээрт.

Хоёрдугаарт, Улсын Их Хурал руу та бүхэн маань энэ үл хөдлөхтэй холбоотой дээд доод хязгаарыг нь хуулиар зааж өгсөн. Хотын татвар бас 2 хувь байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой хуулийн санал санаачилгуудаа юун төлөө хотын асуудлыг хариуцсан 20 минутын сайдтай болсон юм шүү дээ. Хот бол өөрөө хууль өргөн барих эрхгүй байсан учраас хотын асуудлыг хариуцсан сайдтай болсон. Тэгэхээр энэ сайдаараа дамжуулаад шаардлагатай гэвэл өргөн барих бүрэн боломжтой. Би бол захын хороодын 400 хувь доогуур нөхцөлд амьдарч байгаа хүмүүс 400 хувь бага татвар төлөх.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр саяхан Монгол улсын Засгийн газар болон Орано Майнинг компанийн хооронд байгуулагдсан Бадрах Энержигийн Зөөвч Овоогийн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан байгаа. Энэ Их Хурлаар 3 хууль нэг тогтоолын төсөл батлагдсан. Энэний ажлын хэсгийн даргын хувиар олон хүмүүст бас баяр хүргэж үг хэлсэн байгаа. Тэгээд энэ дотор бас Хишигээгийн Нямбаатар дарга тухайн үед ХЗДХ-ийн сайд байхдаа энэ хэлэлцээрийг анхлан эхлүүлж хамгийн гол нь бидний баталсан энэ санхүүгийн моделийг хамгийн анх гаргаж энэ Орано Майнингтай тохирсон байгаа. Энэ яг моделийн дагуу энэ гэрээ батлагдсан. Тэгэхээр танд бас энэ дашрамд, энэ ажилд нь бас талархаж байгаагаа илэрхийлье ээ.

Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар асуулт асууна.

А.Ганбаатар: Энэ өдрийн мэндийг хүргэе. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Их Хурлын тогтоолын төсөл болгоод оруулж ирж байгааг ерөнхийд нь дэмжиж байна. Тэгэхдээ яах вэ 2 асуулт байж байна. Өнөөдөр 25 он гэж үзвэл 40 он гэхэд нэг 15 жилийн хугацаа байгаа. Хүний амьдралаар яах вэ багагүй, хотын түүх хөгжлийн хувьд энэ богинохон хугацаа гэж хараад байгаа юм. Тэгэхээр 2040 оны Улаанбаатарын статус ямар байх вэ гэж асууж байна. Яагаад гэвэл энэ зэрэгцээ Хархорин хот, Зуунмод хот, Хүннү гэж нэрлэж магадгүй байна тиймээ. Ингээд олон хотуудын төсөл, төлөвлөгөө, бүтээн байгуулалт орж ирж байгаа учраас цаашдаа Улаанбаатар хот Вашингтон байх юм уу, санхүү, эдийн засаг, бизнесийн хоттой Нью-Йорк нь байх юм уу гэдгийг иргэд бид нар төсөөлөл аваагүй байна л даа.

Тэгэхээр 2040 оны Улаанбаатарын статус ямар байх вэ? Яагаад гэвэл Хархорины ажлын хэсэгт байж байхад алсын бодлого бол түүхэн нийслэлийг сэргээх буюу алсдаа Улаанбаатар хотын оронд нийслэл болох ийм магадлалтай байгаад байгаа юм. Ийм концепц бас яригдсан. Тэгэхээр та энэ дээр төсөөлөл гэдэг юм уу төлөвлөгөөгөө хэлж өгөөч ээ гээд.

Хоёрт нь энэ Их Хурлын тогтоол дотор нийслэл Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавиад 5 жил тутамд Их Хурал тайлагна гээд байгаа юм л даа. 5 жил арай жоохон хол биш үү гээд байгаа юм. Минийхээр бол. 2 жил байж болохгүй юу? 2 жилээ больё гэхэд энэ Их Хурлын бүрэн эрхийн циклээр 4 жилд нэг удаа тайлагнаж байж болохгүй юу гэсэн. Яагаад гэвэл 2040 он хүртэл энэ шаардагдах төсөв бол 200 орчим их наядын төгрөг. Үүнээс 45 хувь нь улсын төсөв, хотын төсөв, ЖДҮ-ийн сангаас ингээд төвлөрүүлнэ гэхихсэн

байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ их мөнгөний урсгалыг Их Хуралдаа 5 жилд тайлагнана гэхээр зарим Их Хурлын цикл нь бас сонсохгүй явчих ийм магадлалтай харагдаад байгаа юм. Ийм 2 асуудал байна аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нямбаатар дарга хариулна.

Х.Нямбаатар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя аа. Хот байгуулалтын тухай хуулиар хотын ерөнхий төлөвлөгөөг 15-аас 20 жилээр төлөвлөнө гээд ингээд хуульчилчихсан.

Хоёрдугаарт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар 5 жил тутам уг хөгжлийн төлөвлөгөөнд мониторинг хийж танилцуулах ийм хуулийн хугацаануудыг л бид нар тавьсан байгаа. Бид нар бас ажлын хэсэг дээрээ яг яриад ер нь энэ хот байгуулалтын тухай хуульд заасан хугацааг ер нь жоохон өөрчилбөл яадаг юм бэ гэсэн дэлхийн дундаж хотуудын ерөнхий төлөвлөгөө ийм үсрэнгүй хөгжлийн үед бол нэг 15-аас 20 жилийн хугацаатай байдаг. Тэгээд саяын энэ 2020 минутын хот гэдэг концепц гэхэд саяхан 2015, 2016 оноос эхлээд л Францын архитектор болон хот төлөвлөгчдийн анх санаачилгуудаар гарч ирээд л дэлхий нийтээрээ тэр тренд рүү явж байгаа юм байна лээ.

Тэгэхээр өөрөөр хэлбэл нэг 15-аас 20 жил тутам хотуудын хөгжлийн тренд өөрчлөгдөж явдаг. Энэнтэйгээ уялдаж хөгжлийн төлөвлөгөө хийгддэг юм байна лээ. Дээр нь та нэг статус асууж байна. Би бол одоо яг хэлж мэдэхгүй байна. Бид нарын GDP өнөөдөр хорьхон тэрбум доллар байгаа. Шинэ Зуунмод хот гэх үү Хүннү гэх үү энэ хот бол Улаанбаатар хот 2 ерөөсөө хоорондоо нэг хот нэг интеграцад орно оо гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Хархорины тухайд бол сая бие даасан хуультай боллоо. Цаашид Монгол Улс хүн ам өсөж эдийн засаг хөгжихийн хэрээр ер нь эртний төрт ёсны түүхэнд ч гэсэн төр улс тэлж хөгжихийн хэрээр хот балгадуудыг босгодог энэ зарчмынхаа дагуу би төлөвлөлт хийж байгаа гэж ойлгож байгаа.

Шинэ Зуунмод хот буюу Хөшгийн хөндий Улаанбаатар хот 2-ыг ерөөсөө салгаж ойлгох боломжгүй. 2 талаараа хурдны зам, тэр одоо нөгөө LRT бусад ийм масс тээврийн хэрэгслүүдээр холбогдсон. Улаанбаатар хотын өнөөгийн байгаа 6 дүүрэг дээр байгаа суурьшлыг тэлэх хамгийн боломжит дэд бүтцийн боломжит хувилбар гэж манай энэ багт зөвлөгөө өгсөн гаднын зөвлөхүүд өгсөн. Энд тээвэр ложистикийн төв нь тийшээгээ гарна. Худалдааны бөөний төвүүд нь бас тодорхой хэсгээр гарна. эрүүл мэнд, боловсролын байгууллагууд хамгийн гол гарч байгаа зүйл нь нөгөө яам агентлагуудыг Засгийн газрыг тийш нь бүхэлд нь гаргая л гэдэг ийм жишээ байгаа. Гаднын улс орнууд ч гэсэн энэ жишээ байна. Сая 2010-аад оны үеэс эхлээд Сөүл засаг захиргааны төвөө Сэйжүн гээд эртний нөгөө хангил үсэг зохиосон хүний нэрээрээ нэрлэсэн ийм хот байгуулсан.

Өнөөдөр Батлан хамгаалах яам, Ерөнхийлөгчийн ордон 2-оос бусад нь өнөөдөр Сэйжүн рүү нүүгээд явж байгаа. Тэгээд яг энэнтэй адилхан бид нар Улаанбаатар хотын төвлөрлийг Богд уулынхаа ар өвөр 2 талдаа тэнцүү задлах зорилгоор ийм төлөвлөлтийг 2040 дээрээ оруулж ирсэн гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Ганбаатар гишүүн тодруулъя.

А.Ганбаатар: Нямбаатар даргын хэлж байгаагаар нөгөө олон улсын жишиг нь 15-аас 20 жилд түргэн хөгжиж байгаа, хурдтай хөгжиж байгаа ийм загвараар явж байна. Явах юм байна манайх. Тийм ээ. Тэгэхээр ерөнхийдөө 14 мега төслүүд хэрэгжээд 14 мини хотууд байгуулагдаад ингээд одоогийн проблем буюу утаа түгжрэл ерөнхийдөө бол алга болно гэж найдаж байгаа. Түүрүүн Ерөнхий сайд үгэндээ дурдаж байсан том төслүүдийг иргэн бүр нарийн ойлгох бараг албагүй тийм ээ энэ бол төрийн бодлого, засгийн бодлогод төлөвлөлтөөрөө түрээд явчих боломжтой юм. Нөгөө талаасаа иргэд нөгөө заавал бүтэн ойлгох албагүй ч гэсэн хаана миний мэргэжил амьдрал байж болох вэ гэдгээ шийдэх хэрэгтэй. Тэндээ төлөвлөж өөрийнхөө нүүдэл суудал, амьдрал, бизнесийнхээ орлогыг төлөвлөх ёстой. Тэгэхээр 14 хот төрөлжиж харагдаж байгаа. Тэгэхээр миний түрүүний асуух гээд байсан энэ Нийслэл болох юм байна энэ нь эдийн засгийн хот болох юм байна энэ дээр нэг ийм чиглэлээр хөгжих юм байна гэдэг нь маш тодорхой.

Тэгээд дээр нь энэ маркетинг сурталчилгаан дээр бол.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. ер нь бол энэ бодлогын баримт бичгийг бүхэлд нь дэмжиж байгаа. Энэ бол маш чухал 2 нийслэл Улаанбаатар хотын 2040 урт хугацааны бодлого батлагдах гэж байна. Энэ бол 2040 он гэхэд Улаанбаатар хот маань ямар байдалтай хөгжчихсэн байх юм. Улаанбаатар хотын өнгө төрх ямар байх юм? Ямар бүтээн байгуулалтуудыг хийчихсэн байх юм? Ямар ямар томоохон асуудлуудыг шийдчихсэн сайн хөгжилтэй хот болчихсон байх юм бэ гэдгийг шийдэх маш чухал бодлогын баримт бичиг. Энд иргэдийн оролцоо бол үнэ үнэхээр өндөр байх хэрэгтэй. Нийт одоо ард иргэдээсээ бүгдээрэнгээс нь санал асуух хэрэгтэй. Хотын иргэдээсээ, уугуул иргэдээсээ бүгдээрэнгээс нь асуух хэрэгтэй.

Цаашлаад энэ олон улсын энэ зөвлөх компаниудыг бол хангалттай сайн харамгүй энэ зөвлөх компаниудтай хамтарч ажиллах ёстой юм байгаа юм. Ингэж байж бид нар сайн төлөвлөлтийг гаргана. Ард иргэд бол ер нь Улаанбаатар хотод юу хэрэгтэйг маш сайн мэдэж байгаа. Гол нь төрийн улс төрчдийн үүрэг бол энэ улс төрийн зорилго чиглэлтэй нийцэж байгаа юм уу, төсөв маань дийлэх юм уу үгүй юм уу гэдгийг л улс төрчид шийдэх юм. Тэгэхээр энэ саналуудаа бас сайн аваарай гэдэг нэг ийм хүсэлт байна.

Хоёрдугаарт нь бол нэг ийм ер нь бол энэ төлөвлөлт гэдэг бол бүх мэдээлэл ард иргэдийн дунд ирчихлээ. Энэ мэдээлэл соргог байгаа дээрээ бид нар маш яаралтай дунд болон богино хугацааныхаа төлөвлөлтийг хийх ёстой. Ингээд төлөвлөлтөө хийгээд авчих юм бол бид нар энэ төлөвлөлтийг хянахад ингээд амар болно. Тэгэхээр энэ дээр цаг хугацаа алдмааргүй байна аа. Энийг яаралтай хийж авах ийм ямар бололцоо байна? Энэ тогтоолын төслийн 2.1 дээр бол энэ 2025 оны 2 дугаар улиралд багтааж энэ төлөвлөлтийг хийнэ ээ гэдэг нь энэ дунд болон богино хугацааныхаа төлөвлөлтийг ярьж байгаа хэлбэр мөн үү? 2 дугаар асуулт.

Гуравдугаарт нь бол би энэ сая Ганбаатар гишүүнтэй бол санал нэг байна. 2030 онд дараачийн тайланг сонсох гэж байгаа байхгүй юу. Энэ ажлын хот төлөвлөлтийн ажлын явцын тайланг 2030 он буюу энэ парламентын эрх зүйн хугацаа нь дуусчихсаны дараачийн парламентад тайланг сонсох гэж байна. Ер нь төлөвлөсөн хүмүүс өөрсдөө гүйцэтгэлээ хянаж явах нь хамгийн үр дүнтэй

дараачийн парламент цаг хугацаа ч өөрчлөгдөнө, энд ажиллаж байгаа, мэдэж байсан хүмүүс нь ч цөөрнө. Тэгэхээр зэрэг энийг ойр маш ойрхон 2 жилд нэг удаа сонсох ийм боломж. 2013 оны ер нь бол Улаанбаатар хотын төлөвлөлт 29 хувьтай биелэлттэй гэж байгаа юм. Тэрний тайланг нь 2, 2 жилд Улсын Их Хуралд сонсож байсан юм байна лээ. Тэгэхээр бид нар 5 жилд нэг удаа энэ тайланг сонсоно гэдэг арай хол биш үү тэ? Энийг ойртуулах ийм боломж бололцоо байна уу? Ийм 2 асуулт байна. Баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Б.Пүрэвдорж: Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Би түрүүн маш тодорхой хэлсэн. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль дээр энэ хугацаануудыг тавьчихсан байгаа. Тэгээд энэ хуулийг хууль тогтоогчид та бүхэн өөрчилбөл тэр тогтоосон хугацааг наашлуулбал бид нар тайлан тавих боломжтой гэж хэлж болно. Зүгээр ер нь би Их Хурлын эрхэм гишүүдийг нэг зүйлийг маш сайн ойлгоосой л гэж бодож байна. Энэ хот төлөвлөлтийн төлөвлөгөө хэрэгжихэд хамгийн чухал юм бол ерөөсөө л санхүүжилтийн асуудал. Тэгээд бид нар ӨМӨЗО-оос GDP-ийн хувьд түрүүн би харьцуулж хэлсэн. Манайх 20 тэрбум долларын GDP-тэй улс улсаараа Өвөр Монголынх 360 тэрбум байдаг. Манай улсын жилийн төсөв 30 их наяд бол түүнээс 6 их наядаар нь 21 аймаг, 9 дүүрэг, 360 сумдаа хөрөнгө оруулалт олгоод зургаахан тэрбум төгрөгийг жилдээ хувааж зарцуулдаг.

Гэтэл бид нарын энэ ерөнхий төлөвлөгөө дээр хэрэгжүүлэх гэж байгаа тавьж байгаа бид нарын том зорилт бол 240 их наяд. Үүнээс 120 их наядыг нь бид өөрсдөө улсын төсөв дээр тавьж өгөх ёстой. Тэгэхээр Их Хурлын гишүүд тайлан сонсох нэг хэрэг. Тайлангаа хэрэгжүүлэхийн тулд жил болгоны улсын төсөв дээр дэд бүтцийг хөгжүүлэх сан дээр мөнгөнүүдийг энэ дэд бүтцийн тодорхой төлөвлөсөн мөнгөнүүдийг л тавиад өгвөл энэ ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн гол үндэс бүрдэнэ ээ.

Дээр нь манай энэ 2040-ийн гол үндсэн нь юанс нь юунд оршиж байгаа вэ гэхээр хот улс өөрөө эхлээд дэд бүтцээ шийдээд өгье, газраа чөлөөлөөд өгье өө. Дэд бүтэцтэй чөлөөлөгдсөн газар дээр хувийн сектороороо орон сууц бусад тэр нийгэм соёлын, барилга байгууламжуудыг барьж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хамтдаа энэ 2040-ийг хэрэгжүүлье ээ гэдэг л ийм үндсэн уриа лоозонтой ийм ерөнхий төлөвлөгөө байгаа гэдгийг товчхондоо хэлье.

Бид нар 1984 оноос хойш нэг ч ДЦС бариагүй. 40 жил, 50 жил болж байгаа шугамуудаа өргөтгөж шинэчлээгүй, эрчим хүчний хэрэглээ 2035 он буюу 10 жилийн дараа гэхэд 3 гегад хүрнэ. Түүнийг дамжуулах шугамыг татахад л би энийг олон удаа давтаж хэлж байгаа. 2 тэрбум долларын зардал урьдчилсан байдлаар төлөвлөж байгаа.

Тэгэхээр ерөөсөө улс нийслэл энэ ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрэгжихүйц зардал мөнгийг тавиад өгвөл энийг хэрэгжүүлэхэд, салбарын яамдуудтай хамтарч хот, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэхэд бэлэн байгаа гэдгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Нямбаатар дарга дөнгөж сая хэллээ. Энэ санхүүжилттэй холбоотой асуудлууд байж байж л ер нь асуудал явна гэж. Тэгэхээр бид чинь үндсэндээ бол холимог тогтолцоогоор явдаг болчихлоо. Хуучны зөвхөн 76 тойрог руугаа юм чулуудаад хувааж тэндээ л хэдэн тойрог дээрээ хуваачихдаг байсан бол одоо энэ чинь холимог тогтолцоогоор пропорционалиар орж ирсэн. Нөгөө нэг бид нарын бас нэг жоохон ад үзэх маягтай байгаа 48 гишүүн энэ бол яг улс эх орны ач холбогдол бүхий рейтингээр нь ингээд санхүүжилт хөрөнгө оруулалтыг эд нар хардаг ийм зарчим руу орчихсон шүү дээ. Тийм болохоор цааш цаашдаа хөрөнгө оруулалтын асуудлууд бас ингээд шийдэгдээд явах байх гэж бодож байгаа юм. Энэ 2010, 2011 байх аа. Би тэрийг хэлж санахгүй байна. Энэ хот байгуулалтын хуульд оруулсан шүү дээ. Хот байгуулалтын тухай хуульд оруулаад энэ Улаанбаатар хотын төлөлтийг бид нар Улсын Их Хурал үздэг болсон, хэлэлцдэг болсон баталдаг болсон. Энэ яасан гэхээр би бас хэлээд л байгаа юм. Урьд өмнө нь гарч байсан алдаа дутагдал өөрөөр хэлбэл хэн нэгэн Засаг дарга, хэн нэгэн газрын албаны дарга, хэн нэгэн архитектур очоод эвдээд байдаг энэ хот төлөвлөлтийг концепцыг эвдэхгүй хууль болгож бид нар энэ Улсын Их Хурлаар оруулдаг болсон.

Өнөөдөр ингээд ач холбогдол нь гарч байна гэж бодож байгаа. Энэ олон асуудлууд гарч байж байна. Ард иргэд маш том мэдээллүүдийг авч ирж байна. Маш олон сайхан танилцуулгуудыг хийлээ.

2 асуудал байгаад байгаа шүү дээ. Одоо ер нь ард иргэдийн тэр тусмаа Улаанбаатарчуудын хараад байгаа асуудал 1 дүгээрт бол утааны асуудал.

Хоёрдугаарт авто замын түгжрэлийн асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр одоо бол элдэв янзын зуух энээ тэрээ гэхгүйгээр шууд тэр газ руугаа хийлгүй хатуу түшсэнээсээ татгалзсан руугаа оръё гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Улаанбаатар хотоос бол концепц гаргаж ирж байгаа юм байна, төлөвлөгөө гаргаж ирж байгаа юм байна. Зайлшгүй хэрвээ хуульд өөрчлөлт оруулах ёстой гэж байвал одоо жишээ нь Улаанбаатар хоттой ярилцаж байгаа тэр хуульд нь өөрчлөлт оруулъя Нямбаа даргаа, санаачилъя. Тэгээд ерөөсөө хууль руугаа орох хэрэгтэй байна. Энд 30 он гэхэд оръё гэж байгаа юм байна шүү. Тийм болохоор 5 жил гэдэг бол богинохон хугацаа. Хэрэв 5 жилийн хугацаанд амжуулъя гэж байгаа бол маш яаралтай амжуулах хэрэгтэй байна. Дэмжье, 2 гараараа дэмжье, бүх зүйл дээр чинь тусалъя, дэмжье.

Хоёрдугаарт энэ түгжрэлтэй холбоотой асуудал. Японы Засгийн газраас тусламж дэмжлэгээр техник эдийн засгийг үндэслээд энэ авто замын бүх сүлжээг бол засаж янзалсан шүү дээ. Өнөөдрийг хүртэл бид нарын янзлаад байгаа юмнууд чинь ерөөсөө тэрний хүрээнд л явагдаад байгаа л гэж би ойлгож байгаа. Тэгээд хэд хэдэн түвшний 2 түвшний уулзваруудыг янзлах энэ Баруун 4 зам, Зүүн 4 зам, тэгээд Саппоро Баянбүрдийн уулзварууд эд нар гээд энэ байж байгаа. Энэ уулзваруудыг чинь 2 түвшинд болгоё гэсэн ийм зүйл гарсан шүү дээ. Энэ ерөөсөө сүүлийн үед яригдахгүй юм. Би энд Нямбаатар дарга би сүүлд бүүр бодох юм эсвэл би хоцрогдоод байгаа юм уу. Бид нарын хийж байсан юм шинэ залуучуудын чинь хүрээнд ерөөсөө хэрэггүй болчихоод байгаа юм уу гэж бодох юм.

Энэ 2 түвшний зам, давхар зам, 2 түвшний уулзваруудын асуудал ерөөсөө яригдахгүй болчихоод байх юм. Энэ дээр та бүүр нэг юугаа хэлж өгөөч. Саналаа хэлж өгөөч. Энэ ер нь хийх ёстой юм уу үгүй юм уу? Одоо жишээ нь энэ гүүгл дээр та бүхэн хар л даа. Ерөөсөө хэдэн уулзварууд чинь Баруун 4 зам, Зүүн 4 зам, тэр

Саппоро тэр бүх уулзварууд чинь дандаа бүгдээрээ улаан байгаа шүү дээ. Өдрийн цагаар гэхэд чинь наад талууд нь дандаа ногоон байж байгаад яг уулзвар дээр очоод л улайрчхаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хэдэн уулзварууд чинь өөрсдөө бөглөрөөд байгаа юм биш үү? Энэ хэдэн уулзварууд чинь өөрсдөө түгжрэл үүсгээд байгаа юм биш үү? Тэгэхээр энэн дээр нэг хариулт хэлж өгөөч. Одоо тэр төлөвлөлтийн дагуу энэ давхар замаа ер нь хийх юм уу? Давхар зам гээд тэгэхээр 1 их айхтар нүсэр юм бодоод байх шиг байна. Үгүй шүү дээ хийх ёстой газрууд нь хийгээд л явчихна шүү дээ. Тэгэхээр наад зах нь гэхэд энэ хэдэн уулзваруудаа янзалж байж энэ түгжрэлтэйгээ ноцолдохгүй бол зүгээр нэг хэд хэдэн илсэн байдлаар бол.

Б.Пүрэвдорж: Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Бат-Эрдэнэ гишүүн ээ бид нар энэ 2040-өө батлуулчихсаны дараа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Улаанбаатар хотод 14 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 42 нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг олон улсын нээлттэй тендерээр зуруулахаар тендерийн материал бэлдэж байгаа юм. Тэгээд энийгээ бид нар олон улсын ийм нэр хүнд бүхий компаниар зуруулчихсан тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар батлуулчих юм. Засгийн газрын хуралдаанаар батлуулчихвал ерөөсөө нөгөө барилгын зөвшөөрөл авах нөгөө А-ийн даалгавар авах, эскиз батлуулах гэдэг ойлголт бүрмөсөн байхгүй болно. Өөрөөр хэлбэл 15 дугаар хорооллын тэр тухайн нэгж хороолол дээр тэдэн давхар өндөр барилга байна гэдгийг бүх төлөвлөгөөг нь урьдчилаад бид нар баталчих юм аа. Хэмжээ дамжаатай нь.

Хоёрдугаарт таны ярьж байгаа тэр давхар зам энэ 2 асуудал ярьж байгаа.

Нэгдүгээрт, Туулын хурдны зам бол экспресс вэй гэж олон улсын тэр ангиллаараа гэрлэн дохиогүй хэд хэдэн орц гарцуудтай шууд шулуун явдаг зам. Түүн дээр ирж огтлолцох тойрог хурдны зам гэж 26 км Улаанбаатар хотын баруун, хойд, зүүн хэсгийг бүхэлд нь кольца байдлаар холбосон ийм 2 түвшний гүүрэн байгууламж бүхий замын тендерийг бид нар энэ 6 сард зарлах гээд ТЭЗҮ дээрээ суугаад ажиллаж байна. Тэгэхээр энэ зарлагдах юм бол бид нар энэ Улаанбаатар хотын ачааллыг 40 орчим хувиар бууруулна гэдэг ийм симуляц хийсэн. Таны хэлж байгаа Саппорогийн уулзвар хойд талын энэ нөгөө Дөлгөөн нуурын уулзвар, бусад хэд хэдэн томоохон ийм ачаалал бүхий уулзваруудыг олон түвшний болгоё гэдэг. Энэ судалгааны ажил хэвээрээ хийгдэж байгаа. Бид нар алийг нь эхэлж нэгдүгээрт тавих вэ гэдгээсээ шалтгаалаад Туулын хурдны зам дээр нийслэлийн төсвийг бүхэлд нь дайчилъя гэдэг ийм шийдэл хүрсэн юм. Таны ярьж байгаагаар ер нь бүх замуудыг бид нар олон түвшний болгож болохгүй байгаа юм аа. Яагаад гэвэл дараагийнхаа замууд дээр очоод хахаа үүсгэх гэж байгаа ийм симуляцын үр дүнгүүд харагдаж байгаа.

Тухайлах юм бол Гадаад хэргийн яамны уулзварыг олон түвшний болгож байгаа тохиолдолд одоо манай энэ орд гадны баруун хойд уулзвар өөрөө цаашаагаа нэвтрэх зам нь ерөөсөө хоёрхон эгнээ байгаа учраас иймэрхүү зарим газруудад ачаалал өгөх газрууд дээрээ бид нар бүгдэд нь давхар түвшний болгож болохгүй байгаа ийм мэргэжлийн байгууллагын дүгнэлтүүд байгаа. Таныг Зам, тээврийн яамны төрийн нарийн байхад эхлүүлсэн хэд хэдэн судалгааны ажлуудын үр дүн дэх томоохон уулзваруудыг олон түвшний болгох ёстой. Зүүн 4 замын уулзвар, Баруун 4 замын уулзвар, Саппорогийн уулзвар, энэ хойд талын Дөлгөөн

нуурын уулзвар энэ тэр гэх мэт энэ уулзваруудыг бид нар олон түвшний болгох замаар хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх боломжтой гэдэг ийм загварчлал гарсан гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Бат-Эдэнэ гишүүн тодруулья.

Ж.Бат-Эрдэнэ: Мэдээж мэргэжлийн үүднээс та бүхэн бас тооцоолол хийгээд ингээд гаргах нь зөв байх. Мэдээж бүгдийг нь аваачаад давхар болгоно ч гэж юу байх вэ. Тэрийгээ бол тооцох байх гэж бодож байна. Энэ хорооллууд дунд байж байгаа нэвтрэх чадварыг сайжруулмаар байна. Тэгэхгүйгээр дан төв замууд чинь бөглөрчхөөд байна шүү дээ. Тэгээд зарим газар магадгүй зүгээр тэр газар чөлөөлөх асуудлууд, газар худалдаж авах байдаг юм уу яадаг юм, ямар байдлаар байдаг юм тэр ААН-үүдийн бас тэр нэг зөндөө олон хашаануудыг нэвтрээд нэвтрээд дундуур нь явдаг сүлжээд явдаг гардаг нэг ийм жоохон гарцуудыг янзалмаар л харагдаад байх юм. Тэрэн дээр нэг анхаарал хандуулаарай гэж. Ер нь бол дэмжиж байгаа тэгээд асуудлыг мөн ажлын хэсэг дээр нэлээн ярилцаад явах байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Нийслэл Улаанбаатар хотын 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай гээд үүнийг дэмжиж байгаа. Тэгээд их олон гишүүд асуулт асууж нэлээн дэлгэрэнгүй зарим үед нь дутуу ч хариултууд яваад дуусаж байна. Асуугдаагүй байж магадгүй зарим нэг зүйлийг нь асууя. Давхардсан асуултуудаа орхиё доо. Түрүүн хариулчихсан асуултуудыг бас асуугаад яах вэ? Энэ нэг стандартууд байдаг евро стандарт ч гэдэг юм уу энэ стандартын ойлголтууд хэр явж байна вэ? Одоо жишээ нь 10 мянган хүнд байдаг юм уу, 5 мянган хүнд, 50 мянган хүнд. Бид нар нэг зүйл хариултыг тогтмол аваад байгаа. Сургууль, цэцэрлэг бүгд тавигдаж байгаа энэ тэр гээд эмнэлэг гэдэг ч юм уу. Энд чинь байгаа тэр одоо жишээ нь бусад асуудлууд байж байна шүү дээ. Одоо жишээ нь Үндсэн хуульд заагдсан хүний эрхтэй холбоотой шашин шүтэх тухайд ч байдаг юм уу. Тэдэн мянган хүн дотор нэг ширхэг сүм хийд байна ч гэдэг юм уу, тэдэн мянган хүн дотор нэг ширхэг ийм соёлын төв, урлаг соёлын байгууллага, номын сан гэдэг юм уу тийм стандартууд энд хэр тавигдсан юм бэ гэдэг тухай асуумаар байгаа юм.

Хоёрт нь энэ Улаанбаатар хотыг чинь хүн болгон л бараг ярьж байдаг. Нөгөө явган хүнд ээлгүй хот. Ерөөсөө явган алхах боломжгүй. Дээрээс нь хүйтэн хот өвөлдөө бол. Тэр байгалийн хүчин зүйлээс гадна зүгээр явган хүн яагаад алхахгүй байна вэ гэхээр наад явган хүний зам дээр чинь үндсэндээ хажуугаар нь энэ скүүтэр дугуй янз бүрийн юм гаргаад ирчихсэн, хүн явахад их эрсдэлтэй болчихсон. Одоо хэн нэгэнтэй шүргэлцэхээс авхуулаад эрх чөлөөндөө халдуулах гэдэг юм уу үгүй бол халтирч унах, үгүй бол тэр чулуу тэр явган хүний зам дэвсгэр тавьж байгаа тэр чулуунууд нь нүхтэй энхэл донхол юм уу халтиргаатай юм уу эвдэрхий байдаг. Нэг бол ингээд нарийсгаад хаячихдаг нэг хэсэг жоохон өргөн байж байснаа нарийсгаад хаячихдаг. Тэгээд явган хүмүүс чинь явж орж ирээд л ганц л зүйл байгаа шүү дээ. Тэгж унаад тэгж халтираад тэгж хүнд зодуулах шахлаа одоо маргааш машинаа унаад гарья даа л гэж байгаа шүү дээ. Явган хүнд огт ээлгүй хот. Бид нар өөр улсад очоод 1, 2 км газар бол зүгээр л алхчихдаг шүү дээ.

Тэгэхээр энэ явган хүний төлөвлөлт явган хүмүүсийг зорчих тэр боломжийг хэр тусгаж байгаа юм бэ? Мэдээж том замууд, гүүрнүүд, байгууламжууд, масс, тээвэр энэ бүх юмнуудыг яриад байдаг. Хажуугаар нь нөгөө талдаа бид нийтийн

тээврээс буугаад дахиад алхах газар нь хэцүү байвал дахиад л машин руугаа очно. Дахиад л түгжрэл дахиад л утаа үйлдвэрлэдэг энэ зүйл рүүгээ л очно. Энэ чиглэл рүү анхаарч байгаа зүйлүүд. Тэр аюулгүй байдал, эрсдэлийн асуудлууд байна 3-д нь.

Хотод бол маш олон төрлийн эрсдэлүүд байгаа. Байгаль орчин дээр бид нар ярьж байгаа зүйл нь нөгөө байгалийг даван дийлэх аргагүй учраас дасан зохицох тэсвэрлэх тухай асуудлууд ярьж байгаа. Тэсвэртэй хотын тухай асуудлууд яригдаж байгаа одоо. Энэ чиглэлээр ерөнхий төлөвлөлт дээр хаана нь яаж орсон бэ гэдэг зүйлийг асууя.

Б.Пүрэвдорж: Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Батбаатар гишүүн энэ 2040 он хүртэлх хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд хотын стандарттай холбоотой асуудлууд хэрхэн туссан бэ гэдэг ийм зүйлийг асуулаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хот нийтдээ 72 стандарт батлагдахаас, 50 стандарт нь батлагдаад явж байгаа, 22 стандарт нь батлагдах шатдаа явж байгаа. Аливаа хотын ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа энэ ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж үүсдэг хэд хэдэн нөхцөл байдлууд байдаг юм байна. Өөрөөр хэлбэл тодорхой стандартуудыг шинээр батлах, шинээр анхдагч хуулиудыг санаачлан батлуулах тодорхой хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах гэх мэт ийм тохируулгын шинжтэй зохицуулалтууд үүсдэг нөхцөл байдлууд бусад улс орны хотуудын ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа бий болдог. Тэр утгаараа магадгүй энэ 2040 батлагдсаны дараа 2040-ийн хэлэлцүүлгийн явцад тодорхой санал санаачилгууд орсонтой холбоотойгоор шинээр стандартуудыг шинэчлэн тогтоох ийм шаардлагууд үүснэ ээ гэж харж байгаа. Сая Лос Анжелес хотын хэд хэдэн дүүргүүдэд ноцтой гал түймэр гарсан талаар мэдээллүүдийг бид нар бас нэлээн авч судалж үзсэн.

Тэнд ерөөсөө галын шалтгаан нөхцөлийн нэг томоохон галд тэсвэртэй байх зүйл дээр хэд хэдэн асуудлууд үүссэн гээд мэргэжлийн экспертүүд нь тайлбарлаж байна лээ. Тухайлах юм бол хамгийн түрүүнд гал унтраах системүүдийн ерөөсөө усгүй байсан гидрантын системүүд нь. Гэтэл манайд өнөөдөр Улаанбаатар хотод өндөр барилгууд болон орон сууцын хорооллуудын дунд гидрантын нэг ч систем байхгүй байгаа. Тэгэхээр цаашид бид нар энэ 2040-ийг батлахтай зэрэгцэж энэ 2040-ийн араас хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд таны саяын ярьж байгаа тэр байгалийн гамшигт тэсвэртэй байх тэр гамшигийн эрсдэлийг бууруулах энэ чиглэлийн стандартуудыг нэмж шинэчлэх шинээр гарц галын болон бусад гамшиг ослын үед иргэдийг авран хамгаалах, хотоос гарах гарц, нэгдсэн удирдлагын системүүдийг шинэчлэн бий болгох талаар маш тодорхой зохицуулалтуудыг энэ 2040-ийн төлөвлөгөөнд тусгасан гэдгийг хэлье.

Дээр нь сая та юуг асуусан. Энэ явган хүний зам явганд ээлтэй байдал, ээлгүй байдлын талаар ярьсан. Өнөөдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод 584.6 км явган хүний зам байна. 2040-ийг бид нар батлуулснаар энэ тоог 2199.5 км болгох төлөвлөгөөтэй байгаа. Дугуйн замын төлөвлөлтийг 75.2 км байгааг 1677км болгож өөрчлөх төлөвлөгөөтэй байгаа.

Дээр нь одоо байгаа замуудынхаа стандартыг бид нар шинэчлэх чиглэлээр хот тодорхой ажлуудыг хийж байгаа. Их Бага тойруу, Наадамчдын гудамж. Олимп.

Б.Пүрэвдорж: Одоо 1 гишүүн асуулт асууна. 2 гишүүн үг хэлнэ. Үүний дараагаар санал хураалттай гишүүд чуулганы танхимдаа морилохыг хүсье. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Энийг бол дэмжиж байгаа ер нь аль болох хурдан шуурхай баталбал зүгээр байна гэж бодож байгаа. Яагаад гэвэл яг энийг хэлэлцэж байх үе шатад бас зарим барилга бас баригдсаар байх байгаа гэж бодож байна. Засгийн газраас дэд бүтцийн хөгжлийг дэмжинэ гэдэг ийм жил болгон зарлаж онцгой анхаарал хандуулж байгааг дэмжиж байна. Ер нь хүн амын маань олонх нь гэж бараг хэлж болох энэ нийслэл хотоос бас ажил амьдралаа залгуулж сурч боловсорч байна.

Тийм учраас энэдээ онцгой анхаарч байгааг дэмжиж байгаа. Гэхдээ зарим төрлийн хязгаарлалтуудыг бол энэ дэд бүтцийн хөгжлийг зэрэгцүүлээд хийж явах зайлшгүй шаардлагатай. Энэ хүрээндээ бол НЗД-аас барилгын өндөрт хязгаарлалт тавьж байгаа бодлогыг хэрэгжүүлж байгаа гэж би ойлгож байгаа. Үүнийг дэмжиж байна. Ер нь энэ өндөр барилга баригдаад байвал тэгээд л түгжрэл хэзээ ч дуусахгүй. Тийм учраас энд амьдарч байгаа айл өрхийн тоо болон энд үйлчилгээ явуулж байгаа энэ метр квадратаас нь хамааруулж энэ гадна талын зогсоолын хэмжээг тооцдог газар олгохдоо энийг тооцдог ийм Хот байгуулалтын тухай хууль болон Газрын тухай хуульд өөрчлөлт оруулахгүй үүнийг шийдэхэд үнэхээр хүнд. Өндөр өндөр барилгууд барихаар доор нь бол машины зогсоолд багтахгүй ээ.

Дээр нь ер нь зонхилох салхины дээд тал чиглэлдээ газар олгохгүй байгаа гэж би ойлгож байгаа. Цаашдаа энийг онцгой анхаарах хэрэгтэй юм байна лээ. Ялангуяа энэ Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль дээр аймгийн төвүүд дээр энийг анхаарах хэрэгтэй. Манай Дорнод аймаг гэхэд одоогоос 8 жилийн өмнө иргэдийн Хурлаараа тогтоол гаргуулж салхин дээд талдаа гэр хороололд газар иргэдийн гэр бүлийн хэрэгцээнд зориулж олгохыг зогсоож салхиныхаа доод талд олгох бодлогыг барьсан нь 8 жилийн дараа одоо харахад бол ингээд аягүй түүхэн чухал шийдвэр байсан байгаа юм. Тэгээд хоног хугацаа ингээд амархан өнгөрдөг учраас үүн дээр бас анхаарах байх гэж бодож байна.

Дээр нь ийм орон торны бүтэцтэй байдаг юм байна лээ хотууд. Тийм учраас ийм жижиг замуудыг маш сайн хотхон хороолол дунд барихгүй бол ингээд төв зам дээрээ бүгдээрээ орж ирээд овоороод үндсэндээ ингээд нэг зүйрлэж хэлэх юм бол тийм нэг элсэн цаг шиг болчхоод байгаа юм. Нэг талдаа өргөн замтай ч гэсэн нөгөө талдаа нарийхан замтай болохоор. Тэгэхээр энэ дээр дэд бүтцийн хөгжлийн хүрээндээ тодорхой ажлууд хийнэ байх гэж найдаж байна. Тэгээд орон нутаг, бүс орон нутгийг зэрэгцүүлээд бас хөгжүүлэх бодлогыг давхар баримтална гэдэгт бас энэ орон нутгаас бүсээс сонгосон гишүүнийхээ хувьд найдаж байгаагаа илэрхийлье. Ер нь цаашдаа орон нутгуудын бие даалгах бодлогыг нь төсвийн болон өмчийн томилгооны эрх мэдлээр бол эрс нэмэгдүүлж өгөхгүй бол үндсэндээ ингээд нэг ийм төв Засгийн газар Улсын Их Хурлаасаа хараат ийм байдалтай орон нутгууд бол ингээд үндсэндээ одоо бид хөрөнгө байхгүй юм чинь юу ч хийж чадахгүй байна гэсэн ийм байдалтай байгааг бас цаашдаа онцгой анхаараасай гэж бодож байна.

Тэгээд нэг 2, 3 тодорхой санал хэлье. Томоохон ордуудыг түшиглэж хот байгуулах ийм хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байгаа. Дээр нь энэ боомтуудыг түшиглэж бас тодорхой хотуудыг байгуулах хэрэгтэй. Яагаад гэвэл уурхайчин залуу гэрээсээ ажилдаа явдаг. Гэр бүл нь тэндээ сургууль, цэцэрлэгтээ ажилладаг. Хүүхэд

нь гэртээ өсөж хүмүүжиж, гэрээсээ сургууль, цэцэрлэгтээ явдаг энэ тогтолцоо руу бид нар очихгүй бол энэ уул уурхайн бүс нутгууд бол үндсэндээ ростер гэдэг нэрээр 14 хоног уурхай дээрээ ажилладаг, 14 хоног гэртээ байдаг. Тэгээд ийм нөхцөл байгаа учраас энэ боломжууд бидэнд байна. Одоо жишээлбэл Оюу Толгой компани ингээд Ханбогд сумын дэд бүтцэд зориулж 50 сая долларын дэмжлэг үзүүлж байгаа гэж байгаа. Тэгвэл манайх улс төсвөөсөө адилхан 50 сая долларын дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Ингэж төв хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд тэнд хот байгуулах бодлогыг бас давхар хөшүүрэг бодлогоор дэмжиж явах ёстой. Дээр нь хөрөнгө оруулалтын гэрээ сая хийгдсэн. Энэ Орано Майнингтай. Тэгээд энэ дээр бол энэ зүйлүүд бас хараахан ороогүй байна лээ. Ер нь энэ уул уурхайн томоохон төслүүдийг.

Б.Пүрэвдорж: Нэмээд авчих уу? Нэг минут нэмж өгье.

М.Бадамсүрэн: Цаашдаа батлах энэ уул уурхайн гэрээн дээр бол энэ зүйлүүдийг заавал оруулж тусгаж өгөх хэрэгтэй гэдгийг бас энд хэлэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл орон нутгийн тэр суурьшлуудыг дэмжихээд нийслэлд ирж байгаа ачааллыг бууруулна. Тэгэхгүй бол дээр үеэсээ л энэ хүрээ гэдэг газар чинь хүн болгоны хүсэж тэмүүлж ирдэг Тунгалаг тамир кинон дээр гарч байгаа шүү дээ. Одоо Эрдэнэ ингээд тэр баруун аймгаас Засагт ханаас ингээд нийслэл рүү гээд морин тэрэгтэйгээ явдаг. Тэгээд тэрэнтэй адилхан хүн болгон тэмүүлж байгаа учраас орон нутагт нь ажлын байр гаргах орон нутгийг нь бас дэд бүтцээр дэмжих бодлогыг давхар хэрэгжүүлж явахгүй бол нийслэл дээрх энэ ачаалал маань улам нэмэгдээд л улам л ачаалалтай болоод байх гэж бодож байна. Тэгээд энэ хүрээндээ шийдэх ганц нэг ажил байна.

Өөрөөр хэлбэл орон нутгийн сургуулиудыг ийм коллеж хэлбэрээр тэгээд 2 дээр нэмэх нь 2. 2 жил нь орон нутагт сураад 2 жил нь Улаанбаатарт сурах энэ тогтолцоог хүртэл бүрдүүлэхээс өгсүүлээд ингээд боловсролын систем дээр хүртэл хийх ажлууд ингээд уялдаатай эрүүл мэнд, боловсролын.

Б.Пүрэвдорж: Санал хэллээ. Төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Жаргалсайханы Золжаргал гишүүн. Индрийн 2 дугаар микрофон.

Ж.Золжаргал: Улаанбаатар 2040 гээд энэ том бичиг баримт миний мэдэхийн 2016 оноос хойш явж байгаа. Тэгээд энэ тууштай ажилласаар байгаад шинэчлээд сайжруулаад эцсийн бүлэгт нэгтгээд оруулж ирээд энэ том ажлын ард гарсан нийслэлийн удирдлагууд энэ ажлын хэсгийн мэргэжилтнүүд багт та бүхэндээ баяр хүргэе ээ. Амжилт хүсье. Энэ монголчууд үндэсний мэргэжилтнүүд өөрсдөө яг ахалж санаачилж, гар бие орж өөрийн толгойгоор Улаанбаатар хотоо төлөвлөж байгаа. Маш ийм комплекс төлөвлөгөө байна гэдгийг хэлмээр байна аа. Тэгээд төслийг дэмжиж байгаа.

Анхаарууштай, заавал хэлэх ёстой 2 чухал санаа байна.

Нэгдүгээрт нь Монгол Улсын иргэд 0.07 га-га эзэмших эрхтэй. Хүмүүс тэнд очоод Хөшигийн хөндийг жорлонгийн хөндий болгох биш ээ. Жорлонгийн хөндий

болгох уу, хөгжлийн хөндий болгох уу гэдгийг эрх барьж байгаа төлөвлөлт хийж байгаа хүмүүс шийдэх эрх мэдэл нь байгаа. Түүнийг нь бас иргэд олгосон байгаа юм. Тийм учраас элдэв янзын яриа байна. Тэнд ингээд түрүүлж очоод улс төрд нөлөөтэй танил талаа ашиглаад олон 100 га, мянган гагаар нь ингээд авчихсан байна гээд. Тэгэхээр энийг шударга байдлаар нээлттэй байдлаар нэг хэсгийг нь инженерийн дэд бүтцийг нь төлөвлөж байгаад иргэдийн 07-г нь шинэ суурьшлын бүсүүдэд тусгаж өгөх нь зүй ёсны асуудал гэж үзэж байгааг цохон тэмдэглэмээр байна.

Хоёрдугаарт нь гэр хорооллын утааны эсрэг гол арга хэмжээ нь барилгажилт юм байна аа төлөвлөснөөр.

Дээрээс нь хийн түлшний хангамж байж болохоор байна. Энэ хэрэгцээгээ хангахын тулд ДЦС болон дулааны станцуудыг төлөвлөсөн байна аа. Нэгэнт 2030 оноос хойш хатуу түлш хэрэглэхгүй ээ гэдэг үзэл санаа барьж байгаа бол элдэв завсрын нүүрсэн түлшний үйлдвэрүүдэд их хэмжээний мөнгө оруулахаа больё. Тэр мөнгөөрөө төлөвлөлт дээр оруулчихсан байгаа ДЦС-уудаа барья. Үгүй ядаж үнэхээр том химийн үйлдвэр баримаар байгаа бол нөгөө хийн түлшээ бодъё. Үүн дээр анхаараасай. Эргээд хэдэн жилийн дараа толгойгоо барих, тархиа барих ажилд битгий хамаг цаг хугацаагаа зараасай гэж хүсэж байна. Тэгээд та бүхэнд дахин талархаж байгаагаа илэрхийлье. Амжилт хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Цахим хөгжлийн сайд Цэндийн Баатархүү үг хэлнэ ээ. Индрийн 2 дугаар микрофон. Гишүүд шууд санал хураалттай шүү.

Ц.Баатархүү: Сайн байцгаана уу? Тэгээд өнөөдөр Улаанбаатар хотын ирээдүйд ямар зураглалаар хөгжих юм бэ дэвших юм бэ гэдэг маш том хэлэлцүүлгийг хийж байна. 2040 он гэхэд дэлхийн нийт хүн амын 65-аас 70 хувь нь хотуудад амьдрах юм байна. Хот бол эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог гол институт гол тоглогч болно. Хотуудыг хөгжүүлэхгүйгээр улс орон бол хөгжихгүй юм байна аа. Хотыг хөгжүүлэхийн тулд зөв төлөвлөх хэрэгтэй, зөв төлөвлөхийн тулд иргэдийн оролцоо хамгийн чухал юм байна.

Тэгэхээр өнөөдөр Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байгаа 2040-ийг нийслэл Улаанбаатар хотын айл өрх бүрээс санал авах ийм шаардлагатай гэж би бодож байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүргээс сонгогдсон гишүүнийхээ хувиар чуулганы завсарлагаанаар дүүрэг, хороодынхоо иргэдээс хотын ерөнхий төлөвлөгөөнд дараа нь орж ирэх хэсэгчилсэн төлөвлөгөөнд саналыг нь авна гэдгээ хэлье.

Хоёрдугаарт нь хотын хөгжлийн нууц бол маш энгийн. Зөв төлөвлөнө. Төлөвлөлтөө хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд мөн иргэдийн оролцоо эрдэмтдийн оролцоо маш чухал маш чухал. Тэгээд өнөөдөр Улаанбаатар хотыг хөгжүүлэхгүй байгаа зүйл бол газрын харилцаа биш ээ. Бид нар газрын харилцааг өөрөөр харах хэрэгтэй. Газар чөлөөлөлт нь бүх зүйлийг гацаагаад байгаа биш ээ. Иргэд газраараа, тухайн орон нутагтаа, хороондоо, хотдоо хийгдэж байгаа томоохон бүтээн байгуулалтаас хувь эзэмшиж болдог ийм цоо шинэ хөрөнгө оруулалтын тогтолцоо руу дэлхийн хотууд орсон байна аа. Жишээлэх юм бол Сэлбэ хотын иргэд Сэлбийн дулааны станцад тодорхой хувь эзэмшиж болдог ийм тогтолцоо руу хотууд орж байна аа. Тухайн хороонд баригдаж байгаа томоохон төсөл арга хэмжээнд орон нутгийн иргэд нь, хотын иргэд нь хувь эзэмшдэг төслөөрөө хамтардаг нэгдэж

нийлээд бүтээн байгуулдаг цоо шинэ энэ концепцыг хотын энэ ерөнхий төлөвлөгөөнд тусгаж өгөөч гэдэг ийм саналуудыг хэлж байгаа юм.

Гуравдугаарт нь иргэдийнхээ өмчтэй байх эрх, хөрөнгөтэй байх эрхийг хааж боох биш нээх хэрэгтэй гэж бодож байгаа. Учир юу юм бэ гэхээр өнөөдөр Улаанбаатар хотод иргэдээ газартай болох энэ ажлыг дахин зөвөөр зохион байгуулах шаардлагатай байгаа юм аа. Улаанбаатар хотын олон иргэд ийм саналтай байгаа юм билээ.

Тийм учраас цахимаар хуулийн хүрээнд хамгийн зөв энэ газар өмчлөлийн ажлыг дахин эхлүүлэх, эхлүүлэх нь зөв гэж би хувьдаа үзэж байна аа. Хамгийн сүүлд хэлэхэд Улаанбаатар хот бүтцийн хувьд өөрчлөлт хийх хэрэгтэй. Хотын ерөнхий төлөвлөгөө бүх төлөвлөлтийг баталж өгдөг хүн бол ямар нэгэн Засаг дарга томилдог биш, мэргэжлийн байгууллага нь томилдог мэргэжлийн хот төлөвлөгчдийн холбоо нь томилдог ийм томилгоотой болж байж хотын төлөвлөгөөг цааш нь зөв хэрэгжүүлэх ийм нөхцөл боломж үүснэ ээ гэж бодож байгаа.

Хоёрдугаарт Улаанбаатар хот анх удаагаа явган болон дугуйн замын дэд бүтцийн газрыг нэмж байгуулах шаардлагатай. Ингэснээр Улсын Их Хурлын гишүүдийн иргэдийн санаа зовоод байгаа явган зорчигч, дугуйн зорчигч бусад зорчигчдын эрх ашгийг хамгийн түрүүнд хамгаалах ийм боломж бүрдэнэ гэж би хувьдаа үзэж байна аа. Улаанбаатар хотын 2040 гэдэг төлөвлөгөө бол Монгол Улсын эдийн засгийг дахин шинээр том эргэлтэд оруулах маш том төсөл хөтөлбөр болсон гэж би хувь хүнийхээ үзэж байна. 2040-ийг боловсруулсан нийт ажлын хэсэгт баярлаж байгаагаа илэрхийлье. 2040-д Улаанбаатар хотын өрх айл болгоноос нэмж саналыг нь авч хийх ажлыг дахин эрэмбэлэх нь зүйтэй гэдэг саналыг хэлье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар нийслэл Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Санал хураалт.

1.Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

64.3 хувиар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Ажлын хэсэгт талархал дэвшүүлье ээ.

Дараагийн асуудалд оръё. “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбогдуулан Засгийн газар 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ доод хэмжээг шинэчлэн тогтоож 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх албан хаагчдын цалингийн нэмэгдэл шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосонтой холбогдуулан Улсын Их Хурлаас цалингийн хэмжээг тогтоодог Үндсэн хуулийн цэц, Ерөнхий прокурорын газар, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газраас саналаа ирүүлснийг үндэслэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг заасныг баримтлан “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт энэ хуулийн 45.1-д зааснаас бусад асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид тухайлан заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж 45.5 дахь хэсэгт Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах асуудлыг энэ хуулийн 45.2, 45.3, 45.4-д заасан журмын дагуу хэлэлцэнэ гэж тус тус заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тус тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа төрийн байгууллагуудын цалингийн асуудлыг тоон дүнгээр биш дүйцүүлэх байдлаар уян хатан тогтоох, цалингийн тогтолцооны шинэчлэлийг хийж холбогдох хууль тогтоомжид зохих өөрчлөлт өөрчлөлтийг оруулах нь зүйтэй талаар санал илэрхийлсэн болно оо.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд

тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

6 гишүүнээр тасаллаа. Буланы Бейсен гишүүн асуулт асууна, үг хэлнэ. Бейсен гишүүний микрофоныг өгье.

Б.Бейсен: Энэ зарим салбарын ажилчдын цалин нэмэх асуудал орж ирж байна л даа. Энэ эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмэх талаар оруулахгүй юм уу? Цалин бага ажиллах хүч нь гадагшаа гараад явж байдаг. Сувилагч эмч нар бүгдээрээ гадагшаа гараад явж байна. Үндсэн цалингийн сүлжээг 2 дахин нэмэх талын асуудал ярихгүй юм уу? Ер нь үнэхээр одоогийн инфляцын нэмэгдэл нөгөө талаар өргөн хэрэглээний барааны үнийн нэмэгдэлтэй холбоотой эрүүл мэндийн салбарын ажилчдын цалингийн хүрэлцээ амьдралдаа хүрэхгүй байгаа энэ талаар ямар бодолтой байгаа бол энэ талаар асууя.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүний асуултад хэн хариулах вэ?

Ёс зүй, дэгийн байнгын хороон дарга Баярмагнайн Баярбаатар хариулт өгье.

Б.Баярбаатар: Манай Байнгын хороон дарга байхгүй учраас би өмнөөс нь хариулчихъя. Төрийн албан хаагчдын цалин бол нөгөө хуулийнхаа дагуу 6 хувиар нэмэгд л явж байгаа. энэ нөгөө Их хурлаас нөгөө цалинг нь тогтоож өгдөг хуульчилсан буюу Их Хурлаар нөгөө цалинг нь тогтоож өгөх тэр аудит эд нар гэсэн энэ байгууллагын цалингийн асуудал орж ирж байгаа шүү. Би сая тэр тэрнээс нийт төрийн албан хаагчид гэж хамруулах нь буруу.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ 6 хувийн нэмэгдэл гэдэг чинь 30 жил ажиллаж байсан улсууд чинь сая 700 мянга л авч байгаа шүү дээ. Халаалт цахилгаан, тэгээд өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэн. Одоо ер нь эрүүл мэндийн салбарын ажилчид ер нь ажиллах нөхцөл тун муу байгаа. Энийг ер нь нэмэхгүй эмнэлгүүдээр сувилагчийн хомсдолд орчихсон, гадагшаа гараад явж байна. Эмч нар мөн адилхан, ажил нь хүнд.

Тийм учраас энэ талаар ер нь цаашдаа баримтлах бодлого хэдийд нэмэх вэ? 6 хувийн нэмэгдэл чинь бараг саяын цахилгаан дулаан цэвэр бохир усны нэмэгдсэнтэй харьцуулж бодоход ерөөсөө юу ч биш байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярбаатар: Тэгээд Бейсен гишүүн ээ таны ярьж байгаа санал зөв. Тэгэхдээ өнөөдрийн бид нарын нөгөө хэлэлцэж байгаа холбоотой асуудал биш. Бид нар нөгөө яг Их Хурлаас цалинг нь тогтоодог байгууллагын цалингийн асуудлыг ярьж байгаа. 6 хувийг мэдээж чамлалттай гэж хүн болгон бодох байх. Тэрийг бол бид нар нэмэгдүүлэхийн тулд төсөв тэгээд дагасан хуулиуд гээд энэ зүйлүүд дээрээ ярих боломжтой байгаа биз.

Д.Амарбаясгалан: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Надад 2 асуулт байна аа. Тэгэхээр Улсын Их Хурлын харьяа байгууллага, төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, АТГ-ын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон 6 хувийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосон байдлаар оруулж ирж байна. Тэгэхээр энэ бол зөвхөн 6 хувийн нэмэгдэлтэй холбоотой биш би нэг зүйлийг тодруулах гээд байгаа нь 2 байгууллагын албан хаагчдын удирдах болон гүйцэтгэх туслах ажилтан албан хаагчдын цалингийн зөрөө хоорондоо сая 200 мянган төгрөгөөр хоорондоо ялгаатай байгаад байх юм. Өөрөөр хэлэх юм бол АТГ-ын даргын цалин 5 сая 58 мянган төгрөг бол тэргүүн аудиторын цалин 3 сая 790 мянган төгрөг байх жишээтэй. Ингээд энэ аль аль нь л хяналт шалгалтыг хэрэгжүүлж байдаг байгууллагууд. Магадгүй ажлынх нь ачааллынх нь хувьд өшөө олон байгууллагуудтай харьцаж арай илүү өргөн далайцтай үйл ажиллагаа явуулдгийнх нь хувьд магадгүй төрийн аудитын байгууллагын ажлын ачаалал их байдаг байх талтай. Гэтэл энд цалин нь харьцангуй нөгөө АТГ-тай харьцуулахад цалин нь арай багаар тогтоогдсон байгаад байгаагийн учир шалтгаан нь юу юм бэ гэж асуумаар байна.

Хоёр дахь асуулт нь 2 байгууллагын АТГ-ын даргын цалин туслах ажилтныхаа цалингаас 2 сая 800 мянган төгрөгөөр их өөрөөр хэлэх юм бол босоо хамгийн өндөр цалин хамгийн бага цалин 2-ыг хооронд нь харьцуулахад 2 сая 800 мянган төгрөгийн зөрөөтэй байж байдаг. Гэтэл аудитын байгууллагын хамгийн өндөр цалин хамгийн бага цалин 2-ыг хооронд нь харьцуулаад үзэх юм 1 сая төгрөгийн зөрөөтэй байгаад байна. Өөрөөр хэлэх юм бол төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалин дэндүү их шахагдсан ийм байгаад байгаа юм биш үү. Өөрөөр хэлэх юм бол энэ аудитын байгууллагад албан тушаалын цалин нь хэр бодитой тогтоогдсон юм бэ? Албан тушаал ахих болгонд цалин нэмэгдэх байдал нь энэ хүмүүсийн мотивацыг бий болгох ийм боломжтой байна уу үгүй юу гэдгийг би тодруулж асуумаар байна аа.

Д.Амарбаясгалан: Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярбаатар: Хэрлэн гишүүний хэлж байгаа саналтай санал нэг байгаа юм аа. Ер нь цаашдаа бид нар энэ цалинг дүйцүүлэх энэ хэмжээг ойртуулах ийм зайлшгүй шаардлага бол байгаа 1 дүгээрт.

Хоёрдугаарт 2 байгууллагын биш энэ 4 байгууллагын цалингийн асуудал байгаа шүү. Прокурор, Үндсэн хуулийн цэц 2 бас таны хэлсэн дээр байгаа.

Гуравдугаарт бол өөрсдийнх нь ирүүлсэн саналыг үндэслэж өнөөдөр бид нар Байнгын хороо хуралдаж дүгнэлт үйлдэж, Улсын Их Хурлаар энэ цалинг шинэчлэн тогтоож байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Би нөгөө Их Хурлаас тогтоож байгаа байгууллагууд учраас Хүний эрхийн Үндэсний Комисс яагаад ороогүй юм бэ л гэж тодруулах гээд байгаа юм. Дээрээс нь Хүний эрхийн Үндэсний Комисс дандаа ийм тогтоолуудын хойно үлддэг. Тэгээд дандаа жилийн дараа, хагас жилийн дараа яг ХЭҮК-ын цалин орж ирдэг. Хүний эрхийн Үндэсний Комисс, Сонгуулийн ерөнхий хороо гээд ер нь Их Хурлаас цалинг нь тогтоодог хэд хэдэн тогтолцооны байгууллагууд байгаа. Тэгэхээр энэ нь ингээд хамтдаа явдаггүй юм уу гэдэг дээр л тодруулах гээд байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярбаатар: Энэ дээр жишээлбэл Их Хурлын дэргэдэх, Их Хурлаас томилдог энэ байгууллагууд дээр санал ирэх ёстой. Хүний эрхийн комиссоос санал нь ирээгүй. Прокурор, Авлигатай тэмцэх газар, Үндсэн хуулийн цэц, Аудит гэсэн 4 байгууллагын санал ирсний үндсэн дээр өнөөдөр энэ асуудлыг хэлэлцэж байгаа. Цаашлаад бол Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүгч бус гишүүн, Шүүгчийн сахилгын хорооны дарга эд нараас бас санал ирэх ёстой юм. Тэгээд тэр үед нь бас Хүний эрхийн комисс хамтатгаад орох болов уу гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

48 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хэн горимын санал гаргаж байна? Пүрэвжавын Сайнзориг гишүүн горимын санал.

П.Сайнзориг: Дарга энэ нөгөө бас нөгөө жоохон хурууны сөртгөрөөс болоод танигдахгүй техникийн юм болчихлоо. Энэ арьс сөртийчхөөд. Тэгээд бас энэ 12 секундээ бас амжиж жоохон болохгүй байгаад байна шүү. Тэгээд горимын санал гаргаж байна аа. Өмнөх саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье дарга аа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар нэг санал хураалгая. Горимын санал дэмжигдэхгүй бол тогтоолын төслийг буцаах тогтоолын төслийг Тамгын газраас авчирч бэлдээрэй. Сайнзориг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа.

55.1 хувиар санал дэмжигдлээ.

Тэгээд гишүүд бас анхааралтай саналаа өгч байхгүй бол Улсын Их Хурал дахин дахин нэг асуудлаар санал хурааж байгаа гэж олон нийтээс бас шүүмжлэл ирдгийг бас бүгд анхаарч байх хэрэгтэй.

Ингээд Байнгын хорооны саналаар зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогт тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

55.1 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

15.16 цагт

Дараагийн асуудалд оръё. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ. Тус байнгын хороо яаралтай хэлэлцүүлэх горимоор 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоолын төслийг хэлэлцэх үед төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс нь эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх талаар горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Цэгмэдийн Цэрэндорж ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга, Дамбын Нямдэлгэр ЗГХЭГ-ын Засгийн газрын референт, Цогтын Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хотын бүтээн байгуулалт хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч, Бэгзсүрэнгийн Мөнх-Оргил Шадар сайдын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух ёстой гишүүдээс урьдчилж нэр ирээгүй байна.

Байнгын хорооноос Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн ийм саналын томьёоллоор санал хураалт явагдана.

Энэ дэмжигдсэн тохиолдолд эцэслэн батлах санал хураалт. 64 гишүүнээр батлагдана. Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урья. Анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

58.2 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна аа.

Эцэслэн батлуулах хуулийн төслүүдийн хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Санал хураалт.

Ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулаад үзээдэхье.

Санал хураалт.

Бүртгэлийн санал хураалтад орж чадаагүй гишүүд хэд байгаа юм.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

66.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

62 гишүүнээр санал дэмжигдсэнгүй.

Гомбын Ганбаатар гишүүн горимын санал.

Г.Ганбаатар: Санал хураалгах төхөөрөмж бас болсонгүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү?

Д.Амарбаясгалан: Яая гэгчхэв тэгээд? Горимын санал. Санал хураалтыг хүчингүй болгох юм уу? Ганбаатар гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

67.3 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалтыг дахин явуулъя.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

72.4 хувиар, 71 гишүүнээр санал дэмжигдлээ

4.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

70 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

5.“Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

6.“Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

73 гишүүн буюу 74.5 хувиар санал дэмжигдлээ.

7.“Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

8.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

9.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

71 гишүүн буюу 72.4 хувиар санал дэмжигдлээ.

10. “Монгол улсын хөгжлийн 2020-2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

73 гишүүн буюу 74.5 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүд батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

15.26 цагт

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын эрдэнэсийн сангийн орлого зарлагын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглавар батлах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа. Би зүгээр нэг ийм хууль зүйн техникийн ийм боломжийг хэлэх гэсэн юм аа. Нэг ийм зүйл байдаг юм. Ер нь зүгээр чуулгануудаар асар их хуулиуд баталж байна тогтворгүй байна гээд байдаг. Ихэнхдээ үзэл баримтлалтай гэдэг юм уу бие даасан үзэл баримтлалтай 10-аад л хуулийг бид нар баталж байгаа шүү дээ.

Харин дагаж гарч байгаа хуулиуд нь ихэнх нь нэр томъёо солих төдий байгаад байгаа юм. Тэгэхээр энэ Хууль тогтоомжийн тухай хуульд 23 оны 5 дугаар сард орсон өөрчлөлтөөр 30.8 дугаар заалт дээр хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд заасан ижил нэр, томъёог дагаж өөрчлөх шаардлагатай бол ижил утгаар ойлгож хэрэглэх тайлбарыг хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт тусгаж болно гэж байгаа юм. Тэгэхээр шинэ Хархорум гэдэг үгийг солихын тулд зөндөө олон тогтоол болон хуулиудад өөрчлөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр өмнөх батлагдсан хуулиудад угаасаа агуулга нь өөрөөр батлагдаагүй үед Хархорум хотын хуулийг батлахдаа өмнө нь батлагдсан хуулиудаа л хэрэглэсэн Шинэ Хархорум гэдгийг Хархорум гэдгээр ойлгоно гээд ганцхан өгүүлбэрийг дагаж мөрдөх журмын хуульд хийгээд энэ хууль зүйн техникээ бид нар шийдэж болж байгаа юм. Ингэж байж бас хийхгүй болохоороо 200 хууль баталлаа гээд байдаг. Яг эцсийн дүндээ дандаа нэр томъёо сольсон олон хуулиуд батлагдахаар иргэд олон нийт бас л ингээд хууль тогтворгүй байна гэдэг зүйл яриад байгаа юм. Тэгээд энийг бас Ерөнхий сайд бас чиглэсний дагуу энэ хууль зүйн техникээр бид хэд янзлах гэж оролдож хийсэн. Энийг дараа нь нэг жоохон практикт оруулж ирж хэрэглэж байгаач ээ гэдэг зүйлийг би энэ Хархорумын хууль дээр зүгээр хэлж байгаа юм аа.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

4.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.“Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.“Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.“Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8.“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд.

9.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан:

“Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Тогтоолын төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нэг эцсийн найруулга орхигдсон байна. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд дагалдан гарсан

“Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд өнөөдөр нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудал дуусаж байна.

Чуулганы хаалтын үйл ажиллагаа эхлүүлье ээ.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан парламентын анхны намрын ээлжит чуулган Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу 81 өдөр чуулж бие даасан хууль 8 хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, 29 олон улсын гэрээ, конвенц, хэлэлцээр, соёрхон батлах тухай хууль 7, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 8, нийт 52 хууль, Улсын Их Хурлын 57 тогтоол хэлэлцэн баталлаа.

Энэ хугацаанд БНУ-ыг тунхаглаж анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулсны зэрэгцээ нэгдсэн хуралдаан 32 удаа, Байнгын хорооны хуралдаан 146 удаа, дэд хорооны хуралдаан 6 удаа тус тус хийжээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүд багагүй цаг хугацаагаа ажлын хэсгүүдийн хуралдаан, хэлэлцүүлэгт оролцох, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцах ажилд зарцууллаа. Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 60 гаруй ажлын хэсэг давхардсан тоогоор 90 гаруй удаа хуралдсан байна. Эдгээр ажлын хэсгүүд өнөөдөр эрх зүйн шийдэл нь хүлээгдэж байгаа болон цаг үеийн шаардлагад нийцүүлэн зохицуулалтыг зайлшгүй боловсронгуй болгох шаардлагатай асуудлаар байгуулагдан ажиллаж байна.

Тухайлбал Хууль тогтоомжийн тухай хуулийг сайжруулах хууль ба журмын зохист харьцааг хангах эрх зүйн үндсийг бүрдүүлэх эрчим хүчний салбарын эрх зүйн шинэтгэл хийх ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих эрх зүйн орчныг бүрдүүлэх Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийг боловсронгуй болгох, төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмын хүрээнд холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мопед, скүүтерийн хэрэглээг нарийвчлан зохицуулах, электрон тамхины хэрэгцээг зохицуулах, Тамхины хяналтын хууль, тогтоомжийг сайжруулах, Эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйлчилгээ, эм, хүнс, боловсролын зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах зэрэг нийгэм эдийн засгийн олон асуудлыг хөндөж байгаа юм аа.

Ажлын хэсгийн эхний үр дүнгүүд гарч байна. 2024-2028 оны Стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг товлосон цаг хугацаандаа төслийг өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг баталлаа. Ийнхүү Улсын Их Хурал нэгэн бүрэн эрхийн хугацаандаа баримтлах хүн төвт хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн үзэл санаа бүхий алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлээ нэгтгэн тодорхойллоо.

Стратеги төлөвлөгөө нь 4 жилийн үйл ажиллагаагаа урьдчилан төлөвлөж хүрэх үр дүнгээ тодорхой тусгасан байгаа нь парламент төлөөллийн байгууллагын хувьд үр дүнд чиглэх хариуцан тайлагнадаг байх зарчим бодитой хэрэгжихэд ач холбогдолтой юм аа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлээд байна аа. Энэ төсөл нь хууль ба журмын зохист харьцааг хангах, журмын тоог цөөлөх, журам батлах эрх олгосон зохицуулалтад тавигдах шаардлагыг өндөрсгөх, хуулийн төсөлд хүний эрх эрх чөлөөг хангах чиглэлээр дүгнэлт гаргадаг болох зэрэг иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хуульд нийцээгүй журмуудыг хүчингүй болгох, эрх зүйн үндсийг бий болгоход чиглэж байна аа. Тиймээс хаврын чуулганаар энэ хуулийн төслийг нухацтай хэлэлцэж, цаг алдахгүй батлан мөрдүүлэх ажил биднийг хүлээж байна аа.

Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн хэмээн тунхагласан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална хэмээн заасан байдаг. Үндсэн хуулийн эдгээр

заалтын агуулгыг бүрэн утгаар хэрэгжүүлж Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлтөд тусгагдсан сонгуулийн холимог тогтолцоо нь төлөөлөх чадварыг өргөжүүлэх замаар парламентын дархлааг бэхжүүлэхийг зорьсон. Энэ зорилго хэрэгжиж та бүхэн ард түмэн, нутаг дэвсгэр, нас хүйс, ажил мэргэжлийн салбарын төлөөлөл болон сонгогдож, 126 гишүүнтэй парламентыг бүрдүүлсэн. Энэ бол зөвхөн нэг тооны тооны төдий өөрчлөлт биш ээ. Энэ бол өнгөрсөн 30 гаруй жилийн туршлага сургамжаа цэгнэн дүгнэсний үндсэн дээр эхлүүлсэн засаглалын тогтолцооны шинэтгэлийн нэгэн үр дүн юм аа. Тиймээс 126 гишүүнтэй болсны утга учир, ач холбогдол, зөв сайн үр дүнг батлах, харуулах, эх орноо сэргээн мандуулах эрхэм зорилго зөв замд ухралт буцалтгүй оржээ гэсэн итгэл үнэмшлийг бий болгох нь энд суугаа гишүүд бидэнд ноогдож буй эрхэм үүрэг гүн хариуцлага юм аа.

Чухам үүний төлөө энэ Улсын Их Хурал энэ парламентын гишүүд ажиллана гэдэгт итгэлтэй байна. Улсын Их Хурлын намрын чуулган ирэх оныхоо улсын төсвийг хэлэлцэн баталдаг нь хуулиар тогтоосон үүрэг юм аа. Гэхдээ 126 гишүүнтэй парламентын намрын чуулган өмнөх намрын чуулгануудын хэвшмэл жишгийг өөрчилж чадсан гэж үзэж байна. Сүүлийн 10 жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын өсөлтийн хувь ойролцоо байгаа боловч ДНБ-д эзлэх зарлагын хувь нь орлогоосоо дунджаар 4 функтээр илүү байсаар ирсэн. Улмаар алдагдлыг өр зээлээр нөхөх замаар шийдвэрлэж тухайн жилд авсан зээлийн заримыг өмнөх зээлээ төлөхөд үлдсэн хэсгийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсаар байсан. Манай улсын Засгийн газрын нийт өр 2024 оны байдлаар 35.2 их наяд төгрөг байсан бол 2025 оны төсвийн төсөлд энэ өр даруй 5 их наядаар нэмэгдэхээр орж ирсэн. Засгийн газрын өр сүүлийн 15 жилд буурах биш байнга өссөн. 2010 оноос хойш жил бүр дунджаар 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн гэсэн статистик үзүүлэлт бий.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны улсын төсөвт бүхэлд нь тавьсан хориг нь төсвийг эргэн харах нөхцөл бүрдүүлсний зэрэгцээ төсөв хэлэлцэх дэгийг цаашид сайжруулах шаардлагатай байгааг мөн харууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийг хэлэлцэх дэгийн тухай нэг удаагийн хуулийг хэлэлцэн баталж улсын төсвийг өргөн мэдүүлэх хэлэлцэх, батлах хугацааг тусгай дэг дэгээр зохицууллаа. Төсвийг дахин хэлэлцсэнээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувьд хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж суурь тэнцэл ДНБ-ий 3.3 хувийн ашигтай байх төсвийг баталсан. Төсвийн хүрээнд орон нутаг руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх зарчмыг баримталсан бөгөөд Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтцийн шинж чанартай хөрөнгө оруулалтуудыг чухалчилснаар эдийн засаг 8 хувь өсөхөөр төсөөлж байна.

Цар тахлын хүндрэлтэй үеийг бид шуурхай арга хэмжээ авч өндөр зохион байгуулалттайгаар тууштай бодлого хэрэгжүүлсний үр дүнд амжилттай даван туулсан. Мөн геополитикийн хурцадмал тодорхойгүй байдлыг ч зөв бодлогын үр дүнд сөрөн өнөөдөр эдийн засаг маань сэргэж байна аа. Үр дүнд нь эдийн засгийн өсөлт 2024 оны жилийн эцсийн байдлаар 5 хувь руу дөхөж гарахаар байна. Зөв бодлогын хажуугаар түүхий эдийн үнэ гадаад дотоод эрэлт өсөлтөд нөлөөлсөн гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

Хүрсэн үр дүн эдийн засгийн энэ сэргэлтийг хадгалж цаашид тогтвортой авч явах нь бидний үндсэн зорилго байх ёстой.

Эрхэм гишүүд та бүхэн намрын чуулган эхлэх үеийн макро эдийн засгийн тоон үзүүлэлтүүдийг сануулъя аа. Эдийн засгийн өсөлт 5 хувьтай, үүнээс ХАА-н салбар 3.5 хувийн агшилттай, уул уурхайн салбарын өсөлт 1.5 хувь болж нэрлэсэн ДНБ 56 их наяд төгрөг хүрсэн байсан, инфляц 6.7 хувьтай гадаад худалдааны тэнцэл 3.2 тэрбум ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцэл 250 сая гаруй ам.долларын алдагдалтай гадаад валютын нөөц 4.7 тэрбум ам.долларт хүрсэн байсан. 2024 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар төсвийн орлого 22.8 их наяд, зарлага 20 их наяд, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1.5 их наяд, банкны салбарын нийт зээл 35 орчим их наяд төгрөгт хүрсэн. Эдийн засгийн ийм орчинд Улсын Их Хурал 2025 оны төсвийн болон мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслүүдийг хэлэлцэж эхэлсэн. Эдгээр тоо баримтыг дурддаг нь Улсын Их Хурлаас гарсан аливаа шийдвэр хууль тогтоомж ард иргэдийн амьдралд ямар нэгэн байдлаар эерэг нөлөө үзүүлсэн байх ёстой гэдгийг сануулах зорилгоор дахин давтан сануулж байна. Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2025 оны төсвийн төсөл хэрэгжүүлэхээр зорьж байгаа мега төслүүд нь улс орны хөгжлийг шинэ шатад гаргана гэсэн том зорилго тээсэн хөгжлийн бичиг баримт байсан. Улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд аж үйлдвэржилтийн үндсэн суурь болсон эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтууд зэрэг том бүтээн байгуулалтууд багтсан алсыг харсан шийдлүүд үүнд багтсан байсныг хэлэх нь зүйтэй.

Улсын Их Хурлын зүгээс аливаа хөгжлийг түүчээлэх эдийн засагт бүтцийн шинж чанартай өөрчлөлтүүдийг бий болгох төсөл хөтөлбөрүүдийг дэмжих нь бидний үүрэг юм аа. Гэхдээ энэхүү үүрэгтэй зэрэгцээд өнөөдөр ард иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг санаж бодит орлогыг нь өсгөх ирээдүйгээ харсан зарчмын шийдвэрүүдийг гаргах нь манай парламентын үйл ажиллагааны үндсэн чиг шугам байх ёстой.

Эрхэм гишүүд ээ,

Энэ намрын чуулганаар бид Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг баталсан. Эдгээр бодлогын баримт бичгүүдэд эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор инфляцыг 6+-2 хувь тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ гэж заасан. 2023 оны жилийн эцэст инфляц 7.9 хувь байсан бол 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 9 орчим хувьтай байхаар байна аа. Бид инфляцыг нэг оронтой тоонд барих зорилтоо 2023 онд биелүүлж чадсан. Гэхдээ 9 гэдэг бол 2 оронтой тоо руу шилжихэд ганцхан алхмын зайд байна гэсэн үг. Өндөр инфляц ханшийн уналт гэсэн таагүй үзэгдлүүд нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж салшгүй хамт явдаг жамтай. Төсөв алдагдалтай байх нь инфляц өсөх таатай хөрс болж өгдөг. Тиймээс инфляцыг 6 хувь-аас хэтрүүлэхгүй байх нь гарцаагүй чухал зорилт юм аа. Гадаад валютын улсын нөөцийн хэмжээ 2024 оны эцсийн байдлаар 5.5 тэрбум ам.долларт хүрч валютын төлбөртэй барааны импортын 5.7 сарын хэрэгцээг бараа болон үйлчилгээний импортын 4 сарын хэрэгцээг тус тус хангах түвшинд байна аа.

Цаашид банк санхүүгийн салбарын зээлийн мэдээлэлтэй холбоотой эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгоход Улсын Их Хурал анхаарлаа хандуулах ёстой. Цаг үеийн ээдрээтэй нөхцөлөөс үүссэн эдийн засгийн хүндрэлийг даван туулж сэргэсэн санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтийн эерэг үр дүнг дунд хугацаанд тогтвортой хадгалж хөгжлийн бодлого ард түмний амьжиргааны өсөлтөд тууштай

чиглүүлэх нь бидний нэн тэргүүнд зорилт байсаар байх болно. Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 14 мега төсөл тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийг хэрэгжүүлж салбарын реформуудыг хөшүүрэгдэх цогц асуудал, түүний шалгуур үзүүлэлт, шаардагдах санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэр, хариуцагч байгууллагуудыг тусгаж баталсан.

Сүүлийн 30 гаруй жил ярьсан ч амьдралд бодит биеллээ олоогүй гацсан төслүүдийг гацаанаас гаргаж хөгжил дэвшлийг туршсан чөдрийг тайлах эхний алхмуудыг Улсын Их Хурал энэ удаагийн чуулганаараа хийж чадлаа.

Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал улс эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө хамтарсан засгийн газраа бүрэн дэмжиж дээр дурдсан мега төслүүдийг хөдөлгөхөд онцгой анхаарч ажиллалаа. Цаашид энэхүү төсөл хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж Засгийн газраас үр дүн шаардаж ажиллах ёстой. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолыг та бид сар хүрэхгүй хугацааны өмнө баталж, 12 үндсэн чиглэл баримталж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх замаар хөгжлийг хурдасгах Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хөрш орнууд болон гуравдагч хөршүүд олон улсын байгууллагуудтай хийх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж парламентын зөвшилцлөөр үр дүнд хүргэж чадсан нь онцгой ач холбогдолтой шийдвэрүүд байсан. Зөвхөн төмөр замын бүтээн байгуулалт амжилттай хэрэгжсэнээр Гашуун сухайт-Ганц мод, Ханги Мандал-Шивээ хүрэн, Сэхээ, Бичигт, Зүүн хатавч боомтын хил дамнасан холболтын төмөр зам ачаа тээврийн терминал ашиглалтад орж Монгол Улсын экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэнэ ээ.

Төр хувийн хэвшлийн түншлэл бусад эх үүсвэрээр хийгдэх томоохон төслүүд болох 1.2 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий Эрдэнэбүрэнгийн УЦС-ын бүтээн байгуулалтаар 366 сая квт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж баруун бүсийн аймгуудын цахилгаан эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэнэ ээ. Монгол Францын хамтарсан уран үйлдвэрлэлийн төсөл хэрэгжсэнээр жилд 2500 тонн уран экспортолж төсөл хэрэгжих хугацаанд улсын болон орон нутгийн төсөвт 5.2 тэрбум доллар төвлөрөх боломж бүрдэнэ. Эдгээр төслүүд хэрэгжсэнээр хэдэн мянган шинэ ажлын байрууд бий болж тэр хэрээр Монгол айл өрх ААН-ийн орлого бодитой нэмэгдэнэ ээ.

Мөн Улаанбаатар хотын дулааны 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэтгэлийн зураг төсөл боловсруулах хэлэлцээрээр ОХУ-тай хамтарсан 20 сая ам.долларын өртгөөр Улаанбаатар хотын Дулааны 3 дугаар цахилгаан станцыг үе шаттайгаар өргөтгөн шинэчлэхээр төлөвлөж өндөр даралтын хэсгийг эхний үе шатанд 50 мвт-ын дулааны станцыг шинээр барихаар дараагийн шатанд ашиглалтын хугацаа дууссан 48 мвт-ын станцыг буулган суурин дээр нь 250 мвт-ын дулааны станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах хүрээнд инженерийн судалгаа шинжилгээ явуулах ажлын ерөнхий нөхцөлийг тодорхойлж төслийг нэг алхам урагшлууллаа. Ингэснээр нийслэл хотын төв төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлж шинээр дулаан цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах нөхцөл бүрдэх юм аа.

Эдгээр төслүүд нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлэх төдийгүй улс төр геополитикийн хувьд өндөр ач холбогдолтой бөгөөд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн 5 улсын 3 улстай эдийн засгийн салбарт нягт хамтын ажиллагаа өрнүүлэх нь Монгол Улсын цаашдын хөгжил үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой. Иймд эдгээр томоохон төслүүдийн олон талын ач холбогдлыг үнэлж удаан хугацаанд гацаанд байсан төслүүдийг хурдтай чанартай хэрэгжүүлэх нь бидний өмнө тавигдаж буй түүхэн үүрэг бөгөөд энэ нь улсын эдийн засгийн тогтвортой өсөлт хөгжлийг хангахад чухал ач холбогдолтой юм аа.

Үр дүнд нь өнөөдөр 2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр гарч байгаа 4.7-5 орчим хувийн эдийн засгийн өсөлт, нэг хүнд оногдох ДНБ 6700 ам.долларт хүрч 5.5 тэрбум ам.доллар давсан гадаад валютын нөөц зургаа орчим хувьтай байгаа ажилгүйдлийн түвшин, 600 орчим сая ам.долларын ашигтай гарч байгаа төлбөрийн тэнцэл зэрэг макро эдийн засгийн суурь тоон үзүүлэлтүүд дунд хугацаандаа сайжрах суурь хөрс нь бий боллоо. Ингэснээр Монголчууд бидний амьдралын чанар сайжирч өдөр тутмын асуудлууд гэхээсээ илүүтэй ирээдүй рүүгээ харж, төлөвлөсөн, өөдрөг, эерэг нөхцөл байдал бүрдэх бүрэн боломж нээгдлээ. Хууль гаргах төрийн бодлогыг тодорхойлох нь бидний зорьж буй хөгжлийн шинэ ирээдүйг эрх зүйгээр дэмжих үйл ажиллагааны зөвхөн эхлэл юм аа.

Нэгэнт батлан гаргасан хууль, төрийн бодлогыг тууштай, тогтвортой мөрдүүлэх, олон түмэнд зөв ойлгуулж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоо үр дүнд хүргэх нь парламентын үйл ажиллагааны нэг чухал тулгуур юм аа. Тиймээс Улсын Их Хурал хяналтын үндсэн чиг үүрэгтэй онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой. Түүнчлэн бид энэ удаагийн чуулганаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хархорум хотыг дахин сэргээх орчин цагийн хот болгон сүндэрлүүлэх идэвх их бүтээн байгуулалтыг хийж эхлэх эртний түүхт нийслэл хотоо сэргээн байгуулах, оновчтой төлөвлөх, төлөвлөлтдөө нийцсэн хотыг бүтээн байгуулах эрх зүйн зохицуулалтыг мөн баталж чадсан. Энэ чуулганаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг батлан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах үр дагаварт үнэлгээ хийх, тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх зэрэг 17 чиглэлээр хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлж ажиллалаа.

Энэ хүрээнд эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хяналтын сонсголыг 37 төрийн байгууллага, 87 иргэн, хуулийн этгээд, 2 ажиглагчийг оролцуулан зохион байгууллаа. Түүнчлэн 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ахмад настны нийгмийн хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох хүрээнд ахмадын үндэсний чуулганыг Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Уг чуулганд Монгол Улсын өнцөг булан бүрээс ирсэн ахмадын мянга гаруй төлөөлөл оролцсон. Ахмадын амьдралын чанарыг дээшлүүлэх нийгмийн оролцоог дэмжих асуудал төрийн бодлогын төвд байсаар ирсэн. Дундаж тэтгэврийн хэмжээ 2016 онд 285.2 мянган төгрөг байсан бол 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 848 мянган төгрөг болсон. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар ийнхүү инфляцын түвшинтэй холбогдуулж тэтгэврийг 6 хувь нэмсэн шийдвэр гарсан.

Үүний дүнд ахмад настны тэтгэврийн худалдан авах чадвар буурахгүй байх нөхцөл боломж нь бүрдэж байгаа төдийгүй инфляцын түвшинтэй уялдаж тэтгэвэр нэмэгдэж байх тогтолцоонд шилжиж байгаа юм.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд хуульд хууль тогтоох эрх мэдэл гагцхүү Улсын Их Хуралд хадгалагдана хэмээн заасан. Тиймээс хууль тогтоох үйл ажиллагаагаа илүү чанартай, үндэслэл гаргалгаа сайтай, судалгаа шинжилгээ, шинжлэх ухаанч хандлагад суурилсан гарцаагүй шийдлээ хүлээсэн асуудал харилцааг оновчтой олж тодорхойлсон байх ёстой.

9 дэх удаагийн парламентын баталсан стратеги төлөвлөгөө 3 төгөлдөршлийн нэг үндсэн чиглэл чухамхүү үүнд чиглэж байна аа. Тиймээс ажлын хэсгүүд ажлаа ул улам эрчимжүүлж тогтоосон хугацаанд санал, дүгнэлтээ танилцуулах шаардлагатай байгааг мөн энд онцлон тэмдэглэж хэлье ээ. Ирэх хаврын чуулганаар хүн төвтэй цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажлын хэсгүүдийн санал, дүгнэлт боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэх болно оо.

Дэлхийн нийт түүний дотор Монголчууд бид шинжлэх ухаан, техник, технологийн цоо шинэ үе эрин үед амьдарч байна. Хиймэл оюун ухаан бүхий л салбарт хүч түрэн орж ирлээ. Их өгөгдлийн хэрэглээ, инновац, технологийн шинэ шийдлүүд алхам тутмын хэрэгцээ болж хувирлаа. Нийгэм эдийн засгийн үр өгөөж байгаль орчны нөлөөллийг нарийвчлан тооцоолж, төлөвлөлт, бүтээн байгуулалтын бүх үе шатад олон талын оролцоог хангах, ашиг сонирхол нь хөндөгдөх иргэд олон нийттэй нээлттэй харилцаж хүний хүний эрхийг хангасан хүн төвтэй байх стандартыг нарийн чанд мөрдөж ажиллах зэргийг тусгайлан анхаарцгаая аа.

Энэ удаагийн парламент аливаа шийдвэр гаргахдаа хүн төвт хүний эрхийг хангасан, ойлгомжтой, тодорхой цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зарчим баримтлан ажиллаж байгаа. Энэ утгаараа намрын чуулганаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн яаралтай горимоор хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурал аль болох нааштай хүлээн авч холбогдох хууль эрх зүйн орчныг цаг алдалгүй бүрдүүлэхийг эрмэлзэж ажиллалаа. Гэхдээ асуудлыг шийдэх талаас нь харж Улсын Их Хурлаар баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх нь зүйн хэрэг ч хэт цаг хугацааны шахалтад орох нь алдаа дутагдал гаргах эрсдэлтэйг тал талдаа анхаарах ёстой.

Хуулийг яаралтай горимоор хэлэлцэх заалт 2016 оноос хэрэглэх болсноос хойш 9 жилийн хугацаанд Улсын Их Хурал нийт 76 буюу жилд дунджаар 8-аас 9 хууль, тогтоолын төслийг энэ горимоор хэлэлцэж иржээ.

2016-2020 оны парламентын үед 22 хууль тогтоолын төсөл яаралтай горимоор хэлэлцэж байсан бол 2020-2024 оны парламентын үед энэ тоо 2.4 дахин өсөж, 53 хууль, тогтоолын төслийг яаралтайгаар хэлэлцсэн байна. Харин бид ээлжит бус болон энэ удаагийн намрын чуулганаар нийт 11 хууль тогтоолын төслийг яаралтай горимоор шийдвэрлэсэн байгаа нь нэг талаараа Улсын Их Хурлын гишүүд богино хугацаанд өндөр ачаалалтай ажилласныг илтгэх боловч нөгөө талаар

хэлэлцэж буй асуудалд иргэд, сонгогчдын санал бодол, мэргэжилтэн судлаачдын дуу хоолойг сонсож тусгах нөхцөл хомсдож байна.

Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд заасан ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулан иргэдийн санал бодлыг сонсож, эрх, хууль, ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудын тэгш оролцоог хангах зорилт хэрэгжих ёстой. Иймд асуудлыг бүх талаас ул суурьтай судалж танилцах олон талын оролцоог ханган хэлэлцэх нөхцөл бүрдүүлэх хангалттай цаг хугацаатай байх шаардлагатайг Засгийн газар анхаарч хууль тогтоолын төслийг аль болох энгийн горимоор хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх зарчим баримтлах нь хэрэгтэй.

Эрхэм гишүүд ээ,

Улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй ганц салбараас хэт хамааралтай хэвээр байгаа. Өсөлтийн үр шим, олсон орлого иргэдийн амьжиргаанд наалдахгүй байсаар удлаа. Үйлдвэрлэл олигтой хөгжихгүй байгаатай холбоотойгоор бид хөршийнхөө түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч импортын хараат болж хувирсан. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын бууруулах зорилт ахиц дэвшил багатай байна. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой айл өрх хүн амын тоо мэдэгдэхүйц буурсангүй. Боловсрол эрүүл мэндийн тогтолцоо бүрэн зүгшрээгүй хүртээмж нь тааруухан байсаар байна. Хөдөлмөрийг биш халамжийг шүтэх буруу хандлага бий болж хүүхдийн мөнгө тооцохгүйгээр авч үзвэл нийгмийн халамжид нийт хүн амын бараг 3-ны 1 нь хамрагдах болсон байна аа. Хот, хөдөөгийн ялгаа ихсэж, төвлөрөл нэмэгдсэн, хэт төвлөрлийг дагаад дэд бүтцийн хомсдол, түгжрэл, орчны аюулгүй байдал нэн эмзэг түвшинд байсаар байгаа. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчин нийгмийн засаглалын үр нөлөөг оновчтой зохицуулж чадахгүй байна.

Хөрөнгө оруулалтыг төдийлөн хангалттай нэмж чадахгүй байгаа зэрэг нь төр хувийн хэвшил л бодит үр дүн багатай банк санхүүгийн зах зээлийн хүртээмж тогтвортой байдалд хүссэн хэмжээнд хүрэхгүй байгаагийн илэрхийлэл юм аа. Энэ мэт хуримтлагдсан шийдлээ хүлээсэн олон асуудал бидний өмнө хүлээж байна аа. Тэдгээрийг шийдвэрлэх эрх зүйн орчинд оновчтой орчин бүрдүүлэх хөгжлөө тэтгэх, хүнээ дээдлэх, төрийн бодлогыг төлөвшүүлэх буруудсаныг засаж буруудсаныг тэгшитгэн зөв замд нь гаргах түүхэн үүрэг та биднийг хүлээж байна аа.

Баялгийн хулгай, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх шударга ёсны тэмцэл бүрэн дүүрэн үр дүнд хүрч хараахан амжаагүй байна. Энэ тэмцлийг зориудаар зогсох, гацаах, үнэгүйдүүлэх, үр дүнгүй болгож харагдуулах, илт мушгин гуйвуулах, хар мэдээллээр нийт нийгмийг сөргөлдүүлэх замаар эрх ашгаа гүйцэлдүүлэх зорилготой бүлэглэлүүдийн ил далд эсэргүүцэл илүү зохион байгуулалттай болж эрчимжиж байна аа.

Ийм үед эх орон ард түмнийхээ эрх ашгийг эн тэргүүнд эрэмбэлж ёс зүй сахилга хариуцлагыг бат журам болгон, шударга ёс, иргэнээ дээдэлсэн төр эрүүл нийгэм хөгжлөө тэтгэсэн эдийн засгийг цогцлоохын төлөө нэг зүгт харсан нэгдмэл зорилгод хүчээ нэгтгэж зүтгэх нь та бидний эрхэм журамт үүрэг байх болно.

Улс орныхоо өнөөдрийг зөв дүгнэж маргаашийн алс хэргийг олж харж аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид зөвхөн улсаа ард түмнээ бодож хичээн зүтгэцгээе ээ.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулган хаасныг мэдэгдье.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*